ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

2016. №04(20)

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛИЙН ТУСГАЙ ДУГААР

“ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ”

эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл



Улаанбаатар хот
2016 он



Г.БАТТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн магистр, хошууч

ЯЛТНУУДЫН ДУНД БҮРЭЛДЭН ТОГТСОН НИЙГЭМД ХАРШ ЗАН ҮЙЛ, ТҮҮНИЙ СӨРӨГ НӨЛӨӨ

Хураангуй: Гэмт хэрэгтнүүд ялангуяа ялтны дунд бүрэлдэн тогтсон нийгэмд харш соёл, зан үйл, түүний ойлголт, нийгэмд үзүүлэх хор нөлөө, урьдчилан сэргийлэх арга замыг судлах зорилго тавьсан болно.

Түлхүүр үг: Соёл, “өвөрмөц соёл”, шоронгийн “өвөрмөц соёл”, нийгэмд харш зан үйл,этгээд үг хэллэг, шорон судлал

Key words: Culture, subculture, prison subculture, antisocial behavior, slang, prison study/research

Үндсэн хэсэг

Хүн хүнтэйгээ харьцах харилцаа, ёс суртахуун, үзэл бодол, соёл нь нийгэм, хамт олон, гэр бүл, найз нөхдийн хүрээлэл, тэдний харилцан нөлөөллийн дунд төлөвшин тогтдог. Өөрөөр хэлбэл хувь хүний хүрээлэн буй орчин нь түүнийг төлөвшүүлж, хөгжүүлж, улмаар нийгэмд эзлэх байр суурыа олж авахад хүчтэй нөлөөлнө.

Гадны социологчид болон криминологчид нийгмийн жижиг бүлэг хэсгүүдийн дунд тогтсон үнэт зүйлс, хүсэл сонирхол, итгэл үнэмшил нь нийгмийн тодорхой хэсгийн “өвөрмөц соёл” бүрэлдэн тогтоход нөлөөлдөг гэж үздэг. Үүнийг Ангиар “Subculture” Орос хэлнээ “Субкультура” хэмээн тодорхойлсон байдаг ба барууны судлаачид шинжлэх ухааны үүднээс судлан тодорхой онол, сургааль /subculture theory/ боловсруулжээ. Харин криминологийн шинжлэх ухаанд уг онолыг авч ашиглан гэмт хэрэгтнүүдийн болон хорих ял эдэлж буй ялтнуудын дунд бүрэлдэн тогтсон, хэв шинж, нийгмийн бусад хэсэг бүлгүүдээс ялгагдах хэвшил болсон “өвөрмөц соёл” байдаг болохыг нотлон энэ талаар судалж иржээ.

Тэгвэл соёл гэж чухам юу вэ? Ямар хүчин зүйлсийн үр дүнд бүрэлддэг вэ? гэсэн асуулт зүй ёсоор урган гарна. Соёл нь “ард түмэн хойч үедээ хуримтлуулсан мэдлэгээ дамжуулан өвлүүлэх, түүндээ хойч үеэ сургах, хэвшүүлэх чадвартай холбогдсон хүний мэдлэг, итгэл үнэмшил, зан заншлын нийлбэр цогц”[1] бөгөөд соёлд “итгэл үнэмшил, нийгэмшлийн бүтэц, хэл, урлаг, шашин шүтлэг болон нийгмийн давхаргын бодит шинж чанар агуулагдаж эдгээр хүчин зүйлсийн

нөлөөгөөр тухайн нийгмийг тодорхойлохуйц нийтлэг үзэл санаа, үнэт зүйлс, зорилго, зан үйл бий болдог[2].

Германы криминологич Г.И.Шнайдер өвөрмөц соёлын талаар "нийгмийн оюун санаа, соёлын үнэт зүйлсээс тухайн хэсэг бүлгийг бүрдүүлэн бусдаас ялгаруулж буй оюун санааны болон бусад материаллаг үнэт зүйлсийн цогцыг өвөрмөц соёл хэмээн ойлгоно"[3] гэсэн тайлбарыг хийжээ.

Криминологийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл "өвөрмөц соёл" нь гэмт хэрэгтнүүдийн дунд төлөвшсөн зан чанар, орчин, нөхцлөөрөө нийгмийн бусад хэсэг бүлгээс ялгарах соёл, боловсрол, мэдлэг, зан заншил, амьдралын дадал хэвшлийн онцой ялгаа хэмээн ойлгож болох юм[4].

Эдгээрээс үзвэл соёл гэсэн ерөнхий ухагдахуун гэмт хэрэгтнүүдийн дунд бүрэлдэн тогтсон "өвөрмөц соёл"-ын аль алинд нийтлэг хэв шинж байгаа болох нь харагдана. Гэмт этгээдүүдийн дунд бүрэлдэн тогтсон "өвөрмөц соёл" нь тодорхой цаг хугацааны явцад үүсэн бий болж, өнгөрснөөс одоо, одоогоос ирээдүйд уламжлагдан хувьсаж байдаг зүй тогтолтой гэж үздэг. Энэ нь өөрийн гэсэн үнэт зүйл, хууль журам, зан заншил, амьдралын онцлог хэв маяг, хэм хэмжээ, дэглэм журам бүхий гэмт орчин буюу бидний хэлж заншсанаар гэмт хэргийн ертөнцийг бий болгож, тэр нь хувьсан өөрчлөгдөж байдаг.

Чухам яг хэдийд, ямар үед гэмт хэргийн ертөнц болон түүний уламжлал, ёс заншлууд төрөн бий болсныг хэлэхэд бэрх боловч ОХУ-ын эрдэмтэд түүхэн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж гэмт хэргийн ертөнц Оросод 17-р зууны дунд үеэс бүрэлдэн бэхжсэн гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна[5].

Улмаар ОХУ-ын судлаачид гэмт орчин үүсэн бий болсон нөхцөл байдал, гэмт зан үйл, хэвшил хэрхэн бүрэлдэж ирсэн талаарх түүхийн үйл явцыг үечлэн авч үзжээ. Ингэхдээ Хаант Орос улсаас орчин цаг хүртэл 7 үед ангилан гэмт хэргийн ертөнцийн уламжлал, ёс заншил, эрүүгийн ертөнцийн бичигдээгүй "хууль", гэмт хэв маягийн амьдралын нууц хадгалах элементүүдийн нэг, түүний хамгийн хүчтэй хэв шинж болох гэмт хэрэгтнүүдийн этгээд үг хэллэг

[1] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 2007 он. УБ хот. 389 дэх тал

[2] Мөн тэнд. 390 дэх тал

[3] Ганс Йоахим Шнайдер. Криминология. Москва. 1994. /Hans Joachim Schneider. Kriminologie. Berlin. New York. 1987/ с 284.

[4] М.Цэнд. "Криминальная субкультура" буюу " гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц зан үйлийн хэвшил"-ийн тухай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№01(13) 40 дэх тал.

[5] Пенитенциарнная криминология. Рязань. 2009 г. 160 ст

зэргийг[6] түүхчлэн судалж, тэдэнтэй хэрхэн тэмцэх арга замаа боловсруулж ирсэн байна.

Тухайлбал Оросын эрдэмтэн В.Я. Лебедев гэмт хэрэгтнүүдийн нийгмийн эсрэг үзэл санаа, уламжлал, ёс заншлыг, Н.П. Мелещко тэдний нэгдэн нягтрах үзэгдлийг, У.У. Тайбакова халаасны хулгайч нарын онцлог, заншил уламжлал, шинэ залуу үеэ хэрхэн олж, тэднийг сурган дадлагажуулах арга барил, гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц этгээд хэллэг зэргийн талаар тухайлан судалжээ[7].

Гаж үзэл бодол, хэм хэмжээ, үнэт зүйлсийн нөлөөллөөр гэмт хэргийн ертөнцийн оршин тогтнох нөхцөл бүрдэж улмаар гэмт бүлэглэлийн гишүүдийг нэгтгэж, холбож нягтруулдаг болохыг олон орны судлаачид тэмдэглэсэн байдаг.

ОХУ-н зарим судлаачид гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлан тодорхой хугацаагаар хорьж буй нь төрөөс хорих ялаар шийтгүүлэн шоронд хоригдож буй нийт ял эдлэгсэд буюу *албан бүлэг,* хорих ял эдлэх явцдаа хүсэл, сонирхол, хэрэгцээгээрээ өөр хоорондоо сайн дураараа нэгдсэн *албан бус* бүлэг /хамт олон/ гэж үндсэн хоёр хэсэгт хуваан авч үзсэн[8]. Өөрөөр хэлбэл хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог байна.

Энэхүү бичил орчинд ял эдэлж буй хүмүүсийн дунд нийгмийн нийтлэг хэм хэмжээ, хууль тогтоомжын эсрэг үзэл санаа гүн гүнзгий оршин тогтнож байдаг. Ялангуяа олон жил ял шийтгэл эдэлж буй архаг гэмт хэрэгтнүүд буюу нөлөө бүхий ялтнуудын зүгээс бусад ялтнууд, тэр дундаа залуу ялтнуудын үзэл санаанд нөлөөлж өөрсдийн мөрддөг хэм хэмжээг дагах, хорих байгууллагын зүгээс тавьдаг хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, өөрсдийгөө хүндлүүлэх, аялдан дагалдах, гэмт хэргийн замыг сонгох, ялтны бүлэглэлд татан оруулах чиглэгдсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг.

АНУ-ын судлаачид Дэвид Пируз, Меган Мичел нар ялтны гэмт бүлэглэл гэдгийг "өөрийн хүсэл сонирхол, үзэл бодол эсвэл албадлагаар нэгдсэн, тогтсон дүрэм журам зохион байгуулалт бүхий гэмт санаа бодлоо хэрэгжүүлэхэд чиглэсэн ялтнуудын нэгж юм"[9] гэж

[6] Пенитенциарнная криминология. Рязань. 2009 г. 161 ст

[7] М.Цэнд. "Криминальная субкультура" буюу " гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц зан үйлийн хэвшил"-ийн тухай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№01(13) 41 дэх тал.

[8] И.А. Уванов., Введение в пенитенциарную криминологию. Москва 2007 г. Стр 15.

[9] David Pyrooz, Meghan M. Mitchell. *Prison Gangs and Subculture (*Oxford Bibliographies) 2015.http://www.oxfordbibliographies.com/view/document/obo-9780195396607/obo-9780195396607-0168.xml#obo-9780195396607-0168-div1-0003

тодорхойлсон байна. Мэдээж ялтнуудын зарим хэсэг нь дээрх бүлэглэлд нэгдэж гэмт хэргийн замд эргэлт буцалтгүй ордог бол ихэнх хэсэг нь үүний гадна үлддэг. Гэсэн хэдийч ялтны доторхи бүлэглэл бэхжих, цуллаг байдал үүсэх нь олон төрлийн сөрөг үр дагаварыг үүсгэдэг бөгөөд тэдний дунд бүрэлдэн тогтсон "өвөрмөц соёл", нууц, далд харилцааны хэв шинж нь бусад ялтнуудад нийгэмд харш зан үйл төлөвшихөд ихээхэн нөлөө үзүүлдэг байна.

Иймд ялтнуудын дундах албан бус бүлэглэл, шоронгийн өвөрмөц соёл /prison subculture/, тэдний хоорондын харилцан хамаарал, ялтнуудын амьдралын онцгой хэв маяг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө, учруулж буй хор уршиг зэргийг нарийвчлан судалж түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замаа боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өнөөдөр нийгэмд болон судлаачдын дунд ял эдэлсэн хүмүүс засарч хүмүүжих бус харин гэмт хэрэг үйлдэх арга барилд суралцаад, шоронгийн амьдрал, соёлд дасан зохицоод гардаг гэсэн шүүмжлэл гарах болсныг үгүйсгэх аргагүй билээ. Олон улсын байгууллагын сүүлийн үед хийсэн судалгаагаар улсын хэмжээнд ял эдлэж буй нийт ялтнуудын 50.2% буюу талаас илүү хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн байна.[10]

Үүнээс үзэхэд уг асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан судалж, зүй тогтлыг нь илрүүлэх, улмаар цаашид хэрхэн тэмцэх арга замаа боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Гадны зарим орны практикаас харахад гэмт бүлэглэл, ялангуяа хорих байгууллага дахь ялтнуудын бүлэглэл, тогтсон хэв маяг,зохион байгуулалт, үнэт зүйлс, хэм хэмжээ, ёс суртахуун зэргийг тусгайлан судалж энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулж байна. Тухайлбал Англий Оксфордын их сургуулийн дэргэдэх Шорон судлалын хүрээлэн, АНУ-ын Гэмт бүлэглэл судлалын үндэсний төв, Станфордын их сургуулийн дэргэдэх шорон судлалын төв зэргийн дурдаж болох бөгөөд манай хөнш ОХУ-д шорон судлал өндөр хөгжсөн талаар дээр дурдсан.

Гэмт хэргийн ертөнцийн соёл, "ёс суртахууны" үндсийг бэхжүүлэх зорилгоор "шоронгийн хууль" гэгчийг сурталчлах, дэлгэрүүлэх талаар гэмт хэргийн ертөнцийн нөлөө бүхий этгээдүүд ихээхэн идэвхтэй ажилладаг бөгөөд ихэвчлэн залуучууд болон насан хүрээгүй хүмүүсийг дунд уг ажиллагаагаа зохион байгуулдаг байна.

[10] Present conditions of human rights in Mongolian prison. Survey report. *Caritas Czech Republic*. Ulaanbaatar.2014. p 176

Хорих ангид ялтны дунд оршин байдаг “шоронгийн хууль” (ялтнуудын дунд тогтсон үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэг өвөрмөц байдлын цогц) гэгч нь гэмт хэрэгтнүүд болон ялтнуудын дунд бүрэлдсэн өвөрмөц соёлтой холбодон хамт оршин тогтнодог[11] гэж үздэг.

Ялтнуудын харилцааны, нууцлалын болон ертөнцийг үзэх үзлийн илэрхийлэл болсон этгээд үг хэллэг нь криминологийн ач холбогдлоороо чухал байр суурийг эзэлдэг. Үүний тусламжтайгаар ялтнуудын дунд тогтсон зан үйл, дүрэм, хэм хэмжээг уламжлан дамжуулж бэхжүүлж байдаг ба этгээд үг хэллэг нь түүнийг хэрэглэгчдийг нэгтгэн нягтруулж, нийтлэг байдал, нэгдмэл ахан дүүс гэсэн ойлголтыг төрүүлдэг ажээ. Этгээд үг хэллэг хэрэглэж эхлэх үед өдөр тутмын ярианд нэвтрэн шингэж улмаар тухайн этгээдийн ухамсарт нөлөөлөн, үзэл бодол, үнэт зүйлст өөрчлөлт орж, бие хүний үзэл суртал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэн ертөнцийг үзэх гаж үзэл бодлыг маш худтайгаар бүрдүүлдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс явуулсан судалгаанаас үзэхэд [12] судалгаанд хамрагдсан ялтнуудын 91.7 хувь нь ямар нэг байдлаар этгээд үг хэллэг хэрэглэдэг гэснээс үзвэл тэдний хоорондын харилцааны өвөрмөц хэрэгсэл гэдэг нь харагдана.

Харин манай оронд энэ талаар хийгдсэн судалгаа байхгүй бөгөөд хорих ангид үйлдэгддэг пенитенциар гэмт явдалтай тэмцэх, түүний шалтгаан, нөхцлийг тогтоон, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулахад өнөөгийн хорих ангийн, төрөл дэглэмийн ялгаа, ял эдлэгсдийн онцлог,тэдний хоорондын харилцаа, тогтсон “өвөрмөц соёл”, этгээд үг хэллэг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө зэргийг харгалцан судлан авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал ялтны доторх албан бус бүлэглэл болох “гал хам” бүлэглэлүүдийн бүтэц зохион байгуулалт, түүний шатлан захирах ёс, тогтсон хэм хэмжээ, “дархлагдсан ялтнууд” болон нөлөө бүхий ялтнуудын зан төлөв, биеэ авч яваа байдал, яриа өгүүлэл, зэргийг онцгойлон судлан авч үзэх чухал билээ.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэн үзвэл бусад улс оронд болон манай улсад ч гэмт хэрэгтнүүдийн дунд өвөрмөц соёл, тогтолцоо, бүрэлдэн бий болж гэмт

[11]Courtney A. Waid, Theoretical Studies of the Prison Subculture: Contemporary Explanations for Female Inmates. Florida State University. http://sociologyindex.com/prison_subculture.htm

хэргийн ертөнцийн уламжлал, ёс заншил, эрүүгийн ертөнцийн бичигдээгүй “хууль” оршин тогтнож байна. Манай улсын хувьд ялтнуудын дундах албан бус бүлэглэл, шоронгийн өвөрмөц соёл /prison subculture/, тэдний хоорондын харилцаа, этгээд үг хэллэг, амьдралын онцгой хэв маяг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө, учруулж буй хор уршиг зэргийг тусгайлан судалж түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга зам боловсруулах хэрэгцээ, шаардлага хэдийнээ бий болжээ.

Ялангуяа ялтан, хоригдогсдын үзэл санаа, хүсэл сонирхол, тэдний хүрээлэн буй нийгмийн бичил орчин дахь нууцлагдмал хэв маяг, “шоронгийн өвөрмөц соёл” /prison subculture/, ялтнуудын албан бус бүлэг, түүний зохион байгуулалт, тэдний санаа сэтгэлийг хэрхэн удирдан чиглүүлэх талаар судлан ойлгохгүйгээр тэднийг “дахин нийгэмшүүлэх”, гэмт санаа бодлоос нь татгалзуулах, нийгмийн нийтлэг хэм хэмжээ, хууль дүрмийг сахин биелүүлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд хүндрэл учирсаар байх болно. Иймд бид энэ чиглэлээр шинжлэх ухааны мэдлэгт суурилсан өргөн хүрээтэй судалгаа явуулах шаардлагатай бөгөөд илтгэлийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөндөн бичиж буй сэдвийн хүрээнд криминологи, социологи, сэтгэл судлалын болон бусад шинжлэх ухааны мэдлэгт суурилсан олон төрлийн судалгааны ажил хийх түүндээ энэ чиглэлийн судлаач, эрдэмтдийг татан оролцуулах.

2. Шорон судлалын /prison study/ төвийг шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын эрдэмтэн, судлаач, профессор, багш нарын оролцоотойгоор ХСИС-ийг түшиглэн байгуулах. Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, гадны ижил чиг үүрэг бүхий судалгааны байгууллагатай хамтран ажиллах, тэдний туршлагыг судлах.

3. Хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ ялтныг хоорондхолих, ёс суртахууны, зан төлөвийн эвдрэлд оруулан “шоронжуулж” /prisonization/ буй байдлыг даруй өөрчлөх. Анх удаа гэмт хэрэг үйлдэн хорих ялаар шийтгүүлсэн ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж буй ялтныг засрал хүмүүжил олоогүй ялтнаас тусад нь ял эдлүүлэхэд анхаарч ялтныг хэд хэдэн зэрэглэлд ангилан ял эдлүүлэх зэрэг саналуудыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

[12] ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс 2013 онд явуулсан судалгааны тайлан.



Б.БАЯСГАЛАН
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн эрхлэгч, хурандаа

ӨНӨӨГИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДСАН АСУУДЛУУД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Түлхүүр үг: Эрх зүйн шинэтгэл, хорих ял, хорихоос өөр төрлийн ял, зорчих эрхийг хязгаарлах ял, нийгэмшүүлэх, нээлттэй хорих анги, хаалттай хорих анги.

Агуулга: Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиар хорих ял эдлэгсдийн тоо тодийлөн буурахгүй байна. Хорих ял эдлэгсэдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлыг үр нөлөө хангалттай биш, хорих ял эдлэгсдийг шоронжуулж байгаа, хорих ял нь нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавартай болохыг эрдэмтэн судлаачид нотлож байгаа билээ. Иймд эрх зүйн шинэтгэл хийх ажлын хүрээнд аль болох хорих ялаас татгазаж хорихоос өөр төрлийн ялыг манай улс, орны хөрсөнд буулган хэрэгжүүлэх асуудлыг хөндөхийг оролдсон билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тулгамдсан асуудлын нэг бол хорих ялаар шийтгэгдсэн хоригдолын тоо байсаар ирсэн. Сүүлийн арван жилд жилд дунджаар 6000-7000 хүн хорих ялыг биечлэн эдэлж байгаа ба 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж буй тохиолдолд хорих ангид ял эдлэж буй хүний тоо буурах шинжгүй.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох зорилт дэвшүүлж хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх болсон билээ.

Хорих ял гэдэг нь ялтныг олон нийтээс тусгаарлаж харуул хамгаалалт хяналт бүхий хорих тусгай байгууллагад байлгахад оршино [1] гэдэг нь дараах үйл ажиллагааг зохицуулах тэдгээр хорих ял эдлэгсдийг байрлуулах, хооллох, хувцаслах, хүмүүжүүлэх гэх мэт асуудлуудаас хамгийн түвэгтэй асуудал нь ажлын байр, хөдөлмөрийн зах зээлээр хангах явдал, үүнийг төр зохих ёсоор шийдвэрлэж чадаагүй ирсэн одоо ч зохицуулахад бэрхшээлтэй асуудал нэг байсаар байна.

Үүний дараа хоригдлыг хүмүүжүүлэх асуудал чухал асуудал болсон бөгөөд төр засгийн байгууллагууд хоригдлыг хүмүүжүүлнэ, дахин хүмүүжүүлнэ гэж хууль дүрмэндээ зааж хүмүүжүүлэгч гэдэг албан тушаалтан

[1] Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, С.Нарангэрэл, Г.Совд, Г.Уранцэцэг. Хууль зүйн тайлбар толь. УБ хот 2003 он тал 297

ажиллуулж ирсэн боловч хоригдолд хүмүүжил олгох боломжгүй болох нь харагдаж байгаа билээ. Тийм утгаараа сүүлийн үед хүмүүжил гэдэг нэр томьёоноос татгалзан хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлнэ хэмээж нийгмийн ажилтан ажиллуулаж цол хэргэм, албан тушаалыг нь ахиулсан боловч төдий л ахиц дэвшил гараагүй л байна. Хорих байгууллагад хоригдох хүний тоо улс төрчдын анхаарлыг татаж ирсэн бөгөөд 2002 оны Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиуд шинээр батлагдахад тухайн үед хорих ял эдлэгсдийн тоо 6000 гаруй болж байсныг үлэмж хэмжээгээр цөөрнө гэж үзэж байлаа гэтэл 2015 оны байдлаар хорих ял, баривчлах ял эдлэгсдийн тоо цөөрсөнгүй харин улам нэмэгдсэнийг дээр дурьдсан билээ. Хорих ял эдлэгсдийн тоо өсөх тусам улсын төсвөөс зарлагдах хөрөнгө, мөнгө улам өсөж үргүй зардал гарсаар байгаа нь хүн бүхэнд ил тод байна. Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ял эдлэгсдийн тоог цөөрүүлэх хорихоос бусад төрлийн ялыг өргөн ашиглах нь зүй ёсоор тавигдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинэтгэл нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй салбар эрх зүй мөн тул хууль зүйн шинжлэх ухааны хөгжил чиг хандлагатай хамаарал бүхий ойлголт мөн билээ. Хууль зүйн шинжлэх ухааны хөгжил чиг хандлага нийгэм, эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой байдаг тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйг түүнээс салган ойлгох аргагүй билээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй нь тухайн нийгмийн хөгжлөөс хамаарч нийгмийн өмнө тавьсан шаардлагыг гүйцэлдүүлэхийн тулд шинэчлэгдэн хөгжиж ирсэн тодорхой байна. “Эрх зүйн хүрээний өөрчлөлт, шинэтгэлийн асуудал” бүтээлдээ доктор профессор Б. Чимэд эрх зүй нь ганцаараа агаарт дүүжлэгдсэн дэнлүү биш. Харин тухайн нийгмийнхээ ахуй, ухамсраар мөн чанар нь нөхцөлдөн тодорхойлогддог нийгмийн бүхий л харилцаатай шүтэлцсэн нарийн түвэгтэй үзэгдэл, бүхэл бүтэн тогтолцоо мөн билээ. Энэ тогтолцоо наандаж:

- Хууль ба түүнд нийцсэн эрх зүйн бусад хэм хэмжээ
- Үнэлэн цэгнэх нийгмийн эрх зүйн ухамсар
- Уул хэм хэмжээг ухамсарласны үндсэн дээр хэрэгжүүлэх нийгмийн практик гэсэн гурван хэсгээс бүрэлдэн тогтодог.

Үүнээс үзвэл эрх зүйн шинэтгэл нь хууль, тогтоол, дүрэм, зааврыг өнгөцхөн “нухаж” өөрчлөх, сайжруулах төдийхөн бус, харин ихээхэн цар хэмжээтэй үйлс мөн болно[2] гэсэн ба цар хүрээтэй үйлс гэдэг уг та бидний анхаарлын төв байвал зохино. **Эрх зүй бол нийгмийн хөдөлгөгч дөрвөн зүйл *улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл-оюуны*** тохируулагч мөн тул эрх зүйн шинэтгэлийн асуудал хамгийн анхаарал татах зүй бизээ.

[2] Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Философи, социологи, эрхийн хүрээлэн. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ хот. 2013 он. тал 320

Эрх зүйн шинэтгэлийн үндсэн чиглэлийг доктор, профессор Б.Чимэд дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Нэгдүгээрт: ***Хууль тогтоомжийг шинэтгэх.*** Энэ бол уул шинэтгэлийн гол цөм мөн. Тэр нь бас хуулийн дэд актууд (Засгийн газар түүний байгууллагууд, нутгийн удирдах газруудын эрх зүйн хэм хэмжээний)-ыг шинэ хуулиудад нийцүүлэн өөрчлөх нөр их ажлыг дагалдуулдаг.

Хоёрдугаарт: ***Хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх.*** Энэ бол парламент, гүйцэтгэх хийгээд шүүх эрх мэдлийн бүх төрөл, бүх шатны байгууллагын чиг үүргийн хуваарилалт, хариуцлага, хуульд хандах зарчим, хэлбэр, арга барил, эв дүйг хүртэл (тэнд буй хүмүүсийг) шинэтгэх түвэгтэй ажил мөн.

Ялангуяа эдгээр үйл ажиллагааны эрх зүйн дэг журмыг нарийсгаж, хууль дээдлэх ёсыг дээрээсээ дэндүү сайн сахих нь амин чухал. Энэ бол шинэтгэлийн сайхь чиглэлийн гол агуулга мөн. **Шинэ хуулийг шинэчлэгдсэн парламент зөв бүтээж, дуулгаваржсан захиргаа ёсчлон биелүүлж, цэвэржсэн шүүх шударгаар хэрэглэж чадна.** Энд хүн ба хуулийг дээдлэх ёс онцгой анхаарал татна.

Гуравдугаарт: ***Хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх***. Шинтгэл гэдэг бол угтаа машин техник, барилга байшин солих, шинээр сүндэрлүүлэх ажиллагаа биш. Ингэж харагдаж, тэгж илэрдэг боловч язгуураас нь авч үзвэл хүнийг шинэтгэх, хүн өөрийгөө өөрчлөх асуудал мөн. Эрх зүйн шинэтгэлийн эцсийн дүнд хүн, юуны өмнө хууль тогтоогчид, гүйцэтгэгч, хэрэглэгч, эрх зүйн мэргэжилтэй боловсон хүчин хийнэ.

Дөрөвдүгээрт: ***Хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх.*** Энэ бол хүн төрөлхтний хувьд ууган боловч Монголын хувьд хамгийн залуу шинжлэх ухаан мөн. Энэ салбарыг дан ганц марксист онол, арга зүй, ангич хандлагаас ангижруулж, хүн төрөлхтний эрх зүйн мэдлэг соёлын суурь дээр Монголоо судалж, мэдэж хөгжүүлэх, хэрэгцээнд үндэслэн жинхэн ёсоор хөгжүүлэх хүндэн зорилт юм.

Тавдугаарт: ***Нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлж, сайн эрх зүйг үгүйсгэхтэй тэмцэх.*** Энэ бол өгүүлэн буй шинэтгэлийн хамгийн түвэгтэй “үл үзэгдэх” урт хугацааны зорилт бөгөөд бодитой үнэлэж, зөв тайлж, онож хийвэл зохих үзэл онол, мэдрэмж шаардсан ажил юм. Гажуудлын тусгал болсон хуучин ухамсар хийгээд шударга хуулийг үгүйсгэх орчин цагийн сөрөг үзлийг таягдан хаяхын зэрэгцээгээр нийгэмд эрх зүйн шинэчлэгдсэн сэтгэл зүй, шинэ үзэл онолыг бүрдүүлэх ажлыг төрийн зүгээс чиглэсэн зорилготой хийх нь уул ажлын үндсэн агуулга мөн.

Дээр дурдсан таван чиглэлийг эрх зүйн шинэтгэлийн нарийн ширийн хийгээд нийгмийн харилцааны бүх салбарт хамаарах бүх шижмийг багтаасан гэдэг санаагаар ангилсангүй. Харин уг үзэгдлийг бүрдүүлэгч үндсэн

элементийг хамаарна гэж үзэж болно[3] гэсэн байдаг. Тэгвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинэтгэлийг дээрх таван зүйлтэй уялдуулан холбож явуулах хэрэгтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн баярын хурал дээр "Ардчилсан хөдөлгөөнөөр бид эрх, эрх чөлөөгөө эргүүлэн олж авсан. Бид Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олж авсан юм. Ардчилал бол хүрэх зогсоол биш, үл төгсөх үйл явц. Нэг асуудлыг шийдвэрлэхэд дараагийн асуудлын хариуг нэхэж байдаг" [4] гэдэгтэй адил эрх зүйн шинэтгэл бол эцэс төгсгөлгүй байнга хөгжин төгөлдөржиж байдаг эрх зүйн процесс мөн.

Манай орны эрх зүйн шинэтгэлийн чиг хандлага Ром-Германы эрх зүйн бүл соёл, түүний хөгжил чиг хандлагатай салшгүй холбоотой тул эх газрын эрх бүл бүхий орнуудын шүүхийн шийдвэр гүйцэтгэх буюу хорих байгууллагуудын үйл ажиллагаатай судалгаанд түшиглэн товчхон боловч танилцуулъя.

Жишээ болгон барууны зарим нэг орны хорих байгууллагуудын талаар уншиж судалсан, үзэж харсан судалгаанд тулгуурлан, өөрийн санаа бодлоо тольдуульяа.

ХБНГУ-ын хорих байгуулагын хорих ял эдлүүлэх дэглэм нь нээлттэй буюу хаалттай гэсэн хоёр хэлбэрэр үйл ажиллагаа явуулдаг.

Нээлттэй хорих ангид 6 сар хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлэгсэд эсвэл нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдэгсдийн ялыг эдлүүлдэг энэхүү ял эдлэгсэд нь харьцангуй эрх чөлөөтэй байж үйлдвэр хөдөө аж ахуйн байгууллагууд гэрээгээр хөдөлмөр эрхлэж, ажлын цаг дууссаны дараа оройн хооллоо бие даан зохицуулаад хорих байрандаа ирж ирцээ танилцуулан амардаг ба өглөө нь жирийн ажилчид шиг олон нийтийн болон хувийн машин тэргээ хөлөглөн явж ажил хөдөлмөрөө хийдэг нь манайхаар бол нийтийн байранд амьдарч буй хүмүүстэй адилхан байдаг. Энэхүү зохицуулалт нь ЗХХ байгуулагад 1980 оны эхэн үед МАХН-ны Улс төрийн товчооны 206 тоот тогтоолоор "тусгай комендатур"-ыг байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг даалгасан байдаг. Тусгай комендатурыг үүрэг зорилго нь болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж тав хүртэл жил, санаатай боловч нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдсэн 2 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлсэн хорих ял эдлэгсэдэд оногдуулдаг нэг төрлийн хөдөлмөр хүмүүжлийн хэлбэртэй нээлттэй хорих анги, байгууллага байсан. Энэхүү тусгай комендатур нь Сэлэнгэ аймгийн Баруун Хараа САА буюу одоогийн Баянгол сум, Төмөр замын Толгойт өрөө, Налайх хотод тус тус байгуулагдан үүргээ гүйцэтгэж байсаныг өнөөгийн

[3] Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Философи, социологи, эрхийн хүрээлэн. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ хот. 2013 он. тал 322-333

[4] К.Чулуунбаатар, Д.Баатар, Ц.Хажидмаа, Ц.Жамц, Г.Бадамханд Эрх зүй, төрийн үндэс. УБ хот 2015 он тал 111

нийгэм, эдийн засаг, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон хэрэгжүүлж болох талтай гэж бодож байна.

Хаалттай хорих ангид санаатайгаар хүнд гэмт хэрэг үйлдэж 6-15 жилийн хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрэгч этгээдүүдийг хорьж гэм буруугаа ухамсарлах боломж олгох зорилгийг агуулдаг байна. Хаалттай хорих ангид хоригдогсод тухайн хорих байгууллагын нутаг дэвсгэр, үйлдвэрийн талбайд хүний эрх, эрх чөлөөг харьцангуй чөлөөтэй эдэлдэгээс гадна манай хорих ангиудад хэрэгжүүлдэг цэрэгжисэн зохион байгуулалтгүй ял эдлэгсэд хорих ангийн удирдлага албан хаагчидтай ердийн харилцаатай байдаг онцлогтой. Хоригдол ч гэсэн энэ нь хүний жам ёсны эрх, эрх чөлөө, үндсэн хуульд заасан эрхийг аль болох эдлүүлэхийг эрмэлздэг байдал ажиглагдаж байсныг тэмдэглэх хэрэгтэй гэж үзлээ.

Судалгаанаас үзхэд барууны хөгжилтэй орнууд түүний дотор Шведын хууль цаазны байгуулага хорих ял эдлэгсэдийг аль болох өөрийгхөө авьяас чадварыг нээх гар урлал, уран зураг зурах, баримал цутгамал хийхэд нь хорих байгууллагын ажилтан онол арга зүйн зөвлөлгөө өгч эд материалын тусламж үзүүлэн дэмжин тусалдагаараа хорих ял эдлэгчдийг завгүй байлгах бодлого барьж ажиглагддаг. Анх удаа, нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд амралтын өдрүүдэд чөлөө өгч тодорхой заасан хот дүүргээр явж нийгмийн амьдралтай танилцах боломж олгож нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулж хорих байгууллагаас суллах сэтгэл зүйн бэлтгэлд хамруулдаг жишээ байна.

Мөн түүнчлэн хорих ял эдлээд суллагдахад нь уг этгээдийг нийгэмшүүлэх ажлыг гүнзгийрүүлэн зохион байгуулан уг этгээдийг засарал хүмүүжил баттай олсон нийгмийн дунд бие зөв боловсон авч явах чадвартай гэж үзвэл дахин хууль зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг сануулан гэр орон, эхнэр хүүхэдтэйгээ амьдарч ажил хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрдөг. Суллагдсан этгээдийн хойноос нийгмийн ажилтан байнга анхаарал хандуулан зарим үе гэр бүлийн гишүүд, хүүхэдээс тухайг этгээд хэрхэн амьдарч байгаа, гэр бүл хөршийнхөндөө хүндэрэл учруулж байгаа эсэх талаар судалдаг. Хэрэв уг этгээд хууль дүрэм зөрчвөл хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт үйлчилдэг. Энэхүү эрх зүйн хэм хэмжээг манай орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлж болох юм шиг санагдсан.

Үүний зэрэгцээ хууль, эрх зүй судлаач нарын анхаарлыг татаад байгаа “зорчих эрхийг нь хязгаарлах” ялыг ялын төрөлд багтаан хэрэгжүүлэх боломжийг тал талаас нь бодолцох хэрэгтэй. Энэхүү төрлийн ялыг эдлүүлэхэд анхаарал татсан асуудлууд олон байна. Жишээ нь хорих ял эдлэгсдийг зорчих эрхийг нь хязгаарлах ялыг хэрхэн эдлүүлэх, тухай ял эдлэгчийн ар тал, гэр бүлийн байдал, эдийн засгийн чадвах, чадамж тухайн хүний ёс суртахуун, хүмүүжил, харилцааны түвшил нөлөөлөх нь гарцаагүй. Мөн

түүнчлэн орчин үеийн цахим техник техинолгийн шийдэл голлох нөлөөлөл үзүүлэх нь ойлгомжтой.

Зорчих эрхийг нь хязгаарлах шинэ ялын төрөл, хугацаа нь 1 сараас 5 жил хүртэл байхаар төсөлд тусгасан ба шүүх, хууль сахиулах байгууллагаас тогтоосон замаар явж тодорхой тооны хүмүүстэй харьцахаас гадна оршин суугаа газраа өөрчлөхгүй байх ёстой. Хэрэв шүүхийн шийдвэрийг үл хэрэгжүүлсэн тохиолдолд нийгэм, хамт олны дунд явж ажил үүрэг гүйцэтгэх, зарим нэг хүмүүстэй харьцахыг нь хориглохоор тусгасан байна. Зорчих эрхийг нь хязгаарлах ялаар шийтгэгдсэн этгээдэд электрон гав бугуйвчийн тусламжтайгаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавих ажээ.

Манай улс зах зээлийн эдийн засгийн системд эргэлт буцалтгүй шиджиж Үндсэн хуулиар шударгаар хувийн өмчтэй болохыг хуульчилсан ба хувийн өмчийг хамгаалахаар заасан ба сүүлийн 20 жилд хувийн өмчтөн үндэсний тэрбумтнууд төрсөн нийт хүн амын 10-ад хувийг эзлэж тэдгээрийн хөрөнгө үндэсний баялагын 90 гаруй хувийг эзэмшиж байна гэсэн судлагаа байдаг. Сүүлийн жилүүдэд төрийн болон төсвийн мөнгө, өмч хөрөнгө завшихаас улбаалан гэмт хэрэгт холбогдох, улс төрийн болон захиргааны албан тушаалтнуудаас /цагаан захтанууд/ авилгал, хээл хахуулийн гэмт хэрэгт холбогдох нь ихсэж байна. Энэ төрлийн гэмт хэргийг хэрэг гэж тооцох ч байж нийгмийн нэгэн үзэгдэл хэмээх үзэх хандлага ажиглахдах боллоо.

Сүүлийн үед хорих ял эдэлж буй ялтан өөрийн зардлаар дээд боловсрол эзэмшиж ял эдэлж байх хугацаандаа өндөр насны болон бусад тэтгвэр, тэтгэмж тогтоолгох эрхийг нэмэх санал оруулж байгаатай холбогдуулан дараах зүйлд шүүмжлэлтэй хандаж байна.

Гэмт хэргийн өрнөлт түүний чиг хандлагыг харахад улс төрийн болон төрийн албан тушаалтанд зориулсан хорих байр, эмнэлэг байгуулан тэдгээр гэм буруутай этгээдүүдийн хувийн зардлаар хангалт үйлчилгээ үзүүлдэг болоод байгаа нь олон нийт харж байна.

Үүнд: ***“эрх зүй ямагт шударга байдаг бол хууль шударга бус гардаг”*** талаар Ромын үеийн эрдэмтэн мэргэд сургасан байдаг. Өнөөгийн монголын нийгэмд хуулийг хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт нийцүүлэн гаргах түүгээр үл барам зарим нөлөө бүхий улс төрчид ирээдүйд болох эрүүгийн нөхцөл байдал тохируулан хууль боловсоруулах, зарим нэгэн нь залуу хуульч, эрх зүйч нарыг ивээлдэх авах, төрийн зарим албан тушаалд томилох үзэгдэл гаргаж байгааг яагаад ч хүлээн зөвшөөрхөөргүй үйл явц, ажиглагдаж байгааг одооноос засаж залруулах хэрэгтэй байна.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрхийг хасах хэрэгтэй гэж өнгөрсөн үйл явцаас дүгнэж болмоор байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нь нийгмийн харилцааг зохицуулж ирсэн түүхэн уламжлал өнөөгийн нийгмийн өөрчлөлт хууль зүйн шинжлэх ухааны шинэчлэл, эрх зүйн хөгжилтэй шууд холбоотой

болох нь харагдаж байна. Энэхүү өгүүлэлдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинжлэх ухааныг өнөөгийн нийгэмтэй холбон тулгамдаж байгаа асуудыг чадлынхаа хөндөхийг хичээсэн билээ. Үүнээс улбаалан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монголчууд нүүдлийн соёл иргэншлийн үед цаазар авах ял зонхилон хэрэглэж байсан нь эх сурвалжаас тодорхой энэхүү ялын төрлийг өнөө үед үргэлжлүүлэн хэрэглэх нь онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ядаж айлган сүрдүүлэх эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай гэж үзээд цаазын ялгүй орон болох асуудлыг түдгэлзүүлэх хэрэгтэй байна.

2. Хорих ялыг манай оронд XIX-XX зууны үеэс хэрэглэх болсон нь Европын суурин иргэншлийн нөлөө эх газрын эрх зүйн бүлийн харилцаа нэвтэрсэнтэй шууд холбоотой гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Иймээс энэхүү ялын төрлийг аль болох бага оногдуулах шаардлага өнөөгийн нийгэмд үүсээд байна.

3. Эрүүгийн эрх зүй хэм хэмжээ, түүний харилцаатай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт орж аймаг нийслэлд хорих анги бий болгож байгаа нь цаашид хорих ялыг өргөн хэрэглэх бодлого ажиглагдаж байна. Үүнээс татгалзах.

4. Дэлхийн дахины шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагыг Монгол орны нөхцөлд тохируулан хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх, шинэ ялын төрлийг зоригтойгоор буй болгох шаардлага байгааг хууль санаачилагчид болон хууль тогтоох байгууллагад хүргэх нь зүйтэй гэж үзлээ.



Р.УУГАНБАЯР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад

ХУЯГЛАН ХҮРГЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Хураангуй

Ялтныг хуяглан хүргэх ажиллагааны тухай ойлголт, төрөл хуяглан хүргэх ажиллагааны харуул хамгаалалтын зохион байгуулалтын онцлогийн талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үгс

Хорих анги, цагдан хорих төв, нэгдсэн эмнэлэг, ялтныг хорих ангид хуваарилах, хуяглан хүргэлтийн тээврийн хэрэгсэл, ялтан, хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих байгууллага нь хорих ялыг албадан эдлүүлэх, ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх зэрэг бусад арга хэмжээг зохион байгуулах тусгай чиг үүрэгтэй төрийн байгууллага мөн.

Нөгөө талаас энэхүү чиг үүрэг нь эрүүгийн хариуцлагын зорилго /иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх\-ээс урган гарсан хэмээн үзэж болно.

Хуяглан хүргэх ажиллагааны талаар судлахын өмнө хуяглан хүргэх ажиллагаа гэж юуг ойлгох тухай хэл зүйн тайлбар болон хууль зүйн салбарын эрдэмтэн судлаачийн байр суурь, үзэл хандлагыг харьцуулан судалж тодорхой ойлголттой болох нь зүйтэй. Хуяглан хүргэх ажиллагаа гэдэг нь хуяглахаас үүсэлтэй хоршоо үг юм.

Хуяглах 1. ялт хүнийг сахиж сэргийлэх[1], 2. Хуяг дуулгаа өмсөх -Хүмүүс дандаа зэр зэвсэгтэй яван орон гэрээ орхин алс холд одохуйд биеэ хуяглаж, төмөр дуулганд толгойгоо нууж явдаг байжээ, 3. Зарим амьтны, биеийнхээ гадуур хуяг мэт юмтай болох: гахай хуяглах (нэгдүгээр сарын сүүлчээр, бодон гахай орооныхоо үед мэгж эрж, их явснаас халууцаж, харз усанд орж сэрүүцэн, хайрган дээр хэвтэж, бүх бие нь элс шороогоор өвч хучигдах), 4. Зарим юманд ган, болд мэтээр бэхлээс хийх.

Хүргэх 1. Хүрэлцэх гар хүрэх (алив юмыг гараар хүрэлцэх, барих хөдөлгөх), 2. Илгээх, явуулах, өгөх: бичиг хүргэх, бэлэг хүргэх, захидал хүргэх, хүргэж өгөх[2] гэсэн утгыг илэрхийлнэ.

[1] Цэвэл.Я "Монгол хэлний товч тайлбар толь".УБ., 1966.741 дэх тал

[2] Цэвэл.Я "Монгол хэлний товч тайлбар толь".УБ., 1966. 747 дах тал

Академич С.Нарангэрэл /Sc.D/ өөрийн бүтээлдээ: хуяглан хүргэх ажиллагаа гэдэг нь баривчлагдагч, ялтан буюу цэргийн олзлогдогчийг товлосон газарт харгалзуулан хүргэх зэвсэглэсэн хамгаалалт[3] гэж тодорхойлсон бол Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар нар өөрийн бүтээлдээ: Ялтанг цагдан хорих байр, хорих анги хооронд шилжүүлэх, тусгаарлах тасалгаа, сахилгын байрнаас гаргаж тодорхой обьектод хүргэх, буцаах үед тодорхой журам, зааврыг баримтлан аюулгүй байдлыг хангаж тээврийн хэрэгсэл болон явганаар гүйцэтгэж буй харуул хамгаалалтын ажиллагааг ойлгоно[4] гэж тус тус тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл хуяглан хүргэх ажиллагаа нь нэг хорих ангийн байршлаас нөгөө хорих ангийн байршилд харуул хамгаалалтын хяналтан дор ялтан хоигдогчийг зөөвөрлөх ажиллагаа гэж ойлгож болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 сарын 28-ны өдөр баталсан хуяглан хүргэлтийн зааварт Хуяглан хүргэх ажиллагаа гэж ялтныг ял эдлэх хорих анги, гянданд хуяглан хүргэх, хорих анги хооронд болон 401 дүгээр хорих анги-Нэгдсэн эмнэлэгт шилжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллуулах, хорих анги, нэгжийг нүүлгэн шилжүүлэх, түүнчлэн хорих ангийн хамгаалалтын бүсэд харуул хамгаалалтын хяналтанд явганаар үйлдэгдэж буй ажиллагааг ойлгоно[5] гэж тодорхойлсон байна.

Дээрхээс үзвэл хуяглан хүргэх ажиллагааны талаар эрдэмтэн судлаачид нэгдсэн ойлголтонд хүрээгүй бөгөөд энэ нь онолын хувьд маргаантай асуудлуудын нэг болох нь тодорхой харагдаж байна.

Дэлхийн жишгээс хархад хуяглан хүргэх хамгаалалтын ажиллагааг Зэвсэгт хүчний, Хууль сахиулах байгууллагын хуяглан хүргэлт, онцгой ачаа тээшийн хуяглан хүргэлт[6] гэж гурав ангилж авч үздэг бол манай улсын хувьд ялтныг хуяглан хүргэх ажиллагаа нь хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх гэсэн хоёр төрөлтэй.

Хуяглан хүргэлтйн ажиллагааг хэлбэрийн хувьд тээврийн хэрэгслээр болон явганаар хуяглан хүргэх гэж 2 ангилж болно.[7] Хуяглан хүргэх ажиллагааг орон нутаг, газар зүйн байршлаас шалтгаалан нисэх онгоц, суудлын галт тэргээр зохион байгуулж болох ба энэ тохиолдолд харуул хамгаалалтын ажилтныг ялтны тооноос хамааран хорих анги, албаны дарга, Цагдан хорих төвийн Хуяглан хүргэлтийн хэлтсийн дарга томилж, үүргээр хангах ба Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний

[3] Нарангэрэл.С “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан III дах хэвлэл.УБ.,2011./х/.571

[4] Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа”.УБ.,2013./х/.156

[5] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн н/07 дугаар тушаалаар батлагдсан “Хуяглан хүргэх ажлын заавар”-ын 1.3 дах заалт

[6] https://ru.wikipedia.org/wiki/

[7] Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа”.УБ.,2013./х/.157

нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр"-т заагдсан арга хэмжээг авна.[8]

Хуяглан хүргэх ажиллагааны харуул хамгаалалтын онцлог, ажилтны гүйцэтгэх үүрэг:

Хуяглан хүргэлтийн офицер нь батлагдсан нэрс, хувийн хэрэгтэй ялтныг тулган хүлээн авч, түүний бие болон эд зүйлд үзлэг, нэгжлэг хийн холбогдох хууль, дотоод журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад эд зүйлийг хураан авч, хуяглан хүргэх ажиллагааны явцад биеэ хэрхэн авч явах талаар танилцуулан, тээврийн хэрэгсэлд суулгах ажиллагааг биечлэн зохион байгуулна.[9]

Хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулах алба, анги нь

- Хуяглан хүргэх ажиллагаанд явах машин техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах
- Хуяглан хүргэх ажиллагаанд явах алба хаагчдын бэлтгэл сургуулилалт хийх нөхцөлөөр хангаж, тусгай хувцас, галт зэвсэг, тусгай хэрэгсэл шаардлагатай бол албаны нохойгоор хангах үүрэг хүлээх бөгөөд хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулах ажилтнууд дараах зарчмыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:
- Тогтоол гүйцэтгэх газар, хорих анги, албаны даргын баталсан нэрсийн жагсаалтаас зөвшөөрөлгүй ялтныг авч үлдэх, тээвэрлэх
- Хуяглан хүргэж байгаа ажиллагааны нууц задхуулах, ялтныг төрөл садан, бусад хүнтэй уулзуулах
- Хуяглан хүргэх замд зөвшөөрөгдөөгүй газарт зогсох, ялтныг буулгах, гадны хүн тээвэрлэх
- Ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд зориулалтын бус, тэдгээрийн ар гэрийн болон хувийн авто машин ашиглах
- Батлагдсан маршрут зөрчих, бүрэн бус техникээр ялтныг тээвэрлэх, даац хэтрүүлэх
- Хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэх үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх эдгээр зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

Энэ зарчим нь хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэж буй бүх албан хаагчдад чанд мөрдөх шаардлагатай бөгөөд өдөр тутам харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх ажилтнаас дараах мэдлэг, чадварыг заавал илүү эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

- Хуяглан хүргэх ажиллагааны үед гаднаас халдан довтлох үед аюулгүй байдлаа хэрхэн хангах
- Гэнэтийн осол, аваар, техникийн гэмтэл гарсан үед хуяглан хүргэгдэж буй ялтнуудын хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах
- Хуяглан хүргэх явцад ялтны эрүүл мэнд муудсан тохиолдолд хэрхэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх

[8] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 дугаар сарын 28-ний өдрийн н/07 дугаар тушаалаар батлагдсан "Ялтныг хуяглан ажлын хүргэх" зааварын 2.17 дэх заалт

[9] Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч "Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа".УБ.,2013./х/.159

Эрсдэл бий болсон үед бусдаас тусламж хүсэж хамтран ажиллах арга, тактик эзэмшисэн байх /цэрэг, цагдаа, онцгой байдал бусад орон нутгийн албадтай/ зэрэг сэтгэл зүйн болон бие бялдарын бэлтгэлжилтээрээ бусад харуул хамгаалалтын ажилтнаас ялгарч байх ёстой.



Б.МӨНХБААТАР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, сэтгэл судлалын магистр, ахлах дэслэгч

ЭМЭГТЭЙ ЯЛ ЭДЛЭГСДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

\Гадаад орнуудын жишээ дээр

Хураангуй: Эмэгтэй ял эдлэгсдийн дунд сэтгэцийн болон сэтгэл зүйн ямар нэг өөрчлөлт болон бусад төрлийн эрсдлүүд түгээмэл байдаг талаарх олон улсын үзэл хандлагыг харьцуулан судалсан болно.

Түлхүүр үг: Сэтгэцийн эрүүл мэнд, эмэгтэй ялтан, нийгэм хүн ам зүй, сэтгэцийн эмгэгүүд

Хүн төрлөхтний хөгжлийн явцад эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлогийг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулан судалсан байдаг. Дөнгөж өнгөрсөн зуунаас эхлэн хорих ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлог болон сэтгэцийн эрүүл мэндийн талаар яригдаж эхэлсэн түүхтэй. Тэр дундаа эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн онцлогийн талаар мөн тэдний хорих ял эдлүүлэх газар буюу нийгмээс тусгаарлах хэлбэр нь тэдний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж буй талаар сонирхон судлсан байдаг.

Хүн өөрийн амьдралын туршид олон төрлийн асуудалтай тулгардаг бөгөөд тэр болгонд сайн муу ямар нэг шийдвэр гаргах зайлшгүй шаардлага тулгардаг. Өнгөрсөн зууны 30-аад оноос сэтгэл зүйн үйлчилгээ нь хүнийг өөрчлөхөд тэр дундаа ял эдлэгсдийг өөрчлөх, нийгэмшүүлэхэд илүү үр дүнтэй хэрэгсэл гэсэн үзэл хандлага дэлгэрсэн бөгөөд үүнтэй уялдан олон улсын хэмжээнд энэ чиглэлийн алба хаагчид буюу сэтгэл зүйчидийн орон тоо бий болсон байна[1]. 1970-аад оны сүүлээс ял эдлэгсэд дээр туршиж батлагдсан, илүүтэй боловсронгуй болгосон судалгааны хэрэглэгдэхүүнүүд бий болсон бөгөөд 1980-аад онд ял эдлэгсдийн зүгээс эрчимтэй гарч эхэлсэн нийгмийг цочроосон үйлдлүүд буюу хорих ангиас оргох болон гэмт хэргийн гаралт үзүүлэх хариу үйлдлийн талаар илүүтэй анхаарал хандуулан судалж эхэлжээ. Гэсэн хэдий ч 90-ээд оны эхээс эхлэн хувь хүний сэтгэл зүйн онцлог болон тэдгээрт үзүүлэх нөлөөллийн арга хэмжээ эрчимтэйгээр сэргэж эхэлсэн түүхтэй.

Ял эдлэгсдийн онцлогийг судлах сэтгэл зүйн судалгаа шинжилгээний ажлууд гагцхүү зөвхөн эрэгтэй ялтан, хоригдогсод дээр түлхүү тулгуурлаж байсан бөгөөд өнгөрсөн зууны 80-аад он

хүртэл эмэгтэй ял эдлэгсдийн талаарх сэтгэл зүйн асуудлыг “хүндрэлтэй” буюу хэцүү гэсэн тодотгол дунд хамаатуулан охигдуулж байжээ [2] . Энэ талын асуудлыг орхигдуулж байсан шалтгааныг авч үзвэл хорих ангийн алба хаагчдын “эрэгтэй алба хаагч” зүгээс тайлбарлахадаа-илүү асуулт асуудаг, удирдлагад ямар нэгэн асуудлаар илүүтэй ханддаг, гаргасан шийдвэрийг байнга үгүйсгэн өөрсдийн үйлдлээ тайлбарлах гэж оролддог хэмээн тодорхойлж байжээ.[3] Гэвч энэхүү “хүндрэлтэй” гэсэн тодотгол нь эмэгтэй ял эдлэгсдийн бие физиологийн онцлог зүй тогтол болон ямарваа нэг хэлбэрийн хүчирхийллээс үүдэлтэй тодорхой сэтгэл зүйн хямрал, гутрал болон төрх үйлийн өөрчлөлттэй холбоотой байжээ.

Олон улсын сэтгэл зүйчдийн хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд хорих ял эдлэж байгаа эмэгтэйчүүдийн дунд эзлэж буй сэтгэцийн эмгэгийн хувь эрэгтэй ял эдлэгсдийнхээс харьцангуй өндөр байдаг байна. Их британий судлаачид ял эдэлсэн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн сэтгэцийн хямралын талаар судлаж үзэхэд[4]:

Илрэл	Эмэгтэй	Эрэгтэй
Тодорхой бус сэтгэцийн хямрал	14%	7%
Невроз	63%	40%
Архины хамаарал	39%	63%
Бие хүний эмгэг	50%	

Хамгийн хачирхалтай нь бие хүний эмгэгтэй эмэгтэйчүүдийн тоо 50% давж байсан нь эрэгтэй ял эдлэгсдийн дунд эзлэх хувиас даруй хэд дахин их байжээ. Эдгээр судалгааны хариу урьд нь Их британий эрүүл мэндийн яамнаас хийгдэж байсан судалгааны үр дүнтэй /эмэгтэй ял эдлэгсдийн дунд шизофрения, невроз, архи болон сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн хамаарал зонхилж байна/ нийцэж байсан нь хачирхалтай.

АНУ-ын Хууль зүйн яамны тусгай тайлангаас үзэхэд хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэг буюу шизофрения[5], сэтгэлийн шалтгаант

[1] *Ekstedt J., Griffiths C.T.* Corrections in Canada: Policy and Practice Toronto. 1988

[2] *Dallao M.* Keeping classification current. Corrections Today. 1997.
Gottfredson D.M., Tonry M. Prediction and Classification // Crime and Justice: A Review of Research. Chicago, 1987. Vol. 9.

[3] *Van Voorhis P., Presser L.* Classification of Women Offenders: A National Assessment of Current Practices. U.S. Department of Justice, National Institute of Corrections, Washington: DC, 2001.

[4] *Singleton N., Meltzer H., Gatward R., Coid J., Deasy D.* Psychiatric Morbidity Among Prisoners in England and Wales: the report of a survey carried out in 1997 by Social Survey Division of the Office of National Statistics on Behalf of the Department of Health. London: The Stationery Office, 1998.

[5] Бямбасүрэн.С., Сэтгэцийн эмгэг судлал., УБ. 2013., 548 тал “Дотоод шалтгаантай,

сэтгэцийн эмгэгүүд, ухаан балартах хам шинж нь ял эдлэж буй эмэгтэй ял эдлэгсдийн 24%, эрэгтэй ял элэгсдийн 16% нь илэрсэн талаар дурьджээ[6].

Канад улсын хувьд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх судалгаанаас үзэхэд хоолны дуршлын эмгэг, шизофрения болон депрессийн илрэл эмэгтэй ял эдлэгсэдэд эрэгтэйчүүдийг бодвол гурав дахин их ажиглагдаж байсан талаар тодорхойлжээ. Мөн эрэгтэй ял эдлэгсэдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд хүнд хэлбэрийн сэтгэц нөлөөт эм бэлдмэл \героин, кокайн\-ний хэрэглээ их байдаг[7]. Өөрөөр хэлбэл нийгэм хүн амын эмэгтэйчүүдийн эзлэх хувьтай харьцуулахад ял эдэлж буй эмэгтэйчүүдийн дунд сэтгэл зүйн энэ олон төрлийн цочрол гэмтэлийн эх үүсвэр нь өнгөрсөн амьдралтын туршлага буюу хүнд хэцүү амьдрал, бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэлтэй холбогдон илэрч байсан талаар дурьдсан байдаг[8].

Канад улс дахь засан хүмүүжүүлэх байгууллагын Burnaby төвд улсын хэмжээнд нийт эмэгтэй ял эдлэгсдийн 19% дээр хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд 49% нь бие хүний эмгэгтэй, 67% нь сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн хамааралтай, судалгааны явцад 20% нь депрессийн өндөр илрэл, 24% нь түгшүүрийн тодорхой илрэл ажиглагдсан байна[9].

Бразиль улсын хэмжээнд нийт эмэгтэй ял эдлэгсдийн 80 орчим хувь нь бүх түвшний депрессийн илрэлтэй хэмээн судлагдсан бөгөөд архинд донтох эмгэг болон бэлгийн хүчирхийллийн харилцан хамааралтай хэмээн тодорхойлжээ. Тэдгээр ял эдлэгсдийн түүхийг судалж үзэхэд бие махбодийн болон амь насанд нь аюул занал учруулж байсан үндсэн шалтгаан нь улсын хэмжээнд түгсэн хар тамхины зохисгүй хэрэглээ хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.[10]

Тус улсын нийт ял эдлэж буй эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг нийгэм хүн амын дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувьтай

шизофренитэй удамзүйн холбоотой солиорлын шинжээр илэрдэг бүлэг эмгэгийг шизофрени ба шизофрени төст эмгэгүүд гэж нэрлэдэг. Мөн үүнийг солио гэж нэрлэдэг"

[6] *Ditton P.M.* Mental Health and Treatment of Inmates and Probationers. Bureau of Justice Statistics Special Report NCJ174463. Washington, DC: US Department of Justice. 1999.

[7] *Laishes J.* The 2002 Mental Health Strategy for Women Offenders. Ottawa: Correctional Service of Canada, 2002.

[8] *Jordan B.J., Schlenger W.E., Fairbank J.A., Caddell J.M.* Prevalence of Psychiatric Disorders Among Incarcerated Women: Convicted Felon Entering Prison // Archives of General Psychiatry. 1996. Vol. 53. № 6.

[9] *Laishes J.* The 2002 Mental Health Strategy for Women Offenders. Ottawa: Correctional Service of Canada, 2002.

[10] *Reeda E., Rajb A., Falboc G., Caminhac F., Deckerd M.R., Kalield D.C., Missmere S.A., Molnard B.E., Silvermand J.G.* The prevalence of violence and relation to depression and illicit drug use among incarcerated women in Recife,

харьцуулахад харьцангуй өндөр дүн гарч байжээ.

Илрэл	Ял эдлэгсэд	Иргэд
Шизофрения	7%	1%
Липотемия \Эндогенная дипрессия\	33%	8%
Архины хамаарал	36%	4%
Хар тамхины хамаарал	50%	4%
Бие хүний нийгэмд харшлах эмгэг	37%	1%

Мөн энэ төрлийн сэтгэцийн болон сэтгэл зүйн ямар нэг эмгэгтэй эмэгтэйчүүд хорих ял эдлэхээр ирэхдээ эрүүл мэндийн болон сэтгэл санааны байдал нь улам дордож ирдэг бөгөөд эмнэлгийн болон сэтгэл зүйн туслалцаа эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2-3 дахин илүү шаардагддаг байна[11]. Гэвч тодорхой зүй тогтол, шат дараатай судлагдаагүйн улмаас энэ төрлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх асуудал орхигддог байна. Магадгүй хорих ангийн төсөвлөгдсөн эмчилгээ үйлчилгээний зардал нь эмэгтэй ял эдлэгсдийн эмчилгээний зардалд хүрдэггүй нь энэхүү жишиг норм нь эрэгтэйчүүдийн жишгээр тодорхойлгдсон байх ч талтай.

Хорих ял эдлэж буй эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн нийгмээс тусгаарлагдсан, өвөрмөц орчинд үзүүлэх хариу үйлдэл нь харилцан адилгүй байдаг бөгөөд эрэгтэй ял эдлэгсдийн хувьд ямарваа нэг тааламжгүй зүйлдээ шууд хариу үзүүлэх буюу зодоон цохион хийх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх зэргээр илэрдэг бол харин эмэгтэйчүүдийн хувьд эсэргээрээ гаднаа илрэх хариу үйлдэл нь бага байх хэдий ч ихэнх тохиолдол дотоод зовинол, шаналал зэрэг өөртөө буруу өгч энэ илрэл нь даамжрахдаа амиа хорлолт болон бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулах хэлбэрээр илэрдэг байна[12]. Эдгээр үйлдлүүд нь сэтгэл зүйн ямарваа нэг дарамт болон бие хүний өөрчлөлт эмгэгтэй холбогддог бөгөөд харин нийтлэг байдлаар хорих байгууллагын алба хаагчдын зүгээс ямарваа нэг зүйлийг өөрт ашигтайгаар эргүүлэх болон бусдын

Brazil // International Journal of Law and Psychiatry. 2009. Vol. 32. Issue 5.

[11] Alexander P.C., Luper S.L. Family Characteristics and Longterm Consequences Associated with Sexual Abuse // Archives of Sexual Behavior. 1987. № 16.
Russell D.E.H. The Secret Trauma: Incest in the Lives of Girls and Women. New York, 1986.

[12] *Baird V., Bavidge L., Bundey R., Deal A., Dholakia L.N., Dick C.C., Gillan C., Hallett J.H., Malleson K., Monaghan K., Morton F., Prashar U., Siddiqui H., Southall A., Stern V., Stevens R., Watson* J. Commission on Women and the Criminal Justice System: Interim Report on Women and Offending. London. 2003.

анхаарлыг татах оролдлого хэмээн хардаг[13] байна.

N.Singelton et al [14] Их британий хорих ангиудад ял эдлэж буй ял эдлэгсэд дээр хийсэн судалгааны ажилдаа эмэгтэй ял эдлэгсдийн дунд амиа хорлох оролдлого нь эрэгтэй ял эдлэгсэд болон нийгэм хүх амын эмэгтэйчүүдийн дундах эдгээр оролдлогуудтай харьцуулахад харьцангуй өндөр буюу 10 эмэгтэй ял эдлэгсэд тутмын 4 нь амиа ямар нэг байдлаар хорлох оролдлого хийж байсан талаар тодорхойлсон байдаг. 1978-2003 оны Англи болон Уэльсийн хорих ангиудын мэдээллээс үзэхэд эрэгтэй ял эдлэгсэд дунд 1000 хүн тутмын 1 нь, эмэгтэй эдлэгсэд дунд 1000 хүн тутмын 3 нь амиа хоролсон байжээ[15]. Тэдгээр амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хоролсон эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэл зүйн цочрол, гэмтэлийн түвшин нь эрэгтэй амиа хорлогчдын үзүүлэлтээс даруй хэд дахин илүү байсныг тогтоожээ.

Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдэж буй эмэгтэйчүүдийн талаар ярихад гэмт хэргийн зүйлчлэл рецидивийн талаар дурьдах зайлшгүй шаардлагатай ч тэдний хувьд нийгмийн бусад төрлийн асуудлуудыг сөхөхгүйгээр тодорхойлоход хүндрэлтэй байж болох талтай. Гэсэн хэдий ч дээрх туршлагуудаас үзэхэд эмэгтэй ял эдлэгсдийн сэтгэцийн цочрол гэмтлийн зэрэг ийм өндөр байгаа нь тэдэнэд тохирох сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үр дүнтэй төсөл, хөтөлбөр үйл ажиллагаа нь хорих ангийн хэмжээнд нэн шаардлагатай зүйл гэж үзэж болохоор байна.

Иймд энэхүү асуудлуудыг шийдвэрлэхэд олон талын судалгаа тэр дундаа шүүх сэтгэцийн болон сэтгэл зүйн оншилгоо судалгааны хүйсийн онцлогт тохирсон туршигдсан аргачлалуудыг нэвтрүүлэн үр дүнг тооцон судлахаас гадна нөхөн сэргээх сэтгэл зүйн хөтөлбөрүүд \амиа хорлох эрсдэл, түрэмгий зан байдлын эсрэг\ нэвтрүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл хорих ангид ял эдлэж буй эмэгтэйчүүдийн сэтгэцийн цочрол гэмтэл орох магадлал эрэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байдаг бөгөөд

[13] *Baird V., Bavidge L., Bundey R., Deal A., Dholakia L.N., Dick C.C., Gillan C., Hallett J.H., Malleson K., Monaghan K., Morton F., Prashar U., Siddiqui H., Southall A., Stern V., Stevens R., Watson* J. Commission on Women and the Criminal Justice System: Interim Report on Women and Offending. London. 2003.

[14] *Singleton N., Meltzer H., Gatward R., Coid J., Deasy D.* Psychiatric Morbidity Among Prisoners in England and Wales: the report of a survey carried out in 1997 by Social Survey Division of the Office of National Statistics on Behalf of the Department of Health. London: The Stationery Office, 1998.

[15] Ministry of Justice UK. Statistical Bulletin Offender management caseload statistics 2006, 2007. № 115. Электронная версия: http://www.justice.gov.uk/docs/omcs2006.pdf.

энэ төрлийн төрх үйлийн өөрчлөлтүүд нь өнгөрсөн амьдралын туршлага буюу бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлууд нь гүн хэлбэртэй байдаг тул мэргэшсэн сэтгэл зүйчдийн баг, нөхөн сэргээх үйлчилгээ , төрийн болон төрийн бус нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах ажиллагааг нэмэгдүүлэх нь асуудлыг эерэгээр харах боломж өндөрсөх юм.



О.БАЯРЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, докторант, ахлах дэслэгч

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛАХАД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хураангуй: "Нийгмийн ажил нь хүмүүсийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд нь туслах, хүмүүсийн сайн сайхны төлөө тэдний эрх, эрх чөлөө боломжийг нь өргөжүүлэх, тэднийг чадваржуулахад нь чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа"[1] хэмээн тодорхойлсон байдаг. Тодруулж хэлбэл нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээний нэг онцлог нь өөрчлөлтөнд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд үйлчлүүлэгчдийг өөрсдийг нь оролцуулах замаар тэднийг чадваржуулахад голлон анхаардаг юм. Иймд сургууль дээрх хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр үйлчилгээ, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхдээ хүүхэд бүр ямар нэг ялгаварлалгүйгээр, тэгш оролцох боломжоор хангаж ажиллах нь сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулах ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: сургуулийн нийгмийн ажил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, чадваржуулах, оролцоо

Нийгмийн ажил хэмээх энэхүү мэргэжил нь манай оронд 1997 оноос систэмтэйгээр хөгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл 26 жилийн нүүрийг үзээд байна. Уг мэргэжлийн үндэс суурь нь анх сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээгээр эхэлсэн бөгөөд 2000 оны 4 дүгээр сарын 1-нд ЕБС-д нийгмийн ажилтан ажиллах тухай Гэгээрлийн болон ЭМНХ-ын сайдын хамтарсан 73/90 тоот тушаалаар гарснаар хууль эрх зүйн хувьд баталгаасан юм. Тухайлбал ".... хүүхдийн эрх ашиг нь зөрчигдсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч эрсдлийн нөхцөл шалтгааны судлан тогтоох, мэргэшсэн байгууллагад мэдээллэх, зуучлах, сэтгэл зүйн засал хийх, нөхөн сэргээх, зөвлөх, нийгэмшүүлэх, чадваржуулах, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тэтгэлэг хөнгөлөлт үйлчилгээнд хамруулах" хэмээн заажээ. Зарим улс оронд /тухайлбал АНУ[2]/ сургуулийн нийгмийн ажлын

[1] Н.Нямдорж, Г.Түмэннаст, Б.Мягмарсүрэн "Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага" УБ 2005 он

[2] Паул Аллен Мейрес, Роберт Вашингтон "Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ" УБ 2002 он

туршлагаас судлаж үзэхэд хүчирхийлэл үл хайхрах явдалд өртсөн хүүхэд залууст дараах төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлдэг байна.

Анхдагч урьдчилан сэргийлэлт:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үл хайхрах, гадуурхах асуудлыг судалж тогтоох, улмаар хүүхдийн халамж хамгааллын байгууллагатай холбоо тогтоох
- Дээрх тохиолдлуудыг мэдээлэх, нөхцөл байдлыг тодорхойлох, мөн энэ чиглэлийн хуулийн хариуцлагын талаар холбогдох хүмүүст сургалт явуулах хөтөлбөр, арга зүйн материал бэлтгэх
- Сургуулийн хүрээнд хүчирхийлэл гадуурхах үйл хайхрах явдлыг мэдээлэх журмыг боловсруулж мөрдөх
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбогдох бодлого, дүрэм журмыг боловсруулахад санал оруулах, хэрэгжүүлэхэд оролцох
- Насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийг хүчирхийлсэн бу/у үл хайхран эрхийг нь зөрчсөн шинжтэй аливаа үйлдлийг тодорхойлон таних, энэ талаар хүүхэд залуучууд юу хийж болох талаар боловсрол гэр бүлийн хөгжил, амьдрах ухааны чиглэлтэй хөтөлбөрүүдийг агуулгад тусгаж оруулах

Хоёрдогч урьдчилан сэрийлэлт:

- Хүчирхийлэлд өртсөн болон эрх нь зөрчигдсөн сурагчидтай ганцаарчлан ажиллах, тэдний гэр бүлийг дэмжих богино хугацааны арга хэмжээ авах, бүлгээр ажиллах болон хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
- Хүчирхийлэлд өртсөн болон үл хайхрагдсан, гадуурхагдсан хүүхдэд чиглэсэн шууд тусламж үзүүлэх талаар арга хэмжээ авах, анги хамт олон, эцэг эхтэй хамтран ажиллах, зөвлөгөө өгөх
- Хүүхэд, гэр бүл, сургууль, хууль хяналт, эмчилгээ үйлчилгээний байгууллагуудын хоорондох үйл ажиллагааг зохицуулах

Хямралын үеийн үйлчилгээ:

- Хүчирхийлэл, үл хайхрагдсан байдал гаргасан тохиолдлыг холбогдох хуулийн болон хүүхдийн халамж хамгаалал, эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх
- Сурагчдад сэтгэлзүйн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Шаардлагатай болон нөхцөл байдалд сургууль гэр бүлийн халамж хамгаалал, цагдаа, хууль хяналтын байгууллагуудын хоорондох холбон зуучлах
- Хүүхэд, гэр бүл, сургууль, хууль хяналт, эмчилгээ үйлчилгээний байгууллагуудын хоорондох үйлчилгээг зохицуулах
- Хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах тохиолдлыг мэдээлэх болон

бусад үйл явцад оролцсон багш болон бусад хүмүүст сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах

- Шаардлагатай болон эмнэлэгийн үйлчилгээнд хүргэх унаа тээвэр гэх мэт бусад асуудлыг зохицуулах

Эдгээр тусламж үйлчилгээнүүдийг хүргэх үүднээс юун түрүүнд сургууль түүний орчин, олон нийт, тэдгээрийн хөдлөл зүйг шинжлэн судалсны үндсэн дээр хүүхэд хамгааллын тусгайлсан хөтөлбөр үйлчилгээнүүдийг төлөвлөн боловсруулж, улмаар үйлчилгээний хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх хэлбэрээр ажилладаг болохыг Америк дахь сургуулийн нийгмийн ажлын практик туршлага харуулж байна.

Үүний зэрэгцээ сургуулийн нийгмийн ажилтны зүгээс хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртөх эрсдэл бүхий хүүхэд залуус, тэдний хүрээлэн буй орчинд чиглэсэн хэрэгцээтэй тусламж үйлчилгээнүүдийг үзүүлэхдээ доорх 3 түвшин бүхий зохион байгуулалтын арга хэлбэрүүдийг ашигладаг.

Хувь хүнд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ

Энэ нь ганцаарчилсан хэлбэрээр нийгмийн ажлын мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэх зохион байгуулалтын нэг арга хэлбэр бөгөөд хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэл бүхий хүүхэд, залуус тэдний гэр бүлийг үйл ажиллагаанд татан оролцуулах замаар тэдэнд тулгарсан хүндрэл бэрхшээлийг даван туулах асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэгддэг. Зарим тохиолдолд хүчирхийлэл үл хайхрах явдалд өртсөн сурагчидтай уулзаж ярилцах, тэдний өмнө тулгарсан хүндрэлтэй нөхцөл байдлыг үнэлж тогтоох, улмаар сэтгэл зүйн зөвлөгөө, засал болон бусад төрлийн тусламж үйлчилгээг ганцаарчилсан байдлаар үзүүлснээр илүү үр дүнгээ өгдөг болох нь практик туршлагаас нотлогдсон байдаг.

Гэхдээ энэ нь нийгмийн ажилтан шаардлагатай бүх төрлийн тусламж үйлчилгээг бие даан ганцаараа үзүүлэх гэсэн ойлголт хараахан биш юм. Өөрөөр хэлбэл хүчирхийллэл, дарамтанд өртсөн сурагчдыг шаардлагатай бол өөр бусад мэргэжлийн хүмүүс, эмч, сэтгэл зүйч, өмгөөлөгч нарт холбон зуучлах, үйлчилгээнүүдийгхооронднь зуучлах, хянах, үнэлэх хэлбэрээр ажиллах тохиолдол ч нэлээдгүй гардаг. Нөгөөтэйгүүр сургуулийн нийгмийн ажилтан хүчирхийлэл дарамтанд өртсөн хүүхдийн өмнөөс хийж гүйцэтгэх буюу асуудлыг шийдвэрлэх бус гагцхүү тэдний өөрсдийнх нь нөөц бололцоо, давуу талуудыг нь илрүүлэн дайчилж, оролцуулах замаар өөрчлөлтийг

өөрсдөө хийхэд нь дэмжин туслах буюу чадваржуулахад чиглэгддэг.

Түүнчлэн сурагчдад үүссэн нөхцөл байдлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ нь тухайн асуудалтай холбогдож байгаа болон нөлөөлж болох гэр бүл, эцэг эх, ойр дотны хүмүүс гэх мэт бусад бүх системд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх шаардлага ч тулгардаг. Учир нь хувь талаас нь асуудлыг шийдвэрлэсэн ч тухайн асуудлыг бий болгоход хүчтэй нөлөө үзүүлж буй систем /тухайлбал: гэр бүлийн систем/ талаас нь авч үзээгүйн улмаас асуудал дахин гарах магадлалыг нэмэгдүүлдэг. Тиймээс ч сургуулийн нийгмийн ажилтан нэг талаас хүчирхийлэлд өртсөн хүүхэд буюу үйлчлүүлэгчийг чадваржуулах нөгөө талаас гэр бүлийг бүхэлд нь нэгдмэл байдлаар авч үзэх хэрэгтэй болдог.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээ

Сургуулийн нийгмийн ажилтнуудын зүгээс хувь хүн болон сурагчдад тохиолдсон хүндрэл бэрхшээлийг арилгах, учирсан болоод цаашид гарч болзошгүй эрсдлийг бууруулах үүднээс сурагчдын дунд жижиг бүлгүүдийг зохион байгуулан тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан үйлчилгээ хүргэх аргыг түгээмэл хэрэглэдэг. Учир нь сургуулийн ихэнх үйл ажиллагаа бүлгийн хүрээнд зохион байгууллагддаг бөгөөд нийгмийн ажилтнуудын хувьд ч дээр аргыг хэрэглэхэд хамгийн тохиромжтой нь болж өгдөг. Хүүхдийн бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний онцлог нь нэг талаас тухайн бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулах, нөгөөтэйгүүр тухайн бүлгийн гишүүн болох хувь хүн буюу асуудал бүхий сурагчдад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Иймд нийгмийн ажилтан бүлэгтэй ажиллахад хувь хүнтэй ажиллахаас илүү ур чадвар дадлага туршлага шаардагдахын зэрэгцээ зөвлөгч, холбогч, хамтрагч, дэмжин туслагч, удирдан чиглүүлэгч, зохион байгууллагч гэх мэт олон янзын үүргүүдийг давхар гүйцэтгэдэг.

Хүчирхийлэл дарамтанд өртөх гэх мэт ижил төстэй асуудал, хүндрэл бэрхшээл бүхий хүүхдүүд нэг бүлэгт нэгдсэнээр цагийг үр ашигтай өнгөрүүлээд зогсохгүй, тулгарсан асуудал бэрхшээл сэтгэл санаагаа бусадтай хуваалцах, бие биенээсээ суралцах, шаардлагатай дэмжлэгийг бие биедээ үзүүлж, ахиц дэвшил гарахад нөлөөлөхийн зэрэгцээ нийгмийн харилцааны дадлаа хөгжүүлэх, өөртөө итгэх чадвараа нэмэгдүүлэх зэрэг олон талын давуу боломжуудыг гишүүдээ олгож байдаг.

Гишүүдийн хэрэгцээ сонирхол, зорилго зорилт, шийдвэрлэх асуудал зэргээс

хамааран бүлгийн янз бүрийн хэлбэрүүдийг сургуулийн нийгмийн ажилтнууд зохион байгуулж ажилладаг. Тухайлбал: өсөлт төвт бүлэг, чиглүүлэх бүлэг, зөвлөх бүлэг гэхчлэн олон хэлбэрүүдийг дурьдаж болно.

Америкт сургуулийн нийгмийн ажлын хувь хүн болон бүлэгт чиглэсэн шууд үйлчилгээг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хувь хүнд чиглэсэн шууд үйлчилгээнд хүчирхийлэл дарамтанд өртсөн сурагчдын нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийж, сурагчдыг өөрчлөх, тухайн сурагчдад биечлэн зөвлөгөө өгөх, цаг завгүй ачаалалтай ажилладаг эцэг эхчүүдэд утсаар зөвлөгөө өгөх, сэтгэлзүйн дарамтанд орсон багш нартай уулзаж ярилцах зэргийг багтаасан байна.

Бүлэгт чиглэсэн шууд үйлчилгээнд хоорондоо нийлж нөхөрлөдөг хэсэг бүлэг хүүхдүүдтэй тулж ажиллах, тэдгээрийн эцэг эхэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, сургуульд өөрчлөлт хийхийн тулд ажилчдыг идэвхжүүлэх уулзалт зохион байгуулах зэргийг багтаасан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн үр дагавар

Хүчирхийллийн аливаа хэлбэр нь дангаараа үйлдэгдэггүй ихэвчлэн хавсарсан шинжтэй байдаг. Хүүхдийн эсрэг үйлдэгдэх аливаа хүчирхийлэл дарамт нь хүүхдийн нийгэм сэтгэл зүйн байдал, бие бялдарын өсөлт хөгжил, зан төлвийн хүмүүжил зэрэгт олон янзын сөрөг үр дагаваруудыг авчирдаг.

Тухайлбал: Хүчирхийллийн улмаас

- Өөртөө итгэлгүй болж өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурах
- Сурч боловсрох идэвхи сонирхол, чадвар зэрэг нь суларч сургуулиас завсардах
- Хүүхэд өөрийгөө буруутгаж амиа хорлох оролдлого хийх
- Хараа хяналтгүй болон гудамжинд гарах
- Сэтгэцийн саатал эсвэл сэтгэцийн байнгын согогтой болох
- Гэмт хэрэгт холбогдох
- Согтууруулах ундаа болон мансууруулах бодист донтох
- Бага насаа хүчирхийлэл дарамтан дунд өнгөрүүлсэн хүн хожим нь өөрөө бусдыг хүчирхийлэгч болох тохиолдолд цөөнгүй байдаг... гэх мэт.

Нийгмийн ажлын практикт үйлчүүлэгчийг чадваржуулах тухай асуудлыг чухлаар авч үздэг бөгөөд энэхүү онол үзэл баримтлал нь “хүмүүс амьдралдаа тохиолдсон бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцох замаар өөрсдийн амьдралын чанараа сайжруулна” гэсэн санаан дээр тулгуурладаг. Тодруулж хэлбэл суралцагчдыг чадваржуулна гэдэг нь сургууль дээрх хүүхдийн эсрэг

хүчирхийллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс тэдний бусадтай харилцах харилцаа холбоог сайжруулж, бие даах чадварыг нь хөгжүүлэхийг хэлнэ. Парсон болон Симон нар “чадваржуулалт гэдэг нь сурагчид болон анги хамт олны эрх мэдлийг хөгжүүлж дээшлүүлэхэд чиглэсэн үйл явц” хэмээн тодорхойлсон байдаг. Сургууль дээрх хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд доор үйл ажиллагаануудаар дамжуулан сурагчдын оролцоог ханган чадваржуулна.

Чадваржуулах үйл явцдаа сурагчдын итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийг харгалзан оролцуулна. Учир нь тэдний өөртөө итгэх итгэл, өөрийгөө таних, өөрийнхөөрөө байх өөрийгөө хүлээн зөвшөөрөх гэх мэт чадварыг нь дэмжиж хөгжүүлснээр тэд чадваржаад зогсохгүй эргээд сургуулийнхаа орчинд ч тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлнэ.

Сурагчид бие биенээсээ суралцах тусламж дэмжлэг хүсэх, асуудлыг шийдвэрлэх шинэ чадварт суралцах өөртөө итгэлтэй байх зэрэг нь тэдний хамтын үйл ажиллагаа харилцааны явцад хөгжиж, харилцан туршлага солилцох нөхцөл болно. Хамтын үйл ажиллагааны явцад хүүхдүүд асуудлын учир шалтгааныг зөвхөн өөрийн байр сууринаас хараад зогсохгүй олон талаас нь олж харах чадварт суралцана. Сурагчид бусдын дэмжлэг туслалцаатайгаар өөрсдийн өмнө тулгарч байгаа сургууль дээрх хүчирхийлэлтэй холбоотой асуудлын дотоод гадаад хүчин зүйлсийн талаар шүүмжлэлтэйгээр эрэгцүүлэн бодож сурахын зэрэгцээ өөрийн итгэл үнэмшил ойлголтонд үнэлгээ дүгнэлт өгч улмаар асуудалтай холбогдох мэдээ мэдээллийг олж харах үйл ажиллагаанд оролцох байдлаар чадваржина.

Сурагчид сургууль дээрх хүчирхийллийг бууруулахад чиглэсэн өөрчлөлт хийх үйл ажиллагаанд оролцсоноор үйлчилгээний үр шимийг хүртэх орчиндоо нөлөөлөх мэдлэг чадвараа дээшлүүлэх, улмаар өөрсдийнхөө нийтлэг эрх ашиг зорилгын төлөө төлөөх хамтын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж, түүндээ хяналт тавих чадвартай болно.

Дүгнэлт

Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээнд сурагчдын талаас илүү хувь нь тодорхой хэмжээгээр оролцдог ч тэдний дунд зөвхөн мэдээлэл, үйлчилгээ хүлээн авах хэлбэрээр идэвхгүй байр сууринаас оролцох явдал нилээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр сурагчдын идэвхи оролцоо бага байхын хирээр хүүхдийн аюулгүй байдал хамгааллын асуудал ч тэр хэрээр алдагдаж, улмаар сургууль дээр

хүүхдүүд бусдын хүчирхийлэлд өртөх явдал ч нэмэгдэж байна. Сурагчид хүчирхийллийг бууруулах чиглэлээр аливаа үйл ажиллагаанд оролцсоноор эргээд бусдын хүчирхийлэл дарамтанд өртөх санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, сайн дурааараа оролцох боломж нөхцлөөр хязгаарлагдмал байх, бусад хүмүүсийн зүгээс оролцоог нь үл тоомсорлож, идэвхигүй хандах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон хүүхдийн оролцооны талаар хангалттай ойлголт мэдлэггүй байх, тэдгээрийг ялгаварлан оролцуулах зэрэг хүндрэл бэрхшээлүүдтэй тулгардаг байна.

Хүүхдийн эсрэг хүчирийлийг бууруулахад чиглэсэн сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж сурагчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд юун түрүүнд тэдний хэрэгцээ сонирхолыг харгалзан үзэж, ямар нэг ялгаварлал, дарам шахалтгүйгээр оролцох боломж нөхцлийг бүрдүүлэх, улмаар хүүхдийн эсрэг хүчирийллийн хор уршиг, хүүхдийн оролцооны ач холбогдлыг сурагчид болон тэдэнтэй ойр дотно харилцаа холбоотой ажилладаг хүн бүрт ойлгуулан таниулж, оролцоог нь нэмэгдүүлж хамтран ажиллах шаардлагатай байна.



Х.ЦЭГМИД
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн нууцын номын санч, хэл шинжлэлийн магистр, дэд ахлагч

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ УТГА, ДАВТАМЖ

Хураангуй: “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийг Хуулийн хэл шинжлэлийн үүднээс судлан нэр томьёо, хэлзүйн давтамжийг тодорхойлон, энэ нь хэл найруулгад ямар нөлөө үзүүлж буйг жишээ баримтаар батлан, судлаачийн дүгнэлт, саналыг илэрхийлэв.

Түлхүүр үгс: *ШШГТХ-ийн нэр томьёо, тооцоолох, давтамж гаргах, тогтоох*

Орчин үеийн хэл шинжлэлийн нэг томоохон салбар нь Forensic Linguistics буюу хууль, шүүхийн эргэн тойрон дох хэлний асуудлыг судалдаг ухаан агаад өнгөрөн зууны 60-80 онд үүсэн бий болохдоо эртний латин хэл дээрх хуулийг одоо үеийн ижил төстэй хуультай хэл найруулгын талаар харьцуулахаас эхэлжээ. Энэ чиглэл орчин үед шүүхийн үйл явцын хэлэнд дүн шинжилгээ хийх, гэрээ хэлэлцээрийн үг найруулгыг судлах, нэр томьёог шинээр боловсруулж, нэвтрүүлэх зэрэг нь хуулийг олон нийтэд ойлгомжтой болгох зорилгоор улам өргөн хүрээг хамарч хөгжиж байна.

Монгол улсад энэ талын судалгаа цөөн бөгөөд хууль эрх зүйн баримтад орж, батлагдсан нэр томьёог ойлгуулах зорилгоор тайлбарласан толь бичгийг академич С.Нарангэрэл, академич Ж.Амарсанаа нар гаргаж нийтийн хүртээл болгожээ. Гэвч хуульд орж батлагдсан хэрнээ хэл найруулгын алдаатай, цаашид хэл найруулгын үүднээс боловсруулмаар хууль цөөнгүй байдаг. Нөгөө талаар хуулийн хэл найруулга, нэр томьёог хэл шинжлэлийн үндэстэйгээр засаж, цаашид нэмэлт өөрчлөлт оруулж болохыг мэргэжлийн хуульчид ч зөвшөөрдөг. Энэ үүднээс нэг хуулиар жишээ болгон өөрийн ажиллаж буй салбарын буюу “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийг сонгон авч текст боловсруулах /TextStat/ программыг ашиглаж бодит судалгаа хийлээ.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн нэр томьёоны утга

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд олон давтагдаж буй шүүхийн шийдвэр, эд хөрөнгө, шийдвэр, төлбөр гэх зэрэг дан болон нийлмэл үгээс бүтсэн нэр томьёог ухагдахууны үүднээс буюу хуулийн нэр томьёоны тайлбар толиудад хэрхэн тайлбарласан, эдгээр нь олон нийтэд тайлбарсан тайлбараас ямар ялгаатайг “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар” тольтой харьцуулан утгын ялгааг гаргахыг зорив. Тухайлбал:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд (англ. party; ор. сторона)

❖ Утга: 1. Иргэний хэргийн шүүх хуралдаан арбитрын хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч, зохигчид; 2. Эрүүгийн шүүх хуралдаанд тэгш эрхтэйгээр мэтгэлцээнд оролцож, яллах, өмгөөлөх, чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээд[1].

❖ 3. Төлбөр төлөгч, төлбөр авагчийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд гэнэ[2].

❖ Төлбөр авагч нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзэж, түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх хуудсанд заасан иргэн, хуулийн этгээд байх, төлбөр төлөгч нь гэрээний ба гэрээний бус үүргийг биелүүлээгүйгээс бусад гэм хор учруулсан гэж гүйцэтгэх хуудсанд заасан иргэн, хуулийн этгээд байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэд хэдэн төлбөр авагч, төлөгч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд оролцож болно[3] гэснээс нэр томьёоны тайлбарыг харвал эрх зүйн эх толь бичигт Иргэний хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны үүднээс тайлбарласан байна. Харин "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дээрх нэр томьёог тайлбарлан нэг мөр ойлгон хэрэглэж байна.

- Төлбөр авагч (англ. receiver)

❖ Утга: Хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж, түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ[4].

- Төлбөр төлөгч

❖ Төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ[5].

- Гуравдагч этгээд (англ. third parties persons; ор. Третьи лица)

❖ Утга: Иргэний байцаан шийтгэх ажиллагаанд бусад этгээдийн үүсгэсэн иргэний хэрэгт хуулиар хамгаалагдсан өөрийн эрх ба ашиг сонирхлыг хамгаалж буй этгээд[6].

❖ Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны өөрийн болон нэхэмжлэгч, хариуцагчийн, эсвэл аль нэгний нь эрх ашгийг хамгаалахаар оролцож буй этгээд[7] гэснээс нэр томьёоны утгыг харвал "Эрх зүйн эх толь бичиг" дэх утга нь зүйтэй байна. Гуравдагч этгээдийг бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд, бие даасан шаардлага гаргах эрхгүй гуравдагч этгээд гэж 2 хуваадаг. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хуулийн 21.5-д "Бие даасан шаардлага гаргасан

[1] Нарангэрэл.С.Эрх зүйн эх толь бичиг.Уб.,2011.х.417

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.Уб.,2002.21.1 дэх заалт

[3] Амарсанаа.Ж, Баясгалан.Г, Бямбаа.Ж, Мөнхжаргал. Т, Совд.Г, Уранцэцэг.Г. Хууль зүйн тайлбар толь. 2003.х.346

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб.,2002.21.2 дэх заалт

[5] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.Уб.,2002.21.3 дахь заалт

[6] Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Уб.,2011.х.115

[7] Амарсанаа.Ж, Баясгалан.Г, Бямбаа.Ж, Мөнхжаргал.Т, Нарангэрэл.С, Совд.Г, Уранцэцэг.Г Хууль зүйн тайлбар толь. Уб., 2003.х.67

гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож болно гэж заасан байна. “Бие даасан шаардага гаргасан гуравдагч этгээд”-ийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж байгаа төлбөр төлөгч болон төлбөр авагчаас бусад этгээдийг ойлгоно гэж улсын дээд шүүхээс тайлбарлажээ[8].

Бид дээрх нэр томьёоны тайлбарыг уншиж, харьцуулан үзэхэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, түүнийг тайлбарлах эрх бүхий байгууллага буюу Улсын дээд шүүхээс тайлбарлан нэг мөр ойлгон хэрэглэж байна.

Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэгддэг дараах нэр томьёог бусад хууль тогтоомжид тайлбарласнаар ойлгон хэрэглэж байна. Үүнд:

• Сэжигтэн (англ. Suspect; ор. подозреваемый)

❖ Утга: Эрүүгийн хэрэг үүссэн буюу гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдсэн албадан саатуулагдсан буюу ял сонсохоос өмнө таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээд[9].

❖ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу хэрэг үүсгэж сэжигтнээр татагдсан этгээд[10].

❖ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж сэжигтнээр тооцож тогтоолд дурдагдсан этгээд[11] гэсэн утгуудыг харвал хууль зүйн тайлбар толь болон эрүүгийн хуульд утга нь явцуу бол Эрх зүйн эх толь бичигт илүү тодорхой, өргөн утгаар тайлбарласан байна.

• Яллагдагч (англ. Accused; ор. обвиняемый)

❖ Утга: Монгол улсын “Эрүүгийн байцаан шийтгэх хууль” -д заасан журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээд. Яллагдагчийг шүүгдэгч гэж нэрлэнэ. Шүүгдэгчийн хувьд шийтгэх тогтоол гарсан бол ялтан гэж нэрлэгдэнэ. Цагаатгах тогтоол гарсан бол цагаатгагдсан этгээд хэмээн нэрлэгдэнэ[12].

❖ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу тогтоол үйлдэгдэж, яллагдагчаар татагдсан этгээд, ял хүлээж буй хүн[13].

❖ Гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлогдсон гэж “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн дагуу хэрэг бүртгэгч тогтоол үйлдэж яллагдагчаар татсан этгээд[14].

---

[8] Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, тогтоолын дугаар 43)

[9] Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2011.х.413

[10] Амарсанаа.Ж, Баясгалан.Г, Бямбаа.Ж, Мөнхжаргал.Т, Нарангэрэл.С, Совд.Г, Уранцэцэг.Г Хууль зүйн тайлбар толь. Уб., 2003.х.235

[11] Эрүүгийн хууль “ Эрүүгийн хэрэг” эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. Уб., 2013.х.161

[12] Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2011.х.684

[13] Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 2008.х.3259

[14] Амарсанаа.Ж, Баясгалан.Г, Бямбаа.Ж, Мөнхжаргал.Т, Нарангэрэл.С, Совд.Г, Уранцэцэг.Г Хууль зүйн тайлбар толь. Уб., 2003.х.383

❖ Хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагч гэнэ[15]. Эдгээр нэр томьёоны утгыг харвал эрх зүйн эх толь бичигт байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг дэлгэрэнгүй тайлбарласан байна. Яллах тогтоол үйлдсэн л бол яллагдагч болно. Заавал байцаалт явуулах албагүй. Харин монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь болон Хууль зүйн тайлбар тольд хууль зүйн агуулгыг бүрэн илэрхийлж чаджээ.

- Торгох ял

❖ Утга: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ[16] ... гэх мэт.

Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэдэг дараах нэр томьёог хууль тогтоомжид тайлбарлаагүй байна.

Тухайлбал: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, тогтоол гүйцэтгэх ажиллагаа, чанга дэглэм, жирийн дэглэм, хамгаалалтын бүс гэх зэрэг нэр томьёог хуульд гагцхүү ямар тохиолдолд хэрэглэх үндэслэл, журмыг хуулиар тогтоосон боловч нэр томьёоны хувьд тайлбарлаагүй байна.

Хуулийн нэр томьёог хууль тогтоомжид тайлбарлаагүйгээс практикт уг нэр томьёог өөр өөрөөр ойлгон, өөрт ашигтай хэлбэрээр тайлбарлах, хэрэглэх үзэгдэл түгээмэл гардаг бөгөөд энэ нь хууль зүйн алдаа, хийдлийг бий болгоход ч хүргэх аюултай байдаг. Мөн нэр томьёог буруу ойлгосноос хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлийг бий болгодог.

Иймээс хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хуулийн нэр томьёо нэн чухал юм.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн нэр томьёо, түүний давтамж

Хуулийн хэл найруулга, түүний үгийн санд нэр томьёо чухал үүрэгтэйг судлаачид өөрсдийн бүтээл туурвилдаа бичиж, найруулгын өнгө аяс, түүний давтагдах чанарын талаар саналаа дэвшүүлсэн байдаг. Бид энд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль дахь нэр томьёо түүний үүрэг, эзлэх хувь, давтамжийг textstat программ ашиглан нарийвчлан үзсэний үндсэн дээр хууль дахь нэр томьёоны оролцоог илүү бодитой илэрхийлэх зорилго тавьсан болно.

Textstat программыг ашиглаж нэр томьёоны давтамжийг тогтооход “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд давтагдсан тоогоор нийт ***4078***, дангаараа ***2660*** нэр томьёо байна. Тухайлбал:

[15] Эрүүгийн хууль. “Эрүүгийн хэрэг эрх зүйн баримт бичгийн эхтэтгэл”.Уб.,2013.х.162

[16] Эрүүгийн хууль “Эрүүгийн хэрэг” эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл.Уб.,2013.х.19

	Нийлэмж нэр томьёо	Давтамж	Дан нэр томьёо	Давтамж
1.	Эд хөрөнгө орсон хоршоо үт	270	Гүйцэтгэх	359
2.	Шийдвэр гүйцэтгэх	244	Шийдвэр	331
3.	Шийдвэр гүйцэтгэгч	183	Дугаар	294
4.	Төлбөр төлөгч	178	Эд	267
5.	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	117	Төлбөр	266
6.	Төлбөр авагч	112	Заасан	223
7.	Хорих анги	102	хуулийн	201
8.	Албадан дуудлага худалдаа	68	нь	190
9.	Шүүхийн шийдвэр	67	болон	168
10.	Шийтгэх тогтоол	64	бол	153
11.	Хуулийн этгээд	61	Хорих	142
12.	Үйл ажиллагаа	61	Сарын	135
13.	Хорих ял	45	Оны	132
14.	Шийдвэр гүйцэтгэх алба	42	Шүүхийн	130
15.	Гүйцэтгэх бариыт бичиг	30	Зүйл	126
16.	Бариыт бичиг	22	Тухай	125
17.	Хууль тогтоомж	20	Гүйцэтгэгч	124
18.	Гэмт хэрэг	14	Байгаа	123
19.	Нутаг дэвсгэр	14	Энэ	118
20.	Өртэй этгээд	14	Бусад	117
21.	Хорих байгууллага	13	Дүгээр	110
22.	Онцгой дэглэмтэй хорих анги	13	Хуулиар	110
23.	Гүйцэтгэх ажиллагаа	11	Эрх	109
24.	Асран хамгаалагч	11	Ял	106
25.	Харгалзан дэмжигч	10	Өдрийн	102
26.	Баривчлах байр	9	Албадан	100
27.	Гуравдагч этгээд	8	Бариыт	100
28.	Торгох ял	8	Энэ	100
29.	Хүүхдийн тэтгэлэг	7	Дуудлага	99
30.	Мэдэгдэх хуудас	5	Хөрөнгийг	99
31.	Тэмдэглэл хөтлөгч	5	Хөрөнгө	89
32.	Хөндлөнгийн гэрч	4	Зүйлийн	78
33.	Цагдан хорих байр	4	Байгууллагын	76
34.	Мэдэгдэх хуудас	4	Ажиллагаа	72
35.	Тогтоол гүйцэтгэх газар	4	Хууль	72
36.	Нутаг дэвсгэр	3	Шийтгэх	69
37.	Эрх залгамжлагч	3	Байгууллага	65
38.	Гэм хор	1	Төлөгчийн	64
39.			Төлөгч	56
40.			Эзгээд	53
41.			Шийдвэрийг	53
42.			Этгээдийн	51
43.			Ялтныг	50
44.			Авагч	45
45.			Газрын	41
46.			Анги	39
47.			Хөдөлмөрийн	39
48.			Оногдуулсан	38
49.			Тогтоол	38
50.			Иргэн	35
51.			Ялыг	34
52.			Шийдвэр	33
53.			Шүүх	32
54.			Анги	32
55.			Хэрэг	32
56.			Ялтан	31
57.			Гүйцэтгэгчийн	31
58.			Тайлбар	31
59.			Хяналт	30
60.			Дэглэмтэй	31
61.			Худалдан	31
62.			Эрхэлсэн	30
63.			Зардлыг	30
64.			Худалдаа	30
65.			баривчлах	29

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль дахь нэр томьёог бүтэх аргын үүднээс судлан давтамжаар тооцоолон гаргахад дагаврын арга, үг нийлэх арга л голлож байна. Хууль дахь үүсмэл нэр томьёо бүтээж хамгийн идэвхтэй хэрэглэгдэж буй дагавруудын давтамжийг Textstat программыг ашиглаж тогтооход:

№¤	Дагавар¤	Давтамж¤	Жишээ¤
¶ 1.¤	-бар·–бэр–бөр·–вар·–вэр¤	¶ 1043¤	Сал+бар=салбар,· тайл+бар=тайлбар,· хуул+бар=хуулбар,· хэл+бэр=хэлбэр,· шийд+вэр=шийдвэр,· шийд+гэ+вэр=шийтгэвэр,· тэтгэ+вэр=тэтгэвэр,· дуусга+вар=дуусгавар,· тат+вар=татвар,· чад+вар=чадвар,· найд+вар=найдвар,·тел+бөр=телбөр·...·гэх·мэт¶ Тайлбар:· -бөр· дэгавар· нь· 337· удаагийн· давтамжтайгаар· ганцхан· тел+бөр=телбөр· хэмээх·нэр·үг·үүсгэж·байна.·¤
¶ ¶ ¶ 2.¤	¶ ¶ -гч¤	¶ ¶ 784¤	Гүйцэтгэ+гч=гүйцэтгэгч,· зохь+гч=зохигч,· яллагд+гч=яллагдагч,· · · хадгал+гч=хадгалагч,· хадгалуул+гч=хадгалуулагч,· өвлө+гч=өвлөгч,· нэхэмжлэ+гч=нэхэмжлэгч,· хариуц+гч=хариуцагч,· ав+гч=авагч,· тел+гч=телөгч,· телөөл+гч=телөөлөгч,· хамгаал+гч=хамгаалагч,· дэмж+гч=дэмжигч,· хөтлө+гч=хөтлөгч,· оролц+гч=оролцогч,· захир+гч=захирагч,· залгамжла+гч=залгамжлагч,· емгөөл+гч=емгөөлөгч,· байцаа+гч=байцаагч,· орчуул+гч=орчуулагч,· барьцаал+гч=барьцаалагч,· шүү+гч=шүүгч,· хаа+гч=хаагч·...·гэх·мэт··¤
¶ ¶ ¶ 3.¤	¶ ¶ -лт¤	¶ ¶ 475¤	Байгуул+лт=байгуулалт,· заа+лт=заалт,· зөрь+лт=зөрилт,· нэм+лт=нэмэлт,· хэрэгж+лт=хэрэгжилт,· хяна+лт=хяналт,· биел+лт=биелэлт,· сурга+лт=сургалт,· хүс+лт=хүсэлт,· санхүү+ж+лт=санхүүжилт,· өөр+чил+лт=өөрчлөлт,· тодорхой+л+лт=тодорхойлолт,· хүс+лт=хүсэлт,· жагсаа+лт=жагсаалт,· дүн+нэ+лт=дүгнэлт,· хамгаал+лт=хамгаалалт,· дурсга+лт=дурсгалт,· зориул+лт=зориулалт,· амар+лт=амралт·...··гэх·мэт·¤
¶ 4.¤	-лага¶ -лого¤	¶ 307¤	Байгуул+лага=байгууллага,· хариу+ц+лага=хариуцлага,· шаард+лага=шаардлага,· дуу+д+лага=дуудлага,· удирд+лага=удирдлага,· сур+лага=сурлага,· дад+лага=дадлага,· ор+лого=орлого,·бод+лого=бодлого·...·гэх·мэт·¤
¶ 5.¤	¶ -мж¤	¶ 280¤	Захь+р+мж=захиамж,· чад+мж=чадамж,· тогт+оо+мж=тогтоомж,· хадгал+мж=хадгаламж,· тэтгэ+мж=тэтгэмж,· битүү+мж=битүүмж,· бол+мж=боломж,· үз+мж=үзэмж,· илгээ+мж=илгээмж,· техөөр+мж=техөөрөмж· ...· гэх·мэт·¤
6.¤	-гаа¤	256¤	Ажил+ла+гаа=ажиллагаа,· лав+ла+гаа=лавлагаа,· бат+л+гаа=баталгаа· ...· гэх·мэт·¤
7.¤	-тан·–тэн¤	183¤	Ял+тан=ялтан,· алба·тушаа+л+тан=тушаалтан,··сэжиг+тэн=сэжигтэн,· эрх+тэн=·эрхтэн·...·гэх·мэт·¤

Эндээс нэг дагавар олон давтагдаж буйг –гч дагаврын 780 удаагийн давталтаас харж болно. Энэ нь нэг талаар хуулийн салбарт нэр томьёо үүсгэх идэвхтэй дагавар боловч нөгөө талаар шинэ дагавраар нэр томьёо үүсэх боломжийг багасгаж байна. Давтамж нь өөр нэр томьёо бүтэх үүсвэрийг багасгахаас гадна найруулгыг нэлээдгүй сулруулдаг.

Монгол хэлнээ нэр томьёо бүтээж болох 10 орчим арга хэрэгслээс зөвхөн дагаврын болон үг нийлэх аргыг хэрэглэсэн нь нэр томьёо бүтээх аргыг явцууруулж байна. Энэ нь хууль орчуулгын чанартай, нөгөө талаас хэлний мэргэжилтнүүдийг оролцоо багаас үүсэлтэй.

ДҮГНЭЛТ

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийг Хуулийн хэл шинжлэлийн үүднээс судлан түүний нэр томьёо болон хэлзүйн хэлбэрийг TextStat хэмээх тооцоолох программаар давтамжийг гарган утга, бүтэц, хэлбэрийн түвшинд судалгаа хийгээд дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Монгол улсад өдгөө мөрдөгдөж буй 544 бие даасан хуулийн дотроос 20 бүлэг, 144 зүйл бүхий "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хуулийн үгийн сангийн болон хэлзүйн хэлбэрийг бүхэлд Textstat программаар тооцоолон үзэхэд давтагдсан тоогоор ***4078***, дан ***2660*** үгтэй байгаа нь хуулийн үгийн сангийн дундаж тоог гаргахад тустай юм.

2. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хуулийн нэр томьёоны тайлбарыг хууль тайлбарлах эрх бүхий байгууллага буюу Улсын дээд шүүхээс тайлбарлан нэг мөр болгон хэрэглэж байна. Тухайлбал: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд [17] Төлбөр авагч[18], төлбөр төлөгч[19], бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд[20]... гэх мэт. Гэвч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэдэг *албадан дуудлага худалдаа, чанга дэглэм, жирийн дэглэм, хамгаалалтын бүс* зэрэг нэр томьёог аль нэгэн хууль тогтоомжид тайлбарлаагүй байна.

3. Энэ нь хуулийн практикт уг нэр томьёог өөр өөрөөр ойлгон, өөрт ашигтай хэлбэрээр тайлбарлах, хэрэглэх үзэгдэл түгээмэл гардаг бөгөөд энэ нь хууль зүйн алдаа, хийдлийг бий болгоход ч хүргэх тул цаашид нэр томьёоны тайлбар хийх нь зүйтэй.

4. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хууль дахь нэр томьёог бүтэх аргын үүднээс судлан үзэхэд, монгол хэлнээ нэр томьёо бүтээж болох 10 орчим арга хэрэгслээс зөвхөн дагаврын болон үг нийлэх аргыг хэрэглэсэн нь нэр томьёо бүтээх аргыг явцууруулж байна. Энэ нь хууль орчуулгын чанартай, нөгөө талаас хэлний мэргэжилтнүүдийн оролцоо бага байгаагаас үүсэлтэй.

---

[17] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.Уб.,2002. 21.1 дэх заалт.

[18] Мөн хуулийн 21.2.дахь заалт.

[19] Мөн хуулийн 21.3 дахь заалт.

[20] Улсын дээд шүүхийн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 43-р тогтоол.

5. Монгол хэлний нэр томьёоны бүтэх үндсэн хэв маяг нь дагаврын арга юм. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн нэр томьёо үүсгэгч дагаврууд давтамжийг хэдэн дагавар дээр жишээлэн тогтооход -бар[3], -вар[2] дагавар **1043**, –гч дагавар дангаараа хамгийн идэвхтэй хэрэглэгдэж **784,** -лт дагавар **475,** -лага[2] дагавар **307,** -**мж** дагавар **280**, -гаа[4] дагавар **183** удаагийн давтамжтай байсан. Үүнээс дүгнэвэл энэ хуульд нэр үг бүтээх дагавраас маш цөөн тоотойг, давтамж өндөртэйгээр хэрэглэсэн нь харагдах агаад тухайн салбартаа нэр томьёо бүтээх боломжийг бүрэн ашиглаагүй байна.

НОМ ЗҮЙ

1. Амарсанаа.Ж, Баясгалан.Г, Бямбаа.Ж, Мөнхжаргал.Т, Нарангэрэл.С, Совд.Г, Уранцэцэг.Г. Хууль зүйн тайлбар толь. Уб., 2003, 398.х
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.I.Уб.,2008, 594.х
3. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.II.Уб.,2008, 1176.х
4. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.III.Уб.,2008, 1858.х
5. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.IV.Уб.,2008, 2650.х
6. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.V.Уб.,2008, 3278.х
7. Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2011, 699.х
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2002
9. Эрүүгийн хэрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. Уб.,2013, 540.х
10. www.google.mn
11. legalinfo.mn
12. Textstat.2.9



Ш.ЭНХЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч

ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Хураангуй: Монгол улс дахь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн ялын бодлогод орсон хорих ялын өөрчлөлтийн талаар онцлон судалсан.

Монгол Улсад хамгийн анхны Эрүүгийн хуулийг 1926 онд "Шүүх цаазын бичиг" хэмээх нэртэйгээр батлан гаргаснаас хойш 1929, 1934, 1942, 1951, 1961, 1987, 1993, 2002 онуудад өөрчлөн шинэчилж байжээ. Тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой эрүүгийн хууль уялдаж байсан. Тухайлбал, 1987 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлтийг оруулж байжээ. Тухайн үед амины болон социалист гэсэн өмчийн хоёрхон хэлбэрийг зөвшөөрч байсан билээ. Гэтэл Японы Элчин сайдын яамнаас хоёр ширхэг булган малгай алдагдсан хэрэг гарчээ. Хэргийг шийдвэрлэх гэтэл тухайн үеийн эрүүгийн хуульд капиталист өмчийн тухай заалт байгаагүй учир гацаанд орж байсан гэдэг. Дараа нь Гандантэгчинлэн хийдэд хулгай орсныг бас л өмчийн хэлбэрийг нь тогтоож чадаагүй учраас шийдвэрлэж чадаагүй байна. Иймд 1987 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гадаад улсын өмчийн болон шашны болон олон нийтийн өмчийн эсрэг гэмт хэрэг гэсэн зүйл заалтыг нэмж оруулж байжээ.[1]

Харин 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр сонгогчид... -"2002 оны Эрүүгийн хуулийн хууль амьдралд нийцэхгүй байгаа талаар..." үзэл бодлоо УИХ-ын гишүүнд нэр дэвшигчдэд олонтаа илэрхийлж байсан байна. Хуульчид ч бас эрүүгийн хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг дурьдаж байсан.

2002 оны Эрүүгийн хууль нь зарим талаар шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял сонгож хэрэглэх боломжийг алдагдуулж, эрүүгийн хуульд бичсэн ялыг л шийтгэхдээ тогтоолдоо бичихээс өөр аргагүй байдалд хүргэж, монголын нийгэмд шоронжих үйл явцын хөрс суурийг тавьсан юм.[2] гэж үздэг.

---

[1] http://amnesty.mn/files/aim/docs/files/2010/03/file-57.pdf

[2] Шинэчилсэн эрүүгийн хуулийн төсөл санаачлагчид

Ийм учраас Эрүүгийн хуулийн шинэ бодлогод хорих ялын тоог буруулах, хорихоос өөр төрлийн ял оноох хэлбэрийг сонгох замыг баримталсан гэж хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийнхэн хэлжээ. Энэхүү тайлбар бодит байдалд хэрхэн нийцсэн талаар судалж үзэхэд;

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд 238 гэмт хэрэг байгаагаас 209 гэмт хэрэгт хорих ял оногдуулсан, 29 гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял дагнан оногдуулсан байна. Хүснэгтээр дэлгэрэнгүйгээр харуулбал:

Д/д	Гэмт хэргийн төрөл	Хамаарах гэмт хэрэг	Хорих ял оноосон гэмт хэрэг	Хорихоос өөр төрлийн ял оноосон гэмт хэрэг
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	13	0
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	17	15	2
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	6	5	1
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	16	14	2
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	16	7	9
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	13	10	3
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	25	24	1
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	18	17	1
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	10	10	0
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	14	14	0
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	11	11	0
12	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	4	0
13	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	15	11	4
14	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	18	14	4
15	Албан тушаалын гэмт хэрэг	12	10	2
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	22	22	0
17	Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайваны эсрэг гэмт хэрэг	8	8	0
Нийт		238	209	29

Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд 206 гэмт хэрэг байгаагаас 206 гэмт хэрэгт хорих ял оногдуулахаар хуульчилсан байна.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Хамаарах гэмт хэрэг	Хорих ял оноосон гэмт хэрэг	Хорихоос өөр төрлийн ял оноосон гэмт хэрэг
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	6	6	0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	7	0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, гэмт хэрэг	5	5	0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	13	13	0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	9	9	0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	6	6	0
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	11	11	0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	12	12	0
9	Эдийн засгийн гэмт хэрэг	13	13	0
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	17	0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	16	16	0
12	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	14	14	0
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	12	12	0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	7	7	0
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	9	9	0
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	6	6	0
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	3	0
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	11	11	0
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	19	19	0
20	Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайваны эсрэг гэмт хэрэг	10	10	0
Нийт		206	206	0



Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд нийт гэмт хэргийн 12,2%-д хорихоос өөр төрлийн ял дагнан оногдуулахаар заасан бол, шинээр батлагдсан эрүүгийн хуульд 100% хорих ял оногдуулсан санкцитай байна. Энэхүү судалгаанаас харахад нийгмийг шоронжих байдлаас гаргана гэсэн зорилгодоо хүрч чадаагүй байна гэж үзэж болохоор байна.

Шинэ Эрүүгийн хуулийн ялын төрөлд баривчлах ялыг хассантай холбогдуулан хорих ялын хэмжээ 7 хоногоос 20 жил, цаашлаад бүх насаар нь хорихоор хуульчилжээ.

Д/д	7 хоногоос эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг	1 сараас эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг	3 сараас эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг	Бүх насаар нь хорих ял оногдуулсан гэмт хэрэг
1	11.6, 11.7, 13.5, 13.6, 16.7, 17.1, 17.5, 17.11, 20.15, 21.8, 24.6, 28.13.	10.5, 11.2, 11.3, 11.4, 11.5, 12.2, 12.4, 12.5, 13.7, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 15.1, 15.2, 16.8, 16.10, 16.11, 17.3, 17.4, 17.7, 17.8, 17.9, 18.2, 18.5, 18.6, 18.10, 18.11, 19.11, 19.13, 19.16, 20.12, 20.14, 21.5, 21.7, 21.9, 21.10, 21.11, 22.2, 22.4, 22.5, 22.10, 22.11, 22.12, 23.1, 23.2, 23.3, 23.4, 23.5, 25.1, 25.2, 25.3, 25.4, 25.6, 27,4, 27.7, 27.10, 27.11, 28.1, 28.3, 28.4, 28.5, 28.6, 28.7, 28.11, 28.14, 28.15, 28.19, 29.2.	17.2, 18.1, 18.3, 18.8, 18.9, 19.14, 19.15, 19.17, 21.1, 21.2, 21.3, 26.1, 28.10,	12.1, 19.1, 19.3, 19.4, 19.5, 19.6, 29.1, 29.4, 29,5, 29.7, 29.8.
2	Нийт 12 гэмт хэрэгт	Нийт 77 гэмт хэрэгт	Нийт 13 гэмт хэрэгт	Нийт 11 гэмт хэрэгт

Сонирхуулж хэлэхэд шинэ Эрүүгийн хуульд 40 гэмт хэрэг шинээр орсон байна. Тухайлбал: баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлэн хүнийг алах-10.3 /одоогийн Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй байгаа/, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх-11.7, заналхийлэх-13.5, албадан хөдөлмөрлүүлэх-13.13, хүүхдийг шийтгэх-16.7, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах-16.9, хууль бусаар газар орны нэр өөрчлөх-19.16, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах-22.12, нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох-27.4 гэх мэт заалтууд байна.

Энэхүү судалгаанаас харахад хүнд ба онц хүнд гэмт хэрэг, террорист явуулга, зохион байгуулалттай гэмт явдал үйлдсэн этгээдийн хувьд ялын хатуу чанга байлгах бодлогыг баримталсан байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахлах дэслэгч

ТОРГОХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд хэрэглэж ирсэн үндсэн ялын нэг бол торгох ял. бусад ялтай харьцуулахад хамгийн хөнгөн ял бол торгох байхаар хуульчилсан байна. Эрүүгийн хуульд заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялыг Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлд тодорхойлсон байна. Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжинд заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан. Ингэж хуульд заасан нь торгох ялын хэмжээ нийгэм эдийн засгийн өөрчлөлт, мөнгөний ханшийн өөрчлөлттэй цуг өөрчлөгдөж байх уян хатан механизм болсон.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасанчлан ялыг долоон төрөлд хуваан авч үздэг ба ял нь дотроо үндсэн, нэмэгдэл ял гэсэн төрөлтэй байна. Ялын эдгээр төрлүүдийг мөн чанар, эдлүүлэх арга хэлбэрийг харгалзан Үндсэн ялын хэсэгт торгох, баривчлах, албадан ажил хийлгэх, хорих, цаазаар авах ялуудыг, нэмэгдэл ялын хэсэгт эд хөрөнгө хураах ялыг оруулдаг ба тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын аль алинаар нь хэрэглэх боломжтой гэж үздэг байна.

Үүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил гүйцэтгэгддэгээрээ онцлогтой юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасанчлан шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэж заасан байдаг. Энэ ялыг дэлхий нийтийн ихэнх орнууд түгээмэл хэрэглэдэг бөгөөд хэрэг үйлдсэн этгээдийн эдийн засгийн эрхэнд шууд халдан цээрлүүлэх хэлбэрийн материаллаг шинжтэй байдагаараа бусад ялаас онцлогтой юм. Торгох ял нь эрүүгийн харйуцлагын нэг төрөл бөгөөд гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр нотлогдсон этгээдийн эрхэнд шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоож буй төрийн албадлагын онцгой арга хэмжээ юм. Энэ ялын хэмжээг зөвхөн эрүүгийн хуулиар тогтоож, түүнд заасан зарчим, журмыг баримтлан оногдуулдаг ба ялын

биелэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцдаг байна.

Торгох ялын онцлог

2002 оны 9 дүгээр сараас хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар торгох ялыг 24 төрлийн зүйл ангид хэрэглэхээр заасан байдаг.

Торгох ялыг хөнгөн, хүндэвтэр, хүнд гэм хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэдэг хөнгөн төрлийн ял юм.

Торгуулийн ялыг төлүүлэх арга хэлбэр нь улс болгонд өөр өөр байдаг байна. Жишээ нь: Швед улсад торгох ял нь дотроо гурван хэлбэртэй байдаг байна.Үүнд:

- Өдрөөр / тодорхой цалин хөлсөөр ажил хийлгэн төлбөрт нь хийлгэдэг/
- Санхүүгийн аргаар /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэгчлэн/
-Стандарт хэм хэмжээгээр /мөнгөний хэмжээг тодорхой зааж өгөн төлүүлдэг /

Дээрх байдлаар торгодог ба тухайн мөнгийг төлөхгүй бол 3 сар хүртэл хугацаагаар хоридог байна.

Манай улсад торгох ялыг дараах байдлаар хэрэгжүүлдэг:

Торгох ялыг гүйцэтгэх ажиллагааг дэс дарааллаар нь авч үзвэл:

Ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарсанаас хойш ялтан 14 хоногын дотор сайн дурааараа биелүүлэх үүрэгтэй, энэ хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг ялтны оршин суугаа, ажиллаж байгаа, эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлдэг.

- Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол үйлдэж 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлдэг.
- Шийдвэр гүйцэтгэгч нь уг шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор торгуулийн мөнгийг төлүүлэх, тухайн хугацаанд торгуулийн төлөөгүй бол ялыг албадан гүйцэтгэх, байцаан шийтгэх ажиллагаа явуулдаг байна.
- Тухайн ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар уг ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон прокурорын байгууллагад мэдэгддэг.

Ялтан долоо хоногийн хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөнөөс албадан гаргуулах ажиллагааг явуулна. Ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, цалин орлогоо нуух эсхүл бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэн алга болгох, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнгын оршин суух хаяг, газраа өөрчлөх мэтээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих ажиллагаа явуулан

торгох ялыг хорих, баривчлах ялаар солих саналаа прокурорт гаргах бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн санал прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хуульд заасны дагуу торгох ялыг хорих ялаар солидог байна.

Торгох ялаас **ноцтойгоор** /шийдвэр гүйцэтгэгч торгуулийн ялыг биелүүлэх ажиллагааг явуулахад учирдаг хамгийн том тулгамдаж байгаа асуудал бол торгох ялыг биелүүлэхээс ноцтой зайлсхийх гэсэн Эрүүгийн хуулинд заасан үндэслэл/ зайлсхийвэл уг ялын хэмжээнээс үл хамааруулан зөвхөн шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болохыг Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт заасан байна. Энэ заалт нь Эрүүгийн ял гарцаагүй байх зарчмыг алдагдуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл торгох ялаас ноцтойгоор зайлсхийх гэдэг нь ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс цалин орлогоо нуух бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийж байгааг ойлгоно. Гэтэл торгох ялтай этгээдүүд хуулийн Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, ШШГ тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дахь хэсэгт заасныг үндэслэн торгох ялыг өөр ялаар солих тухай саналыг прокурорт гаргана. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд заасны дагуу торгох ялыг хорих ялаар сольж болно. Сүүлийн 3 жилийн судалгаагаар торгох ялаас ноцтойгоор зайлсхийсэн гэсэн үндэслэлээр торгох ялыг сольсон тохиодол байхгүй байна. Шинэчлэлийн засгийн газрын “Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд” Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд “Торгуулийн ялыг биелүүлээгүй этгээдэд хорих ял оноох тухай тусгасан байгаа нь сайшаалтай юм. Хэрэв уг хууль батлагдвал ял биелэгдэх боломж 100% болох юм. Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 5,3 дахь хэсэгт Торгох ялын биелүүлэх талаар дэлгэрэнгүй оруулсан байгаагаас үзэхэд цаашид энэ ял бүрэн биелэгдэх боломжтойг харуулж байгаа юм. Уг заалтад биелүүлээгүй этгээдэд оноох ялын санкцыг сайтар тусгаж өгсөн байгааг доорх зүйл заалтаас харж болох юм.

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүхээс мөнгөн шийтгэл оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялын хэмжээ нь нэг

зуугаас дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

2. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан

торгох ялыг таван жил хүртэлх хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

3. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын

арван таван тооцооны нэгжтэй тэнцэх төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино гэж заасан байгаа нь ял эдлүүлэх ажиллагааны дэвшилттэй ололттой зүйл болсныг дурдах нь зүй юм.

ДҮГНЭЛТ:

Торгуулийн ял нь бусад ялтай харьцуулахад хөнгөн ял юм. Манай улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжинд торгуулийн ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож байгаа нь бодит амьдралтай нийцэхгүй байна.

Гэмт хэрэг үйлдсэн зарим этгээдийн хувьд амьжиргааны түвшин дорой, төлбөрийн чадваргүй, хөдөлмөр эрхэлдэггүй зэрэг байдал нь албадан ажил хийлгэх, баривчлах ялаас торгох ял нь хүнд цээрлэл үзүүлж буй байдал шүүхийн практикт цөөнгүй байна. Мөн Шүүхээс торгох ялыг оноохдоо тухайн ялтны төлбөрийн чадварыг харгалзан үзэж оноох шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлд Торгох ялын хэмжээг төгрөгөөр хатуу тогтоож байгаа нь мөнгөний ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор байнга өөрчлөх шаардлага гарч энэ үүргийг МУ -ын дээд шүүх тогтоолоор биелүүлж байсан нь шүүх хууль тогтоож байгаа буруу практик байсныг шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдэгдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тогтоон заасан байна.

Эдгээрийг дүгнэн үзхэд торгох ялаар шийтгэгдэж буй этгээдүүдийн эд хөрөнгийн байдал, хувийн зан чанар, эрүүл мэнд, амьжиргааны эх үүсвэрийг сайн тогтоож шийдвэр гаргах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэл бага учруулна. Шүүхийн шатанд торгуулийн ялаар шийтгэгдэж буй этгээдийн эд хөрөнгийн байдал төлбөрийн чадварийг үндэслэл муутай тогтоож байгаа нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахад саад учруулж байна. Үүнд шийтгэгдсэн этгээдийн эд хөрөнгийн байдал, төлбөрийн чадварыг мөрдөн байцаалт, прокуроын хяналтын шатанд зөв тогтоож чадахгүй байна.

Эдгээрээс харьцуулан үзэхэд мөрдөн байцаалтын шатанд байцаагдаж буй этгээдүүдийн битүүмжлэгдсэн эд хөрөнгийг зөв тодорхойлж хамгаалалтанд авах нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түргэн шуурхай явуулахад нөлөөлөх юм.



Я.БАТГЭРЭЛ
Налайх дүүрэг дэх шийдвэр гүйцэтгэлийн хэсгийн дарга, докторант, хошууч

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРЛИЙГ БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын хувьд газар зүй геополитекийн хувь мөнхийн хөрш болсон ОХУ, БНХАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн байдал, соёл уламжлал, зан заншил, хууль тогтоомж зэргийг зайлшгүй судлах шаардлагатай билээ. Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй дараах эх сурвалжийн хүрээнд харьцуулсан судаллаа.

Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын их хурлаас Эрүүгийн хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр шинэчлэн баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

БНХАУ-ын эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хуралдаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр засвар оруулж тогтоожээ.[1] Уг хуулийг 1997 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

Монгол улсын болон БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдийг харьцуулалтын аргаар ялын төрлийг зэрэгцүүлэн жишиж тодорхойлох замаар харьцуулан авч үзлээ.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн шижлэх ухааны дээрх аргыг хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ "Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж, тэдгээр актуудыг бүхэлд нь буюу институт бүлэг, хэсгээр нь нормативийн аргаар харьцуулах, улмаар гэмт хэрэг, ялын талаар эрх зүйн хэм хэмжээний хэлбэр, бүтэц, агуулага тогтолцоог зэрэгцүүлэн жишиж тодорхойлох зэргээр институцын түвшинд харьцуулж авч үзэх нь арга зүйн хувь чухал нөлөө үзүүлнэ. [2] " гэж тодорхойлсон байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулийн **есдүгээр бүлэгт эрүүгийн хариуцлагын зорилго, төрлийг тодорхойлж, ялын төрлүүдийг тодорхойлж, ялыг** үндсэн ба нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр ангилжээ.

---

[1] Г.Батзориг, Э.Зуунасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль орчуулга УБ хот. 2006 он.

[2] Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2012 он. 22 дахь тал

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт эрүүгийн шийтгэлийн төрлийг тодорхойлж гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваасан байна.

Монгол улсын эрүүгийн хуульд үндсэн ял 5, нэмэгдэл ял 1, үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэлэх ял 1 байхаар хуульчилсан.

Харин БНХАУ-ын эрүүгийн хуульд гол эрүүгийн төрөл /үндсэн ял/ 5, нэмэлт эрүүгийн төрөл /нэмэгдэл ял/ 3 байхаар хуульчисан бөгөөд нэмэлт эрүүгийн төрлийг дангаар нь тохируулан хэрэглэж болохоор хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	**БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ**
Есдүгээр бүлэг **Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл**	**Гуравдугаар бүлэг** **Эрүү шийтгэл** **Нэгдүгээр хэсэг** **Эрүүгийн шийтгэлийн төрөл**
46 дугаар зүйл. **Ялын төрөл** 46.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна:	**32-р зүйл.** Эрүүгийн шийтгэлийг гол эрүү ба нэмэлт эрүү гэж хуваана
46.1.1. торгох; 46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 46.1.3. эд хөрөнгө хураах; 46.1.4. албадан ажил хийлгэх; 46.1.5. баривчлах; 46.1.6. хорих; 46.1.7. цаазаар авах.	**33-р зүйл.** Гол эрүүгийн төрөл зүйл нь доорхи мэт байна. (Нэг) Захиран хамаарах; (Хоёр) Хорьж хөдөлмөрлүүлэх; (Гурав) Хугацаатай хорих; (Дөрөв) Хугацаагүй хорих; (Тав) Алахаар шийтгэх;
46.2. Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.	**34-р зүйл.** Нэмэлт эрүүгийн төрөл зүйл нь доорх мэт байна. (Нэг) Зоосоор ялгах; (Хоёр) Улс төрийн эрхийг хасах; (Гурав) Эд хөрөнгийг хурааж авах; Нэмэлт эрүүг дангаар нь тохируулан хэрэглэж ч болно.

ТОРГОХ ЯЛ

Монгол улсын хувьд үндсэн ял бөгөөд эрүүгийн хуулинд торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоож торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болхоор хуульчилсан.

БНХАУ-ын хувьд нэмэлт ялд тооцдог. Эрүүгийн хуульд торгуулийн хэмжээг хэд байхыг томьёолоогүй байна. Харин хориглогдошгүй гай гамшиг учирвал, нөхцөл байдлыг тодруулж торгуулийн хэмжээг багасгах эсвэл бүрэн хэтрүүлж болохоор хуульчилсан нь дэвшилттэй зүйл байна гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
47 дугаар зүйл. **Торгох** 47.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. 47.2. Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. 47.3. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно. 47.4. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно.	**Зургаадугаар хэсэг** **Зоосоор яллах** **52-р зүйл.** Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтоох ёстой. **53-р зүйл.** Ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хуваж тушаана. Хугацаа дүүргэлт тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал Ардын шүүх хороо гүйцэтгэгч хүнд гүйцэтгэж болох эд хөрөнгийг нь олж мэдмэгц цаг тухайд нь нэхэмжилж тушаалгах ёстой. Хориглогдошгүй гай гамшиг тушаахад үнэхээр учиртай болон байвал байдлыг нь үзэж багасгах буюу хэтрүүлж болно.

ЭРХ ХАСАХ ЯЛ

Монгол улсын хувьд *эрхэлж буй тодорхой албан тушаал, явуулж буй үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох буюу үйл ажиллагаа явуулахгүй байхаар, үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр, ялын хугацаа болон ялыг хэрхэн тоолох зэргийг нарийвчлан зохицуулсан байхад БНХАУ-д нэмэгдэл ялын чанартай хэрэглэж* Улс төрийн эрхийг нь хасаж шийтгэдэг байна.

Улс төрийн эрхэд сонгох сонгогдох эрх, үг хэлэх, хэвлэн

нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн нэгдэх, жагсаал цуглаан явуулах, Төрийн байгууллагад албан тушаал хаших, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын байгууллагад удирдах албан тушаал хаших зэргийг хамааруулдаг байна.

Монгол улсад эрх хасах ялыг албан тушаалтан болон тодорхой эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй этгээдэд оногдуулдаг бол БНХАУ-д улсын болон хувийн хэвшлийн удирдах ажилтан болон жирийн иргэнд ч оногдуулж болох байдлаар зохицуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
48 дугаар зүйл. **Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах** 48.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ. 48.2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно. 48.3.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг торгох, албадан ажил хийлгэх ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.	**Долдугаар хэсэг** **Улс төрийн эрхийг нь хасах** **54-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах гэж доорхи эрхүүдийг хасах болно. 1, Сонгох эрх ба сонгогдох эрх; 2, Үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эрх; 3, Төрийн байгуулагад тушаал үүрэх эрх; 4, Улсын өмчлөлийн компанид аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгийг жолоодох тушаал үүрэглэх эрх; **55-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах хугацааг нь тус хуулийн 57-р зүйлд тогтоосныг гаргавал нэг жилээс дээш, таван жилээс доош байлгана. Захиран хамаарахаар шийтгээд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэсэн байвал улс төрийн эрхийг хасах хугацаагаар захиран хамаарахын хугацаатай адил байлгах зэргээр гүйцэтгэнэ. **56-р зүйл.** Улсын амар төвшинд хор хөнөөл учруулсан ялт этгээдэд улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэх ёстой. Зориуд хүн алсан, хүчиндсэн, гал тавьсан, хор хаясан, тонон дээрэмдсэн зэрэг нийгмийн эмх дэглэмийг хүнд ноцтой эвдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нь хасахаар нэмж шийтгэж болно. Улс төрийн эрхийг нь хасахаар данган тохируулан хэрэглэвэл хуулийн хуваарь дүрмийн тогтоолыг үндэслэнэ. **57-р зүйл.** Алах эрүү ба хугацаагүй хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн улс төрийн эрхийг нь нэг насаар нь хасах ёстой. Алах эрүүг нь алгуурлан гүйцэтгэх эрхийг нь хугацаатай хорих болгон хөнгөрүүлэх үед улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүг нь гурван жилээс дээш арван жилээс доош

	болгож бууруулах ёстой. **58-р зүйл.** Улс төрийн эрхийг нь хасах нэмэлт эрүүгийн хугацааг хорих эрүү, хориж хөдөлмөрлүүлэх эрүү дуудсан өдөр буюу тэнсэн сулласан өдрөөс эхлэн бодно. Улс төрийн эрхийг хасах эрүү нь гол эрүүгийн гүйцэтгэлийн хугацаанд хүчинтэй. Улс төрийн эрх нь хасагдсан ялт этгээд гүйцэтгэлийн хугацаанд хууль цааз, засаг захиргааны хууль тогтоол болон төрийн албаны хорооны дотоодыг хамгаалах салаа мөчрийн хамаа бүхий хянан хамааралтын тухай тогтоолыг журамлан сахиж хяналтыг дагах ёстой. Тус хуулийн 54-р зүйлд тогтоосон эрхүүдийг хэрэглэж болохгүй.

ЭД ХӨРӨНГӨ ХУРААХ

Эд хөрөнгө хураах ялын зохицуулалтын хувьд төсөөтэй зүйл нэлээдгүй байна. Тухайлбал нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг, гэмт этгээдийн хувьд ноогдох /хувийн өмчлөлийн/ хөрөнгийг бүгдийг буюу нэг хэсгийг /шүүхийн тогтоолд заасан эд хөрөнгийг/ хураан авахаар хуульчилсан боловч БНХАУ-ын хувьд эд хөрөнгө хураан авахаас өмнө гэмт этгээдийн бусдад төлөх төлбөрийг /шүүхээр баталгаажсан/ төлбөр авагчийн хүсэлтээр барагдуулахаар хуульчилсан нь гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж хохирол барагдуулахад нэлээд ахиц гаргасан зохицуулалт болжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
49 дүгээр зүйл. **Эд хөрөнгө хураах** 49.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ. 49.2. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана. 49.3. Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.	**Наймдугаар хэсэг** **Эд хөрөнгийг нь хураан авах** **59-р зүйл.** Эд хөрөнгийг нь хураан авах ялт этгээдийн хувийн өмчлөлийн нэг хэсэг буюу бүгдийг нь хурааж авах явдал болно. Эд хөрөнгийг нь бүгдийг нь хурааж авахдаа ялт этгээдийн хувь хүн хийгээд түүний асран тэжээж байгаа гэр бүлийнхэнд чухал бүхий амьдралын зардал үлдээх ёстой. Эд хөрөнгийг нь хураан авхаар шийтгэхдээ ялт этгээдийн бүлийнхний өмчлөл болох буюу эдлэх эрхтэй эд хөрөнгийг нь хурааж болохгүй. **60-р зүйл.** Эд хөрөнгийг хураан авахаас өмнө ялт этгээдийн зүй ёсны өрийг хураан авсан эд хөрөнгөөр төлөх чухалтай байвал авцаатны хүсэлтээр төлөх ёстой.

АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ

Дээрх ял шийтгэл БНХАУ-ын эрүүгийн хуулийн ял шийтгэлийн төрөлд байдаггүй бөгөөд Монгол улсын ялын төрөлд дараах байдлаар тодорхойлжээ. Уг ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх бөгөөд нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. .Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож сольж болохоор зохицуулсан бөгөөд хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй байхаар хуульчилжээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
50 дугаар зүйл. **Албадан ажил хийлгэх** 50.1.Энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. 50.2.Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. 50.3.Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино. 50.4.Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй.	

БАРИВЧЛАХ ЯЛ

Монгол улсын эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд заасан баривчлах ялын төрлийг БНХАУ-ын эрүүгийн хуулийн гуравдугаар бүлэгт заасан хорьж хөдөлмөрлүүлэх ялын төрөлтэй харьцуулан үзлээ. Дээрх ялын төрлүүд нь адилхан нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд БНХАУ-д ял шийтгэгдсэн этгээдийг хорьж хөдөлмөрлүүлж, мөн ажлын хөлсийг тооцож олгодог байхаар зохицуулжээ. 2 улсын хувьд дээх ялыг үндсэн ялын чанартайгаар хэрэглэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
51 дүгээр зүйл. **Баривчлах** 51.1. Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ. 51.2. Баривчлах ялыг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулна. 51.3. Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй. 51.4. Цэргийн жинхэнэ хугацаат албан хаагчид оногдуулсан баривчлах ялыг сахилгын байранд ганцаарчлан эдлүүлнэ.	**Гуравдугаар хэсэг** **Хорьж хөдөлмөрлүүлэх** **42-р зүйл.** Хорьж хөдөлмөрлүүлэх хугацааг нэг сараас дээш зургаан сараас доош байлгана. **43-р зүйл.** Хорьж хөдөлмөрлүүлэх шийтгэгдсэн ялт этгээдийг дотоодын хамгаалах байгуулагад ойрхон газарт нь гүйцэтгэнэ. Гүйцэтгэлийн хугацаанд хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээд сард нэгээс хоёр өдрийн чөлөөгөөр гэртээ харьж болно. Хөдөлмөрт оролцвол зохих хэмжээний хөлс хүч олгож болно. **44-р зүйл.** Хорьж хөдөлмөрлүүлэхийн эрүүгийн хугацааг нь шүүх таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс бодно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээр өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацаанд нэг өдрөөр тооцно.

ХОРИХ ЯЛ

Хорих ялын үндсэн хугацаа адил 15 жил хүртэл байх бөгөөд Монгол улсад хуулийн тусгай ангид заасан тохиолдолд 25 жил хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан бол БНХАУ-д зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг хугацаагүй хорихоор шийтгэдэг байна.

Хуульд хорих дэглэмийг зааж өгсөн нь 2 улсын эрүүгийн хуульд адил мэт боловч Монгол улсын хувьд үйлдсэн хэргийн хувьд хүнд, хөнгөн, гэмт этгээдийн нас, хүйс, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос ял эдлэх дэглэмийг хуульчилж өгсөнөөрөө онцлог байна.

БНХАУ-ын хувьд хорих ял штйтгүүлсэн этгээд хөдөлмөрлөх чадалтайл бол заавал хөдөлмөрт оролцож хүмүүжигдэн өөрчлөгдөх талаар хууьчилжээ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
52 дугаар зүйл. **Хорих** 52.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ. 52.2. Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил хүртэл байна. Хорих ялыг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар оногдуулж болно. 52.3. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд	**Хугацаатай хорих, хугацаагүй хорих** **45-р зүйл.** Хугацаатай хорих хугацааг тус хуулийн 50-р зүйл, 69-р зүйлд тогтоосныг гаргавал 6 сараас дээш арван таван жилээс доош байлгана. **46-р зүйл.** Хугацаатай хорих, хугацаагүй хорихоор шийтгэгдсэн ялт этгээдийг гянданд буюу бусад гүйцэтгэх талбарт гүйцэтгэнэ. Хөдөлмөрөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжигдэн өөрчлөгдөх ёстой. **47-р зүйл.** Хугацаатай хорих эрүүгийн хугацааг шүүн таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс тооцно. Шүүн таслалтыг гүйцэтгэхээс өмнө урьдаар хорьсон байвал хоригдсон нэг

арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй. 52.4. Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ. 52.5. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.6. Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.7. Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.8. Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.9. Урьд нь хорих ял эдэлж байсан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. 52.10. Шүүх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хорих ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлж буюу чангаруулан өөрчилж болно. Ийнхүү шийдвэрлэсэн шалтгааныг шийтгэх тогтоолд заана. 52.11. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно.	өдрийг нь эрүүгийн хугацааны нэг өдрөөр тооцно.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Цаазаар авах ял 2 оногдуулж болохгүй нөхцөлийг Монгол улсад 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд, БНХАУ-д 18 насанд үл хүрсэн ба шүүн таслах үед жирэмсэн байх эмэгтэйд хэрэглэхгүй байхаар зохицуулжээ. Дэлхий нийтээр цаазаар авах ялаас татгалзаж байгаа өнөө үед Монгол улсын ерөнхийлөгч Монгол улсыг цаазын ялгүй орон хэмээн зарлаж, цаазаар авах ялыг гүйцэтгэхийг түдгэлзүүлээд байгаа билээ. Харин БНХАУ-д ял үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй болон шүүн таслах үед жирэмсэн байгаа эмэгтэйд алах ялыг хэрэглэхгүй бөгөөд бусад этгээдэд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол алах ялыг хэрэглэхээр зохицуулжээ. Монгол улсын эрүүгийн хуульд ялыг буудаж гүйцэтгэхээр заасан бөгөөд дээрх ялаар шийтгүүлсэн этгээд өөрөө хүсвэл Монгол улсын ерөнхийлөгчөөс уучлал хүсэхээр, Монгол улсын ерөнхийлөгч амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар хорихл ялаар солихоор хуульчилсан. Харин БНХАУ-ын хувьд Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой бөгөөд алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. Алгуурлан гүйцэтгэх хугацаа хугацц 2 жил байхаар зохицуулсан бөгөөд энэ хугацаанд зориуд ял хийгээгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавъяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлдэг байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
53 дугаар зүйл. **Цаазаар авах** 53.1. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно. 53.2. Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ. 53.3. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино. 53.4. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.	**Тавдугаар хэсэг** **Алахаар шийтгэх** **48-р зүйл.** Эрүүг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд л тохируулан хэрэглэнэ. Алахаар шийтгэх ёстой ялт этгээдийг заавал доор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгэхийг хоёр жил алгуурлан гүйцэтгэж болно. Хууль ёсоор Ардын шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой. Алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. **49-р зүйл.** Ял хийх үедээ бүх л арван найман насанд үл хүрсэн ба шүүх таслах үед жирэмсэн байх эмэгтэйд алах ялыг тохируулан хэрэглэхгүй. **50-р зүйл.** Алахаар шийтгэхээр алгуурлан гүйцэтгэгсэд алахыг алгуурлан гүйцэтгэх хугацаа нь хэрвээ зориуд ял хийсэнгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгож хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавъяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш, хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлнэ. Хэрвээ зориуд ял хийсэн бөгөөд байцаан тодлоод үнэн магад байвал. Ардын дээд шүүх хороогоор хянан зөвшөөрүүлээд алах эрүүг гүйцэтгэнэ. **51-р зүйл.** Алахаар шийтгээд алгуурлан гүйцэтгэх хугацааг нь шүүх таслалтыг нь тогтоосон өдрөөс эхлэн бодно. Алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэхийг хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацааг түүний алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхэлж болно.

ЗАХИРАН ХАМААРАХ ЯЛ

БНХАУ-н эрүүгийн хуулийн 38-р зүйлд Захиран хамаарах эдийн засгийн байдал, соёл, өв уламжлал, ёс заншил, төрийн тогтолцоо, эрх зүйн бүлээсээ хамаарч

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	БНХАУ-ын ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
	Захиран хамаарах **38-р зүйл.** Захиран хамаарах хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ. **39-р зүйл.**Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд гүйцэтгэлийн хугацаандаа доорхи тогтоолуудыг журамлан сахих ёстой. (Нэг) Хууль цаазын, засаг захиргааны хууль, тогтоолыг журамлан сахиж, (Хоёр) Гүйцэтгэх байгууллагын зөвшөөрөлгүйгээр үг яриа тавих, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэрэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөт эхийг хэрэглэж болохгүй (Гурав) Гүйцэтгэх байгууллагын тогтоолоор өөрийн ажиллагааны байдлаа мэдүүлэх үүрэгтэй (Дөрөв) Зочинтой уулзах тухай Гүйцэтгэх байгууллагын тухай журмыг журамлан сахих хэрэгтэй. (Тав) Сууж байгаа хот, сиянаас салах буюу нүүж явбал гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж зөвшөөрүүлэх ёстой. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдэд хөдөлмөрийн дунд адил хөдөлмөрт адил хөлс авах ёстой. **40-р зүйл.** Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээдийн захиралтын хугацааг нь дүүрвэл гүйцэтгэх байгууллага нь тус хүн ба түүний байгаа нэгжид нь буюу сууж байгаа газрыних нь олон тумэнд захирагдлаас чөлөөлсөнийг нь захирвал зохино. **41-р зүйл.** Захиран хамаарах эрүүгийн хугацааг нь шүүн таслалтыг гүйцэтгэсэн өдрөөс эхэлж бодно. Шүүн таслалтыг нь гүйцэтгэхээс өмнө урдаар хорисон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны хоёр өдрөөр нугалан бодно.

хугацааг гурван сараас дээш, хоёр жилээс доош байлгана. Захиран хамаарагдахаар ял этгээдийг Дотоод хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ.

Доктор Д.Баярсайхан дээрх ялыг Хяналт тогтоох ял [1] гэж тодорхойлоод 2 сараас 3 жил хүртэл хугацаатай байх бөгөөд дотоодыг хамгаалах байгууллагын шууд хяналтанд ялыг хэрэгжүүлдэг байна. Монгол улсын хувьд дээрх ялын төрөл хуульчлагдаагүй байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй харьцуулан судалхад 2 улсын ял шийтгэлийн төрөл ерөнхийдөө адил төстнй бөгөөд тухайн орны нийгэм тус тусын онцлогтой байна.

Судалгааны явцад БНХАУ-ын хорих ялын бодлого нь хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг заавал ажил хөдөлмөр эрхлүүлэхэд оршдог бөгөөд энэ нь уг хуулийн хөдөлмөрлөх чадалтай л бол заавал хөдөлмөр эрхлүүлнэ гэж томьёолсоноос тодхон харагдана.

Мөн торгох ялыг хэмжээг хуульд тодорхой зааж өгөөгүй байгаа нь тухайн гэмт этгээдийн хөрөнгө чинээ, орлого зэргийг харгалзан шүүхээс тогтоож болохоор нээлттэй байгааг Монгол улсад тусган авч хэрэгжүүлэх зүйтэй байна. Хуулийн дээрх заалт өдгөө манай улсад шүдний өвчин мэт асуудал үүсгэж байгаа торгуулийн ялын биелэлтэнд чухал ахиц гаргана гэж судлаачийн хувьд үзэж байна.

[1] Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ хот. 2006 он. 259 дэх тал

Гэмт этгээдийн эд хөрөнгийг хураахаас өмнө төлбөр авагч, хохирогчийн хохирол төлбөрийг эхлэн барагдуулж байгаа нь сайшаалтай байна.



Ж.УУГАНЧИМЭГ
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн дэд профессор, дэслэгч

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БА УЛС ТӨРЖИЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг тойрсон улстөрийн маргаан эцэстээ Үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог үгүйсгэсэн ноцтой үр дагаврыг бий болгож байна.

Төрийн эрх мэдлийн төлөөх улс төрийн намуудын шударга бус өрсөлдөөн нь Үндсэн хуульт төрийн чухал институт болох Үндсэн хуулийн цэц, түүний гишүүдийг үгүйсгэхэд хүргэж, эцэстээ төрд итгэх олон түмний итгэлийг хөсөрдүүлж байгаад жирийн иргэний хувьд гүнээ харамсаж байгаагаа нуух юун.

Зарим нам, улстөрчид Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг улс төрийн ашиг сонирхлоор эгүүлэн татаж, энэ үйл ажиллагаандаа жирийн иргэдийг өдөөн турхирч, цаашлаад хууль дээдлэх ёсыг үнэгүйдүүлэн эрх зүйн зохицуулалтыг дур зоргоороо тайлбарлаж байгаа учир эрх зүйч, судлаач хүний хувьд зарим тайлбар хийх нь зөв болов уу гэж бодлоо.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг хэрхэн, ямар журмаар эгүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно" хэмээн зохицуулсан.

Хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татахын тулд **Нэгдүгээрт,** Үндсэн хуулийн цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон байх, **Хоёрдугаарт,** Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр гарсан байх, **Гуравдугаарт,** анх илгээсэн байгууллагын саналд үндэслэсэн байх шаардлагатай. Дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах бөгөөд энэ нь Үндсэн хуулийн цэцийн бие даасан, хараат бус байдлыг ханган баталгаажуулах эрх зүйн чухал баталгааны нэг юм.

Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан ардчилсан нам болон тус намаас сонгогдсон зарим Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанааг дээрх хуулийн заалтын дагуу эгүүлэн

татах нөхцөл бүрэн бүрдсэн хэмээн тайлбарлаж байгаатай санал нийлэхгүй байгаа тул хууль зүйн үндэслэлийг дараах байдлаар тайлбарлаж байна.

Нэг. Үндсэн хуулийн цэцийн даргыг цэцийн гишүүнийх нь хувьд эгүүлэн татахын тулд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл тэрээр хууль зөрчсөн болохыг шүүхээр тогтоосон байх шаардлагатай. Одоогийн байдлаар Үндсэн хуулийн цэцийн дарга гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хууль зөрчсөн эсэх талаар хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхгүй байна. Харин УИХ-аас Цэцийн дарга, гишүүдийн бүрэн эрхийг улс төрийн зорилгоор дуусгавар болгон тэдгээрийн эрх мэдэлд эзэн суух зорилгоор Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд “Цэцийн гишүүн хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол түүнийг Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн заалтыг нэмэлтээр оруулсан билээ. Харин 2016 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны шийдвэрээр Цэцийн тухай хуульд оруулсан дээрх өөрчлөлтийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнээд түдгэлзүүлсэн хэдий ч Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр түдгэлзсэн хуулийг хэрэглэж Цэцийн даргыг эгүүлэн татаж байгаа нь Үндсэн хуулийг дахин зөрчиж байгаа хэрэг юм.

Улсын Их Хурлаас Цэцийн тухай хуульд “Цэцийн гишүүн хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол түүнийг Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэсэн өөрчлөлт оруулсны цаад улс төрийн сонирхол нь Цэцийн гишүүнийг хууль зөрчсөн эсэхийг шалган тогтоох бүрэн эрхийг Улсын Их Хурал өөртөө олгож, цэцийн гишүүдийг дур зоргоороо огцруулах боломж нөхцөлийг бүрдүүлэх сонирхолтой байсан нь хэн болгонд тодорхой байна.

Ардчилсан, эрх зүйт төр улсад аливаа этгээдийн гэм буруутай эсэхийг шалган тогтоох эрхийг гагцхүү шүүхийн байгууллага хэрэгжүүлдэг нь энгийн иргэд ч сайтар мэддэг эрх зүйн зарчим юм. Иймээс Үндсэн хуулийн цэцийн даргыг хууль зөрчсөн эсэхийг Улсын Их Хурал шалган тогтоосон мэтээр тайлбарлан түүнийг огцруулж байгаа нь хууль бус үйлдэл хэмээн үзнэ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүдийг хууль зөрчсөн эсэхийг шалган тогтоох бүрэн эрх Улсын Их Хуралд хуулиар олгогдоогүйн зэрэгцээ Үндсэн хуулийн цэцийн даргыг хууль зөрчсөн хэмээн тайлбарлаж буй үндэслэл нь бас л өрөөсгөл юм. Улсын Их Хурал дахь ардчилсан намын гишүүдээс Үндсэн хуулийн цэцийн даргыг хууль зөрчсөн эсэхийг тайлбарлахдаа Үндсэн хуулийн цэцийн дарга 2016 оны 01

дүгээр сарын 20-ний өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболдод хүргүүлсэн албан бичигтээ “... нэгэнт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргаан үүсгэн шалгаж байгаа хуулийг хэрэглэж ямар нэгэн шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахгүй байхыг танд үүгээр мэдэгдэж байна” хэмээн бичсэнээрээ тэрээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааны талаарх саналаа урьдчилан хэлэх, энэ талаар зөвлөгөө өгөх эрхгүй”, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гарснаар тухайн хуульд, зарлиг, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол улсын олон улсын гэрээ болон тэдгээрийн холбогдох зүйл, заалтын үйлчилгээ нь Цэцийн эцсийн шийдвэр гарах хүртэл түдгэлзэнэ. Түдгэлзүүлж эхлэх хугацааг Цэц дүгнэлтдээ тусгайлан заана” гэсэн заалтыг зөрчсөн хэмээн үзжээ.

Тэгвэл Үндсэн хуулийн цэцийн даргын гарын үсэг бүхий дээрх албан бичгийг цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааны талаарх саналаа урьдчилан илэрхийлсэн хэмээн үзэж болох уу? Хариулт маш энгийн бөгөөд ойлгомжтой. Албан бичигт Үндсэн хуулийн цэц маргааныг хэрхэн шийдвэрлэх гэж байгаа талаарх урьдчилсан санал, дүгнэлт огт тусгагдаагүй маргаан бүхий хуулиудыг түдгэлзүүлсүгэй гэсэн шийдвэр гаргаагүй. Харин Үндсэн хууль зөрчсөн эсэхийг магадлан шалгаж байгаа хуулийг хэрэглэн үр дагавар үүсгэхгүй байхыгзүй ёсны үүднээс хүссэн байна. Үндсэн хуулийн цэц байгуулагдан үйл ажиллагаа явуулснаас хойш 20 гаруй жилийн хугацаанд Улсын Их Хурлын зүгээс Цэцээс маргаан үүсгэн шалгаж байгаа хуулийг ийнхүү улайран хэрэгжүүлэх гэж зүй бус үйлдэл хийж байгаагүй учир Үндсэн хуулийн хяналтын механизмыг хүндэтгэн үйл ажиллагаа явуулахыг хүссэн Үндсэн хуулийн цэцийн даргын үйлдлийг буруутгах аргагүй. Зүйрлэн хэлэхэд иргэн А, Б нарын хэн нь газар өмчлөх эрхтэй эсэхийг шүүхээр хэлэлцэж байх үед хэн нэг нь маргаантай байгаа газар дээр барилга барьж, барилга барьсан үйлдлээ өмчлөх эрхийг тэргүүн ээлжинд олж авах үндэслэл хэмээн тайлбарлавал энэ нь шударга ёсонд нийцэх үү?

Нэр бүхий иргэдийн мэдээллээр маргаан үүсгэн шалгаж байсан хуулиудыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхөд Улсын Их Хурлаас тогтоосон учир давхар давхар сөрөг үр дагавар гаргуулахгүйн тулд Цэцийн дарга ийнхүү албан бичиг илгээсэн гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой бөгөөд энэ нь төрийн институц хоорондын

албан харилцаанд байх ёстой ердийн үйлдэл юм.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас Үндсэн хууль зөрчсөн хэмээн дүгнэлт гарснаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн үйлчлэл түдгэлзэж, харин цэцийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хуулийг Улсын Их Хуралбодитоор дагаж мөрдөн хэрэгжүүлэх нь хууль дээдлэх ёсонд нийцэх мэтээр муйхарлан тайлбарлах улс төрчид цөөнгүй байна. Хуульд энэ талаарх харилцааг нарийвчлан зохицуулаагүй тул улс төрчид өөрт ашигтайгаар тайлбарлаж байгаа биз ээ. Үндсэн хуулийн цэцээс маргаан үүсгэж шалгаж байгаа хуулийг Улсын Их Хурлаас бодитоор хэрэгжүүлэх, хэрэглэх нь зүй ёсонд нийцэх үү? Судлаачийн хувьд дээрх үйлдлийг зүй ёсонд нийцэхгүй шударга бус үйлдэл хэмээн дүгнэж байна. Хуулийн маш тодорхой нэгэн заалтыг онцлон тэмдэглэх хэрэгтэй: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан албан ёсоор нийтлэгдсэн хүчин төгөлдөр хуулийг хэрэглэнэ”, 10.2-т “Хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана” хэмээн хуульчилжээ. Хэрэв ердийн шүүхээс хэрэглэх хууль Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзвэл шүүгч Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хуулийг хэрэглэн маргааныг шийдвэрлэх эрхгүй бөгөөд Улсын Дээд Шүүх цэцэд хандан хүсэлт гаргах эсэх, хэрэв цэцэд хүсэлт гаргасан бол цэцээс тухайн хууль Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хэрхэн шийдвэрлэх хүртэл хугацаанд шүүх маргаантай байгаа хуулийг хэрэглэх боломжгүй болохыг дээрх хуульд туйлын тодорхой заажээ. Тэгвэл Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн шалгаж байгаа хуулийг шүүхийн байгууллага хэрэглэх боломжгүй атал хуульд нарийвчлан заагаагүй гэсэн ганцхан үндэслэлээр Улсын Их Хурал хэрэглэх нь зөв үү...

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүнийг эгүүлэн татах журмын асуудал томоохон маргааныг бий болгож байна. Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 4-т "Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно" хэмээн хуульчилсан. Дээрх агуулга бүхий заалт Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд мөн бэхжигдсэн. Зарим улс төрчид цэцийн гишүүнийг эгүүлэн татахдаа Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг

авах шаардлагагүй, харин цэцийн гишүүнийг томилуулахаар анх илгээсэн байгууллагын санал байхад хангалттай мэтээр тайлбарлаж байна. "Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын санал" гэсэн утгууд нь "эсхүл" гэсэн холбоосоор холбогдоогүй байгааг хууль хэрэглэх явцдаа анхаарах шаардлагатай.

Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Үндсэн хуулийн цэцийн анхны дарга Г.Совд 1999 онд туурвисан Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар хэмээх бүтээлдээ : “Цэцийн гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхдээ уг гишүүнийг анх дэвшүүлж томилуулсан байгууллагын санал, Цэцийн шийдвэрийг үндэслэх учиртай” хэмээн бичсэн байна.Иймээс цэцийн гишүүнийг эгүүлэн татах асуудлыг шийвэрлэхэд уг асуудлаар гаргасан цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын санал аль аль нь байх шаардлагатай болох нь тун ойлгомжтой байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “Цэцийн гишүүнийг цэцийн зөвшөөрөлгүйгээр ... баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд захиргааны шийтгэл оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.”, мөн зүйлийн 2-т “Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагыг санал, шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.” Мөн зүйлийн 3-т “Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.” хэмээн тус тус заасан нь Цэцийн гишүүний хараат бус байдлын хууль зүйн баталгааг бэхжүүлсэн болох нь харагдана.

Сүүлийн жилүүдэд маш тодорхой байгаа хуулийн заалтыг хүртэл улс төрийн зорилгоор ойлгомжгүй, тодорхойгүй болгодог хандлага олноор гарах болсон нь мэргэжлийн хууль нарт төдийгүй жирийн иргэдэд илэрхий харагдаж байна.

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригийн Улсын Их Хуралд хүргүүлсэн 2016.01.26-ний өдрийн албан бичгийг Улсын Дээд Шүүхийн шийдвэр гэж үзэх асуудал улс төрийн тогоонд бас л маргаантай байна. Улс төрийн тогоо гэхийн учир нь Улсын дээд шүүх

болон Улсын Дээд шүүхийн шийдвэр гэх ойлголт нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар ч маргаангүй, туйлын тодорхой зохицуулалттай. Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1-д "Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ", Монгол улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д "Бүх шатны шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ", 16 дугаар зүйлийн 1-д "Улсын Дээд Шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ" хэмээн зааснаас үзэхэд Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч бол Улсын Дээд шүүх биш болох тодорхой байна. Улсын Дээд Шүүхийн шийдвэр гэдэг Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн дангаар гаргасан аливаа шийдвэр, албан бичиг хамаарахгүй. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа 2005 онд туурвисан Үндсэн хуулийн процессын эрх зүй: Суурь ойлголт, тулгамдсан асуудал хэмээх бүтээлийн 84 дэх нүүрэнд Улсын дээд шүүхийн шийдвэр гэдэгт Улсын Дээд Шүүх нийт шүүгчдийнхээ хурлаар хэлэлцэж гаргасан тогтоолыг ойлгоно хэмээн бичсэн байна. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн тогтоолоор Улсын Дээд Шүүх, Улсын Дээд Шүүхийн шийдвэр гэх ойлголтууд нэг мөр шийдвэрлэгдсэн болохыг онцлон тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т “Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо ... Улсын дээд шүүх гишүүдийнхээ олонхийн саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана.” гэж заасан.

Хэдийгээр эгүүлэн татах талаар хуулиар зохицуулаагүй ч гэсэн хууль зүйн үүднээс тайлбарлавал томилох, эгүүлэн татах асуудал яг ижил процедураар явагдана гэдгийг эрх зүйч мэргэжлээр суралцаж буй 1 дүгээр дамжааны оюутан ч хариулах байхаа. Тэмүүжин гишүүний тайлбараар бол Цэцийн гишүүнийг томилохдоо Улсын дээд шүүх гишүүдийнхээ олонхийн саналыг үндэслэн (өөрөөр хэлбэл Улсын дээд шүүхийн бүх шүүгчид хуралдаж) зохих шийдвэр гаргана. Харин эгүүлэн татах бол Ерөнхий шүүгч дангаараа санал өгнө гэсэн ойлголт бий болж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрх, түүний хараат бус байдлыг хангах баталгаа талаас нь авч үзвэл аль нь илүү сөрөг үр дагавар бий болгохыг тунгаан бодвол та бүхэн надтай санал нэгдэх буй заа.

Дүгнэн үзвэл Улсын Их Хурлаас гаргасан Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татсан шийдвэр нь өөрөө Үндсэн хууль болон хүчин төгөлдөр хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн Үндсэн хуулийн зөрчил бөгөөд уг

асуудлыг хуулийн хүрээнд, шударгаар шийдвэрлүүлэхийн тулд мэргэжлийн хуульч хийгээд эрдэмтэн судлаачид өөр өөрийн дуу хоолойг үндэслэл бүхий байдлаар илэрхийлэх нь зүйтэй хэмээн үзэж энэхүү нийтлэлийг бичлээ.

Өнөөдрийн хууль зөрчсөн үйлдлийг нэн даруй таслан зогсоохгүй бол уг үйлдэл хожмын нэгэн цагт хууль ёсны мэтээр хүлээн зөвшөөрөгдөж, хууль ёс, шударга ёсны төлөө ярихад нэгэнт оройтох биз ээ .....



Д.ЭНХБАЯР
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх албаны тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, цагдаагийн дэд хурандаа

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ.

Хураангуй: Монгол улсад үйлдэгдэж байгаа хулгайлах төрлийн гэмт хэргийн сүүлийн 12 жилийн судалгаанд үндсэлэн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгасан болно.

Түлхүүр үг. Хулгайлах гэмт хэрэг, орон байрны хулгай, малын хулгай, халаасны хулгай, үйлдлийн арга

1990 оноос Монгол улсад өрнөсөн өөрчлөлт шинэчлэлт нь улс төр нийгэм, эдийн засгийн хувьд эерэг нөлөө үзүүлсэн ч эрүүгийн нөхцөл байдлын хувьд тийм ч таатай биш байна. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 12 жилд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33.7 хувь, 2010-2014 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 29.5 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг эзэлж гэмт хэргийн тоо өссөнөөс гадна түүний бүтэц, нийгэмд аюултай шинж чанар, гэмт этгээдүүдийн арга, заль мэх ихээхэн өссөнийг та бид сайн мэдэж байгаа билээ.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулинд тусгай ангийн 145 зүйлд хулгайн гэмт хэргийг журамлан өгчээ. (145 зүйл: Бусдын эд хөрөнгийг хулгайлах). 145.1 Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол ...145.2 Энэ гэмт хэргийг давтан буюу бүлэглэж, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол...145.3 Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, эсхүл хэргийн улмаас хохирогчийн амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол... 145.4 Энэ хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа, эсхүл булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг,гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол...гэж заажээ.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, технологийн төвөөс гаргасан мэдээгээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь 2003-2014 онуудад 84436 бүртгэгдсэний 51.2

хувь нь орон нутагт, 48.8 хувь нь нийслэл хотод, 0.04 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 2008-2011 онд 3.5-16.6 хувиар буурсан үзүүлэлттэй байх боловч 2012 онд 18.8 хувиар, 2013 онд 25.8 хувь, 2014 онд 6.8 хувиар тус тус өсчээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 30-аас доошгүй хувь нь хулгайлах гэмт хэрэг байна.

Орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 31.8 хувь, нийслэлд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 30.3 хувь нь хулгайлах гэмт хэрэг байх бөгөөд цаашид өсөх хандлага ажиглагдаж байна. Нийслэл хотод сүүлийн 12 жилд 133031 гэмт хэрэг бүртгэгдсэний 33.4 хувь нь хулгайлах гэмт хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд онц их хэмжээний хохирол учруулж байна.

Цагдаагийн байгууллага сүүлийн 5 жилийн байдлаар / 2010-2014 он/ хулгайн гэмт хэргийн талаарх 29501 гомдол, 2010-2014 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хулгайлах гэмт хэрэг 27314 бүртгэгдэж үүнээс 14009 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдсон бөгөөд хэргийн илрүүлэлт 51.3 хувьтай байна.

Сүүлийн 5 жилд 33627 хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэний 44.2 хувь нь орон нутагт, 55.5 хувь нь нийслэлд үйлдэгдсэн байх ба нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргүүдэд, орон нутагт Хэнтий, Төв, Дорнод аймгуудад гэмт хэргийн гаралт хамгийн өндөр байна. 2010-2014 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 33500 иргэн, 262 байгууллага хохирч, үүнээс 156 хүн гэмтэж, 60.3 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирсан нь улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 23.7 хувийг эзэлж байна.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл гэр, орон сууцанд гарсан хулгайн хэрэг 36.2 хувь, бэлчээр дээрх мал хулгайлах хэрэг 13.8 хувь% гудамж талбайд гарсан хэрэг 11.5 хувийг эзэлж байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 2 хүн тутмын нэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 3 хүн тутмын нэг нь бүлэглэн үйлдсэн, 11 хүн тутмын нэг нь урьд өмнө нь шүүхээр ял шийтгэгдсэн байгаагаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх арга хэлбэр улам нарийсч байгаа нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс иргэдийн өмч, мал, авто тээврийн хэрэгсэл, халаасны хулгайн гэмт хэргийн төрлөөр авч үзвэл:

1. **Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг** 2010-2014 онд

улсын хэмжээнд 22358 бүртгэгдсэн нь хулгайлах гэмт хэргийн 66.5 хувийг эзэлж байна. Иргэдийн өмчийн хулгай 2011 онд өмнөх оноос 13.8 хувиар, 2012 онд өмнөх оноос 18 хувиар, 2013 онд өмнөх оноос 31.3 хувиар, 2014 онд өмнөх оноос 18.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 4 жил дараалан иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт буурсан байна. Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн 65.6 хувь нь хүнд, 33.7 хувь нь хөнгөн, 3.4 хувь нь хүндэвтэр, 0.1 хувь нь онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байна. 2010-2014 онд иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн улмаас 22961 иргэн, 165 аж ахуйн нэгж байгууллагад 42.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 38.9 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ.

2. **Мал хулгайлах гэмт хэрэг**. 2010-2014 онд улсын хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 6484 бүртгэгдсэн нь нийт хулгайлах гэмт хэргийн 19.3 хувийг эзэлж байна. Мал хулгайлах гэмт хэргийн 93.7 хувь нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Статистик мэдээнээс дүгнэхэд бүртгэгдсэн гэмт хэрэг жилээс жилд өссөн байна. Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 2011 онд 7.7 хувь, 2012 онд 5.3 хувь, 2013 онд 10.2 хувиар буурсан байх бөгөөд 2014 онд 5.3 хувиар өссөн байна.

3. **Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг**. 2010-2014 онд улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн хулгайлах төрлийн гэмт хэргийн 2.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилд бүртгэгдсэн авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 53.2 хувьтай байгаа нь нийт хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн түвшингээс 1.9 хувиар их байна.

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэргийн улмаас 942 иргэнд 1.8 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 43.8 хувийг нөхөн төлүүлжээ. Энэ төрлийн гэмт хэрэг нутаг дэвсгэрийн хэмжээнд харилцан адилгүй бүртгэгдэж байна. Тухайлбал: орон нутагт ихэвчлэн мотоцикль түүний эд анги хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа бол хүн ам төвлөрсөн нийслэл хотод суудлын автомашин, түүний эд анги хулгайлах гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж байна.

4. **Халаасны хулгайн гэмт хэрэг**. 2010-2014 онд улсын хэмжээнд 1519 халаасны хулгайн гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт хулгайлах гэмт хэргийн 4.5 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн 96.4 хувь нь нийслэлд бүртгэгджээ. Гэмт хэрэг 2011 онд өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурсан бол 2012 онд 47.3 хувь, 2013 онд 71.1 хувь 2014 онд 37.5 хувиар тус тус өссөн байна. Сүүийн 5 жилд бүртгэгдсэн халаасны хулгайн гэмт

хэргийн илрүүлэлт дунджаар 37.6 хувьтай байгаа нь хулгайлах нийт хэргийн илрүүлэлтийн түвшингээс 14.4 хувиар бага байна. Нийт гэмт хэргийн 70.0 хувь нь хөнгөн ангиллын хэрэг байгаагаас үзэхэд халаасны хулгайн гэмт үйлдлийг бүртгэх, хүлээн авах, хэргийг илрүүлэх, шийдвэрлэх асуудал учир дутагдалтай байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэгчдийн нийгмийн байдлыг авч үзвэл 13624 буюу нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 50 гаруй хувийг эрхэлсэн ажилгүй хүмүүсээс үйлдэж байгаа нь харагдаж байна. Энэ бүгдээс дүгнэж үзэхэд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь:

1. Ядуурал, ажилгүйдэл ялангуяа орон нутагт ажилгүйдэл нэмэгдэж иргэд орлогын эх үүсвэргүй болсон улмаар нийслэлд ирж гэмт хэрэг үйлдэх болсон

2. Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх арга, хэлбэр улам нарийсч халаасны, орон байрны, автомашины, малын, түүх соёлын дурсгалт зүйлс зэрэг байдлаар мэргэшин тухайн гэмт хэргийн замаар олсон эд зүйлийг мэдсээр байж авдаг, захиалдаг, борлуулдаг сүлжээ, ченжүүд зохион байгуулалтанд орсон.

3. Ард иргэд Цагдаагийн байгууллагад итгэл буурснаас гэмт хэргийн талаар мэдэгдэхээ больсон.

4. Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг нь зохион байгуулалтад орж далд хэлбэртэй болсон.

5 .Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг гагцхүү Цагдаагийн байгууллагын ажил мэт ойлгодог, төрийн бусад байгууллагын оролцоо, дэмжлэг сул.

Иймд цаашид хулгайн гэмт хэргийг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хийх саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэж буй албадын орон тоо хүч хэрэгслийг нэмэгдүүлж, бүтцийн өөрчлөлт оруулж, ажиллах нөхцөлийг сайжруулах.

2. Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ шатанд гаргах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, илрүүлэхэд илүү хүч зардлыг зарцуулах

3.Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулахаас гадна Цагдаагийн байгууллагын дотоод албадын уялдааг сайжруулах

4. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулж, урьд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байгаа онц хүнд, хохирол ихтэй эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргүүдийг илрүүлэх ажлыг идэвхижүүлэх.

5. ЦЕГ-ын мэдээлэл технологийн төвөөс гаргаж буй

мэдээг дүн шинжилгээнд анализ хийж цаашдын ажлаа төлөвлөхөд ашигладаг болгох.

6. Гадаад орнуудын туршлагаас хэрэгжүүлэх, судлах ажлыг эхлүүлэхээс гадна тус чиглэлээр судлаач нарыг гаргах, урьдчилан сэргийлэх төсөл боловсруулах /хохирогч судлал, социологийн судалгаа г.м/

7.Хулгайн гэмт хэргээс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх, ажлыг эрчимжүүлэх

8. Хулгайн гэмт хэргийг болон гэмт хэргийг бүртгэх ажлыг нэг мөр болгож, хэрэг завших, нуун дарагдуулах зэрэг зохисгүй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг арилгах

Өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэж, дэлхий нийтийн жишгийг анхаарч гэмт хэргийн илрүүлэлтийн бууралт, хэргийн тооны өсөлт гарцаагүй нийгмийн хөгжлийн дагуух үйл явц гэдгийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрөх явдал мөн. Гэмт хэргийн тоо буурч илрүүлэлт өсөж байх ёстой мэтээр ойлгодог ойлголтоос салах цаг иржээ. Заавал гэмт хэргийн тоог механикаар буулгаж. илрүүлэлт байнга ахиж байгаа мэтээр харагдуулах ёсгүй билээ.

ЦБ-ын боловсон хүчний бэлтгэх асуудлыг чанаржуулах, мэргэшүүлэх ажлыг идэвхжүүлэх шаардлага байгаа бөгөөд нэгэнт мэргэжлийн сургалттай сургуулийн хувьд Хууль сахиулахын их сургуулийн цагдаагийн сургуулийн бүтэц орон тоо, бааз суурийг улам бэхжүүлмээр байна. Бусад хуулийн сургуулиудаас юугаараа онцлог билээ гэдэгт анхаарч энэ чиглэлийн сургалтыг түлхүү өгч хөгжүүлэх цаг иржээ. Жишээлбэл: ЦБ-ын онцлогийн дагуу Эрүүгийн тагнуулын, криминалистикийн, мөрдөн байцаах тактикийн, хуулийн сэтгэл судлалын, логик гэх мэт нэн чухал хэрэглэгддэг хичээлүүдийн цаг сэдвийг нэмэх чанаржуулах. Ингэж чадваас бэлтгэгдэн гарч буй ЦБ ажилтан нар бусдаас онцлог чадвартай, практик дээр шууд ажиллах чадвар эзэмшсэн байх болов уу.

Дэлхий нийтийн жишгээр урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүн зэрэгт тавьж түүнд төрийн бодлого боловсруулж анхаарал хандуулах шаардлага нэн чухал байна.

ЦБ-аас гэмт хэрэг илрүүлэхэд зарцуулж буй хөрөнгийн үнэлгээг судлан гаргаж түүнээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах ёстой билээ.”Ухаалаг хууль тогтоогч гэмт хэрэг гарсны дараа биш урьдчилж хууль зарлиг гаргадаг” гэсэн мэргэн үгийг ойлгох цаг нь ирсэн байна.

Хулгайн гэмт хэрэг өдөр ирэх тусам зохион байгуулалттайгаар үйлдэгдэх хэлбэр лүү орж байгаа үед судалгаа шинжилгээний ажлын

түвшинг шинэ шатанд гаргаж хохирогч судлал, зах зээлийн /хулгайн гэмт хэргээс олсон эд зүйлс/ эрэлтийн судалгаа болон бусад судалгааг хийж гүйцэтгэн гэмт хэргийн нөхцөл байдлыг үнэн зөв тогтоож дүн шинжилгээ хийн, хэтийн төлөв хандлагыг судалж, цаашдын ажил, бодлого боловсруулахад ашиглаж сурах хэрэгтэй байна.

Гэмт хэрэг түүний дотор хулгайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг ЦБ, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх албадын тус бүрийн болон ерөнхий бодлого боловсруулж

-төрийн хэмжээнд шийдэх

-ЗГ-ын яам, агентлагын хэмжээнд шийдэх

-хот аймаг, дүүргийн хэмжээнд шийдэх гэх мэт тодорхой зааж өгч энэ асуудлыг шийдэхгүй бол хохирогч нь нэр томъёондоо тааруулж хохироод дуусч байна.

Гэмт хэргийн патентын судалгаа хийх шаардлага байна. Хулгайн гэмт хэрэг үйлдэгчдийг бүрэн хяналтанд авах арга хэмжээ боловсруулж улсын, хот аймгийн, шүүх прокурор, ШШГБ, ЦБ-ын түвшинд хэрэгжүүлэх шатлалыг тогтоох. Үүнд техник технологи ашиглах, хүн хүчийг зөв төвлөрүүлэх, орон тоо бүтцийг зөв зохистой болгож ажиллах зэрэг шаардлага гарч ирж байна.

Мөрдөгч /МБ, ХБ, төлөөлөгч/-хэсгийн байцаагч нарын хулгайн гэмт хэрэг дээр хийх ажлыг нэг бүрчлэн зааж гарын авлага, зөвлөмж, сургалт явуулах. Үүнд: Хохирогчийн ямар зүйлийг заавал тодруулах , хэргийн газар хийх ажлууд, дэс дараалал хэрэг дээр зохиох ажил, эрэн сурвалжлалт гэх мэт

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүх, харьяаллын оргосон сэжигтэн, яллагдагч, ялтан, ор сураггүй алга болсон хүн, цогцос, хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис түүхийн үнэт зүйлс, мөнгө, эд зүйлсийг эрэн сурвалжлах ажлыг чанаржуулахын тулд компьютерийн мэдээллийн сүлжээг өндөр түвшинд хүргэж практикийн ажилтнуудад /ХБ, МБ, төлөөлөгч нарт/ эзэмшүүлэн үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.



Б.ХИШИГТОГТОХ
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх албаны тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, цагдаагийн дэд хурандаа

ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОХ ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн ойлголт мөн чанарын тухай асуудлыг авч үзэхийн өмнө гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын тухай суурь ойлголт, томьёололыг тайлбарлах шаардлагатай юм.

Ер нь эрүүгийн эрх зүйн онол-арга зүйн ном-зохиолд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг нэн ялангуяа сүүлийн жилүүдэд дараахь байдлаар томъёолж ирсэн байдаг. Тухайлбал “Тодорхой этгээдийн өөртөө байгаа эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа”, “Хууль хэрэгжүүлж байгаа ажиллагаа”, “Мэргэжлийн эрх үүргээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа” гэх зэргээр бичиж байна[1].

Гэвч бидний үзэж байгаагаар дурьдсан нөхцөл байдлуудыг нэгэн нэр томъёотой болгох буюу “хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх” гэж томъёолох нь зохистой мэт санагдана. Яагаад гэвэл тухайн этгээд хууль ёсоор өөрт нь олгогдсон (үүрэг болгосон) эрхээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэхдээ эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан эрх ашигт хохирол учруулдаг бөгөөд түүнтэй холбоо бүхий мэргэжлийнхээ чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ч гэсэн зөвхөн хуульд заасан үндэслэлийг гол болгодог ба тэрхүү үйл явцыг зохицуулах журмыг гагцхүү хуулинд тодорхойлон заасан байдаг тул уг үйл явцыг хэрэгжүүлж байгаа буюу зохицуулж байгаа үйл ажиллагаа нь зөвхөн хууль ёсны эрхтэй байдаг тул уг үйлдэл нь үндэслэл, мөн чанарын хувьд үнэхээр хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа байдаг, байх ёстой. Иймд энэ үйл явцыг судлаач В.И.Михайлов нилээд үндэстэй, нарийвчлалтай тодорхойлсон байна. Тэрээр үзэхдээ “Өөрийн” эрхээ хэрэгжүүлэх гэдэг томъёолол нь илтэд ойлгомжгүй бөгөөд тухайн хүн “бусдын” эрхийг хэрэгжүүлэх боломжгүй харин гагцхүү тухайн хүн буюу тодорхой ажилтанд хууль ёсоор олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа юм [2] гэжээ. Өөрөөр хэлбэл уг ажиллагаа нь зөвхөн хувь хүнд, өөрт

[1] Курс советского уголовного права. М.1970, 400-р тал, С.Жанцан. “Монголын эрүүгийн эрх зүйн онол” УБ.2009, Ж.Болдбаатар, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги”, УБ.2010

[2] Михаилов.В.И. О социально-юридическом аспекте сүдержания обстоятельств исключающих преступность деяния .Государство и право, 1995, №12, 68-р тал

нь хамаарах зүйл биш харин үнэхээр хуулиар хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлж байгаа хууль ёсны ажиллагаа байдаг гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

Энэ дашрамд дурьдахад гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагааг хэрхэн хамааруулах, тэгэх ямар үндэслэл шалгуур байгаа болох уг асуудлыг холбогдох хууль тогтоомж нэн ялангуяа эрүүгийн хуульд хэрхэн тусгаж оруулах зэрэг асуудлыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны суурь судалгаа болгож цогц байдлаар нь авч үзсэн судалгаа болон эрүүгийн эрх зүйн ном, зохиол нилээд дутмаг бөгөөд ер нь энэ чиглэлийн эрдэм шинжилгээний чанартай бүтээл манай орны хувьд бараг байхгүй байна гэж хэлж болно.

Харин олон улсын хэмжээнд буюу онцолж дурьдвал ОХУ-ын эрүүгийн эрх зүйн нилээд судлаач эрдэмтэн өөрсдийн бүтээлдээ хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болох талаар тодорхой санал-дүгнэлт дэвшүүлжээ.

Тухайлбал С.Калина бичихдээ: хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа буюу тодруулбал хууль хэрэгжүүлж байгаа, мэргэжлийн үүргээ гүйцэтгэж байгаа, өөрийн бодит эрхээ гүйцэтгэж байгаа зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох онол-арга зүйн бүрэн үндэстэй юм[3] гэжээ.

Гэвч эрүүгийн эрх зүйгээс өөр бусад салбар эрх зүйд буюу тэдгээрийн холбогдох хууль тогтоомжид заасан хууль эрхээ хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагаануудыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлтэй эсэх нь нилээд маргаан дагуулж байгаа асуудал юм. Яагаад гэвэл иргэний эрх зүй ба захиргааны эрх зүйн тодорхой хэм хэмжээ-зохицуулалт нь өөрийн мөн чанарын хувьд тухайн болсон үйл явдлыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болж чадахгүй. Энэ тухай Н.И.Загородников бичихдээ: “Эрүүгийн эрх зүй дэх олон ойлголт, асуудал, иргэн, захиргааны болон бусад салбар эрх зүйн үндэслэлүүдтэй байдаг боловч чухамхүү эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх асуудлын тухайд гол үндэслэл нь эрүүгийн хууль тогтоомж байх учиртай” [4] гэжээ. Иймд эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашигт хохирол учруулсан асуудлыг үнэхээр эрүүгийн эрх зүйн үндсэн бодлого зарчмыг баримтлах ёстой гэдгийг дийлэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг болох нь

[3] Калина.С. Обстоятельства, искдючающие преступность деяния, понятие и виды. Уголовное право, 1999,№3, 7-р тал

[4] Загородников.Н.М. Советское угголовное право.М.1975, 100-101-р тал

тодорхой байгаа боловч сүүлийн үеийн эрүүгийн эрх зүйн чиглэлээр гарсан нилээд сурах бичиг, ном-зохиолд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох талаар огтхон ч дурьдахгүй байгаагийн дээр уг асуудалтай холбоотой олон зүйл маргаан дагуулсаар байгаа боловч уг асуудлыг эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулах ёстойг бүгд хүлээн зөвшөөрч байна. [5] Ингэснээрээ эрүүгийн эрх зүйн ихэнх эрдэмтэн-судлаачид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох ёстой гэдэгтэй дийлэнх нь санал нэгдэж байгаа юм. Тухайлбал, нэрт эрдэмтэн А.А.Пионтковский эрүүгийн эрх зүйн талаар туурвисан гол бүтээлүүддээ “Хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөртөө байгаа эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь хэдүйбээр гэмт хэргийн шинжийг илэрхийлж байгаа боловч тэр нь уг болсон үйл явдлын нийгмийн аюулыг үгүйсгэж буй нөхцөл байдал болж болох талтай” гэж аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын эрүүгийн эрх зүйн онол-арга зүйн суурь үндсийг тодорхойлсон байдаг.[6]

Гэвч аливаа гэмт үйл ажиллагаа нь “Хууль ёсны бус” зүйл болох нь нэн тодорхой тул түүнийг хэзээ ч хууль ёсны ажиллагаа гэж үзэхгүй бөгөөд харин тухайн хүнд тодорхой хуулинд заасан, бүр үүрэг болгож өгсөн бодитой үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар бусдад гэм хор, хохирол учруулж байгаа үйлдэл нь хэдүйбээр гэмт хэргийн шинжтэй боловч түүнийг хийхэд хүргэсэн нөхцөл байдал нь өөрөө нийгэмд аюултай байдаг боловч хууль ёсны үүргээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа нь мөн чанарын хувьд нийгэмд ашигтай тэгэхлээр тэр ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогддог гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй юм. Нөгөө талаар “хууль бус” зарим ажиллагаа, тухайлбал хууль бусаар үр хөндөх, бусдыг хууль бусаар хорих зэрэг үйлдлүүд нь тодорхой төрлийн гэмт хэрэгт тооцогддог бөгөөд иймэрхүү маягийн (төрлийн) “хууль бус” үйлдлүүд нь мөн чанар, үндэслэлийн хувьд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлаас огт өөр болох нь тодорхой.

---

[5] Уголовное право.Общая часть, И 1992, 200-р тал,

Уголовное право. Общая часть, И 1997, 178-р тал,

Рахманинова.Г.К, Осуществление лицом своего права как обстоятельство, исключающее преступность деяния, Автореф.дис.канд.юрид.наук. М 1994,

Уголовный закон. Опыт теоретического моделирования. Под.ред. В.И.Кудрявцева и С.Г.Калиной, М. 1987, 119-138-р тал,

Кадников.Н.Г, Обстоятельства, , исключающие преступность деяния / Н.Г.Кадников, М, 1998, 39-45-р тал

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гагцхүү эрүүгийн хуулинд заасан үндэслэлээр гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох нь онол-арга зүйн ба хууль цаазын бүрэн үндэстэй юм. Яагаад гэвэл тодорхой төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүн, ерөнхий болоод нарийвчилсан шинжийг гагцхүү эрүүгийн хуулинд тодорхойлон заадаг бөгөөд ийнхүү заасан тодорхой төрлийн гэмт хэргийг хийсэн үйл ажиллагаа нь ямагт гэмт хэрэгт тооцогдох бөгөөд “хууль ёсоор” бусдад гэм хор учруулах гэсэн ойлголт байж болохгүй. Харин эрүүгийн хуулинд урьдчилан, тодорхой, бодитой заасан үйл ажиллагаа нь хэдүйбээр гэмт хэргийн ерөнхий хэлбэр, мөн чанар, тэр ч байтугай бодит хохирлыг учруулсан байсан ч тэрхүү ажиллагаа нь эрүүгийн хуульд заасан үндэслэл, хэр хэмжээний дотор үйлдэгдсэн бол тэр нь гэмт хэрэгт тооцогдохгүй. Жишээлбэл: үнэхээр эрүүгийн хуулийн дагуу хийгдсэн аргагүй хамгаалалт нь бусдыг санаатай алсан ч гэмт хэрэгт тооцогддоггүй.

Харин эрүүгийн хуулиас өөр бусад хуулинд тодорхойлон заасан бодит үйл ажиллагааны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол тухайлбал зэвсэгт хүчний харуулын дүрэм болон хилийн албаны хуулинд тодорхойлон заасан зөрчил-бодит үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох эсэхийг маш нарийвчлан тодорхойлж хууль-эрх зүйн үндэслэлийг нь нэгэн мөр боловсруулах шаардлага амьдрал-практикт нэн тулгамдсан асуудал болоод байна. Энэ тухай В.Михайлов бичихдээ “зэвсэгт хүчний цагийн манаач тухайн харуулын объектод халдсан үйл ажиллагааг таслан зогсоох тэр ч байтугай галт зэвсэг хэрэглэх, тухайн “халдагчийг” шууд буудаж хөнөөх эрх, үүрэгтэй бөгөөд түүнийг зэвсэгт хүчний холбогдох дүрэмд (харуулын албаны дүрэм) тодорхой заасан байдаг тул тэрхүү бодит үйл ажиллагааг эрүүгийн хуулийн холбогдох заалт тухайлбал аргагүй хамгаалалтын хэм хэмжээг үндэслэл болгохгүйгээр эрх ёсны буюу хууль ёсны үйл ажиллагаанд тооцох боломжгүй юм”[7] гэжээ. Дээр дурьдсан бодит үйл явдал буюу “хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа” тодорхой үйлдэл цагдаагийн байгууллагын ажилтнуудад ч гэсэн шууд хамаарч болох талтай бөгөөд иймэрхүү санал-дүгнэлтийг Е.А.Галактионов, А.И.Каплунов нарын зэрэг судлаачид өөрсдийн зарим бүтээлдээ дэвшүүлсэн байна.[8]

[6] Курс советского уголовного право, М.1970, 400-р тал

[7] Михаилов.В, Выполнение профессиональных функцы, как обстоятельство, исключяающее преступность деяния /В.Михаилов.// Уголовное право, 2002, №2, 51-р тал.

[8] Галактионов,Е.А. Проблемы правового регулирования сотрудникими государственных военизированных организаций огнестрельного оружия/

Харин манай улсын хувьд энэ чиглэлээр дагнасан судалгаа, тодорхой дэвшүүлсэн санал-дүгнэлт одоохондоо хараахан гараагүй байна гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Гэтэл манай хойд хөрш ОХУ-ын шүүх-мөрдөн байцаах ажлын практикт үндэслэл болсон шүүхийн, бүр ОХУ-ын Дээд шүүхийн тогтоол хүртэл нэгэнтээ батлагдан гарч практикт мөрдөгдөж байна. Тухайлбал 1984 оны 8-р сарын 16-нд гарсан ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоолд “Нийгэмд аюултай халдлагыг таслан зогсоох болон хэв журам зөрчиж буй тодорхой гэмт этгээдүүдийг баривчлах, албадан саатуулах зорилгоор явуулж буй хууль сахиулагч байгууллагуудын ажилтнууд ба цэрэгжүүлсэн харуул хамгаалалтын ажилтнуудын эрх ашгийг хамгаалан зохицуулахдаа хуулийн заалтыг ягштал сахин биелүүлэхийн хамтад дээр дурьдсан хүмүүс хэв журам сахиулах талаар холбогдох эрх зүйн актад дурьдсан журам, төрөлжсөн дүрмийн заалтад тодорхойлон заасан бодит үндэслэл хэр хэмжээний дагуу зөрчил гаргагч гэмт этгээдүүд ба довтлогч этгээдүүдийн үйлдлийг таслан зогсоох болон тэдгээрийг баривчлах ажиллагаандаа галт зэвсэг болон хүч хэрэглэсэн нь хууль ёсны ажиллагаа байвал тэдгээрийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлтэй”[9] гэж заасан байдаг.

Аливаа шинжлэх ухааны судлагдахуун болж буй ойлголт, юмс үзэгдлийн мөн чанарыг тодорхойлно гэдэг нь юуны өмнө уг асуудлын үндсэн буюу шийдвэрлэх шинжүүдийг нь гаргаж ирэх, тогтоох явдал байдаг тул хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны түгээмэл буюу нийтлэг шинж нь гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдлын шинжүүдтэй нийцэж байх ёстой гэж үзэж байна.

Иймд гэмт хэргийг үгүйсгэж байгаа нөхцөл байдал нь обьектив ба субьектив шинжүүдтэй байдаг нь ойлгомжтой.

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын обьектив шинж нь:

а) Тэдгээр нөхцөл байдлыг ямар нэг хуулийн хэм хэмжээгээр урьдчилан тодорхойлж зааж өгсөн байдаг;

б) Тухайн үйл явдлууд нь эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хор хохирол учруулсан байдаг;

в) Тухайн үйлдэл нь хуулинд урьдчилан заасан хэмжээ хязгаар буюу тодорхой журмыг зөрчсөн байдгаараа мөн чанарын хувьд хуулиар хамгаалж байгаа обьектод хохирол учруулдаг;

Е.А.Галактионов, А.И.Каплунов// Правоведение, 1996, №4, 11-р тал

[9] Сборник постановлений Плениум Верховных судов СССР и РСФСР (Российский Федераций) по уголовным делам. М,2000, 191-р тал

г) Эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хохирол учруулсан бодит үйлдлийн эсрэг хийсэн үйл ажиллагаа байдаг тул ямагт нийгэмд ашигтай байдаг зэрэг нь обьектив шинжид хамаарч болох талтай.

Харин субьектив шинж тэмдэг нь гэвэл:

а) Уг үйл ажиллагааг хийж байгаа этгээд нь хэрэг хариуцах чадвартай;

б) Уг этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн байдаг;

в) Түүний хийж байгаа үйл ажиллагаа нь ямагт мөн чанарын хувьд нийгэмд ашигтай байдаг тул зорилго сэдэлт нь мөн нийгэмд ашигтай байдаг зэрэг болно. Энэ тухай Ю.В.Керимов “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд” (М.1972) гэдэг бүтээлдээ дээрх обьектив болон субьектив шинжүүдийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нарийвчилсан судалгаа, онол-арга зүйн үндэслэлтэйгээр тодорхойлон бичсэн билээ.

Иймд дээр дурьдсан шинж тэмдгүүдийг нэгтгэн дүгнэж тэдгээрийн бодит мөн чанарыг тодорхой бүтэц, ангилалд оруулж бичвэл:

Нэгдүгээрт: Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал нь юуны өмнө холбогдох хуулийн хэм хэмжээгээр зохицуулагдах шаардлагатай байдаг тул энэ шинжийг нь “тодорхой хэм хэмжээгээр зохицуулагддаг” мөн чанар гэж томьёолж болох талтай. Энэ тухай И.Ребане бичихдээ: “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг түүний зохицуулалтынх нь мөн чанарыг үндэслэж хоёр үндсэн бүлэгт хуваан үзэж болох юм. Тухайлбал:

1) Эрүүгийн хуулинд урьдчилан тодорхойлж заасан нөхцөл байдлууд.

2) Холбогдох өөр хуулинд урьдчилан заасан нөхцөл байдлууд гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваж болно.”[10] гэжээ.

Гэвч бидний үзэж байгаагаар дээр дурдсан ангилалд 3 дахь хэсэг буюу эрүүгийн хууль тогтоомж ба өөр бусад салбар эрх зүйн холбогдох хууль тогтоомжид урьдчилан заасан нөхцөл байдлуудыг зайлшгүй хамааруулан үзэх шаардлагатай юм. Энэ хэсэгт багтаж байгаа нөхцөл байдлууд нь практикт үндсэн 3 хэлбэрээр илэрч байна гэж үзэж болох үндэстэй. Үүнд:

1. Эрүүгийн хууль тогтоомж буюу улмаар үндсэн хуулиар хамгаалсан харилцаанд хор хохирол учруулж байгаа үйл ажиллагаа, тухайлбал ах дүү төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзаж байгаа үйлдэл нь мөн чанарын хувьд үндсэн хууль буюу эрүүгийн хуулиар хамгаалж

[10] Ребане.И. Обстоятельства, исключающие общественную опасность / И.Ребане // советское угголовное право. Общее учение о преступление, -Тарту, 1983.Ч,3.-сб

байгаа харилцааны эсрэг шинжтэй байдаг. (Үндсэн хуулийн 14 дэх заалт)

2. Эрүүгийн хуулиар хамгаалан зохицуулж байгаа нийгмийн харилцаанд хохирол учруулж байгаа үйл ажиллагаа, тухайлбал аливаа этгээд өөрийнхөө гэргий, нөхөр болон ойрын төрөл садныхаа үйлдсэн гэмт хэргийг үл мэдээлэх буюу нуун дарагдуулах нь хүний ёсны мөн чанараас урган гардаг зүйл учир энэ нь хэдийгээр эрүүгийн хуулинд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг мөн боловч уг үйл ажиллагааг хэрвээ холбогдох хуулинд урьдчилан зохицуулах талаар тодорхой заасан байвал түүнийг гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд хамааруулан үзэж болох талтай боловч энэ нь манай улсын холбогдох ямарваа хуульд огтхон ч заагаагүй тул шууд утгаар нь практикт хэрэгжүүлэх боломжгүй байна. Харин олон улсын эрүүгийн эрх зүйд буюу тухайлбал ОХУ-ын эрүүгийн хуулийн тусгай ангийн 316-р зүйлд: хэн нэг хүн эхнэр, нөхрийнхөө буюу ойрын ах дүүгийнхээ үйлдсэн хэргийг нуун дарагдуулах эрхтэй гэдгийг шууд тодорхойлон заасан бөгөөд уг үйл ажиллагааг ямагт хөнгөрүүлж үздэг байна.

Хоёрдугаарт: Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал нь мөн чанарын хувьд нийгэмд ашигтай бөгөөд ямагт бодит үйл ажиллагаа байдаг тул хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй үйл явдал нь ухамсарт, тухайн хүний сэтгэл зоригийн дагуу болдог зүйл боловч уг үйл ажиллагааг хийхэд хүргэж байгаа үндэслэл, нөхцөл нь ямагт гадны буюу хөндлөнгийн нөлөөлөлтэй байдгаараа онцлогтой бөгөөд харин бусдын биеийн хүчинд автагдсан буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас уг ажиллагааг хийсэн байвал тэр нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэлд тооцогдохгүй болох талтай гэдгийг анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл дурьдаж буй энэхүү тодорхой тохиолдол нь албаны үүрэгт ажиллагаатай холбоогүй харин хувийн шинжтэй байж болдгоороо онцлогтой. Нөгөө талаар давагдашгүй хүчин зүйлд автах гэдэг нь тэр болгон тухайн хүний албаны үүрэгт буюу хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаатай холбогдоогүй байж болох талтай. Учир нь давагдашгүй хүчин зүйл нь байгалийн үзэгдэл, адгуус амьтны довтолгоо гэх мэт янз бүрийн хүчин зүйлтэй холбогдож гардаг тул түүний эсрэг хийж байгаа үйл ажиллагаа нь уг этгээдийн санаа зоригоос тэр болгон хамаардаггүй.

Цаашилбал биеийн хүчин зүйлд автагдана гэдэг нь тухайн нөхцөлд уг этгээдийн санаа бодол, сэтгэл зоригоос тэр болгон шалтгаалдаггүй гэдэг нь тодорхой тул ийм нөхцөлд хийж байгаа үйл

ажиллагааны хууль-эрх зүйн мөн чанар, үндэслэлийг тэр болгон тодорхойлох, тооцох боломжгүй байдаг.

Иймд тухайн болж байгаа үйл явдал, нөхцөл байдлыг ухааран ойлгох, ухамсарлах боломжгүй нөхцөлд хийсэн үйл ажиллагааг тэр болгон хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа нөхцөл байдалд хамааруулж үзэх боломжгүй юм.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд заавал байвал зохих бодит шинжийн нэг нь тухайн үйлдэл нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулж байгаа явдал байдаг тул уг үйл ажиллагаа нь гол төлөв ямар нэг гэмт хэргийн шинж тэмдгийг өөртөө агуулж байгаагаараа онцлогтой. Энэ тухай П.Яни бичихдээ: “Хуулинд урьдчилан заасан үндсэн нөхцөл, хэр хэмжээний дотор ялангуяа тодорхой тогтоосон журмыг ягштал баримталсан үйл ажиллагаа нь тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг өөртөө агуулж байгаа ч гэсэн уг үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй”[11] гэжээ. Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болохын хувьд уг болсон бодит үйл явдал нь ямарваа гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн буюу хэлбэрийн төдий байдлаар илтгэн харуулж байдаг нь түүнд заавал байвал зохих бодит шинж юм. Энэ мөн чанарыг бүрэн дүүрэн тодорхойлон тогтоохын тулд уг үйл явдлын зөвхөн үйлдлийнх нь буюу биеийн хүчин чадлын шинжийг төдийгүй хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа хамгийн гол амин шинж болох нийгэмд ашигтай социал мөн чанарыг нь онцгойлон нээж харуулах шаардлагатай юм. Чухам энэхүү мөн чанарын талаар В.И.Михайлов нилээд нарийвчлалтай, оновчтой бичсэн байдаг. Тэрээр бичихдээ: “Тухайн болсон үйл явдал нь хэдүйбээр бодитой хор хохирол учруулсан ч гэсэн зохих үндэслэл байвал эрх ёсны буюу хууль ёсны үйл ажиллагаанд тооцогдох боловч харин түүний хор хохиролтой, аюултай мөн чанар нь огтхон ч өөрчлөгдөхгүй. Өөрөөр хэлбэл уг болсон үйл явдал нь хэдийгээр хууль ёсны ажиллагаа байдаг боловч түүний нийгмийн мөн чанар нь ялангуяа “аюултай” шинж нь социал үнэлгээний хувьд өөрийнхөө мөн чанарыг огтхон ч өөрчилдөггүй”[12] гэжээ.

Үүнээс үзвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл

[11] Яни.П. Крайная необходимость:непреступный вред экономичиского преступления П.Яни // Закон-2000,№7, 48-р тал.

[12] Михайлов, В.И. Нормативное регулирование правомерного вреда в сфере предпринимательства /В.И.Михайлов // Закон, -2000, №7, 36-р тал.

ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцох үндэслэл нь тэрхүү үйл явдал эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хохирол учруулж байгаа ухамсартай буюу тухайн этгээдийн сэтгэл-зоригийн дагуу болдог санаатай, бодитой үйл ажиллагаа байдагт оршино. Нөгөө талаар энэхүү үйл ажиллагаа нь хуулинд урьдчилан заасан хэр хэмжээ, үндэслэлийн дагуу болсон байх учиртай бөгөөд энэ нь уг үйл явдлын бас нэгэн бодит шинж болох ёстойг онцгой анхаарах хэрэгтэй юм.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, тохиолдол бүрийн хууль ёсны хэр хэмжээ, нэн ялангуяа хуулинд урьдчилан тодорхойлон заасан бодит үндэслэл, шинж болон уг үйл ажиллагааг хийх талаар тогтоосон журмын заалт бүрийг тал бүрээс нь, бүрэн дүүрэн, бодитой “ягштал” тогтоох шаардлагатай гэдгийг онцгой анхаарвал зохилтой.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох өөр нэгэн онцгой, бие даасан, бодитой шинж буюу үзэгдэл нь уг үйл ажиллагаа нь өөрийн мөн чанарын хувьд нийгэмд ашигтай буюу түүнийг (уг болсон бодит явдлыг) олон нийтийн зүгээс зайлшгүй хүлээн зөвшөөрдөгт оршдог. Яагаад гэвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэл нь ямагт нийгмийн ашиг сонирхолыг хамгаалахын тулд зайлшгүй хийж байгаа буюу хийхэд хүргэж байгаа үйл ажиллагаа байдаг. Энэ нь зөвхөн нийгмийн эрх ашиг төдийгүй хувийн эрх ашгийг ч гэсэн хамгаалах зорилготой байж болохыг үгүйсгэх аргагүй. Энэ тухай С.И.Никулин бичихдээ: “Хувийн эрх ашгийг хамгаалах явдал нь улсын ба нийгмийн эрх ашгийг хамгаалахтай эн зэрэгцэхүйц үйл явдал тул хувийн эрх ашгийг хамгаалах нь эрүүгийн хууль тогтоомжийн бас нэгэн үндсэн зорилт мөн” [13] гэжээ. Ийнхүү эрүүгийн хуульд тодорхой этгээдийн хувийн буюу “амины” эрх ашгийг хамгаалдаг төдийгүй түүнийг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг тохиолдлын нэг нь тухайн этгээд ойрын ах дүү, төрөл садан болон эхнэр, нөхрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх хууль ёсны бодит эрхтэй байдаг явдал юм. Энэ нь өөр бусад салбар эрх зүйн хувьд ч гэсэн мөн нэгэн адил хамаардаг. Гэвч бусад салбар эрх зүйгээр зохицуулагддаг тодорхой үйл явдлууд нь нийгэмд ашигтай байх буюу олон нийтийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх түвшингийн хувьд харилцан адилгүй янз бүр байдаг нь тодорхой. Иймд тухайн үйл ажиллагаануудыг зохицуулах эрх

[13] Никулин, С.И. Угголовный закон и частный интерес. / С.И.Никулин, М, 1994, 10-р тал. Мғн Кудрявцев, В.Н. Право и поведение / В.Н.Кудрявцев, -М, 1978, 40-р тал.

зүйн хэм хэмжээнүүд нь өөрийн мөн чанарын хувьд мөн харилцан адилгүй өөр өөр байдаг ажээ. Өөрөөр хэлбэл тэдгээр зохицуулалт нь бас обьектив ба субьектив шинжтэй байх нь ойлгомжтой. Энэ тухай Ю.В.Баулин бичихдээ: "Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал нь мөн чанарын хувьд янз бүр байх бөгөөд уг үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжийг зөвхөн хэлбэрийн төдийгөөр үл барам зарим шинж нь тухайлбал субьектын нас, хэрэг хариуцах чадвартай байх зэргээрээ бүгд ижилхэн байдаг"[14] гэжээ. Тэр ч байтугай хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь тодорхой нөхцөл байдалд заавал тусгай субьекттэй байх тохиолдол ч гарч болно. Тухайлбал цагдаагийн ажилтан тодорхой гэмт хэрэгтний үйлдлийг газар дээр нь таслан зогсоох, баривчлахдаа галт зэвсэг хэрэглэсэн тохиолдлыг шалгахад юуны өмнө тухайн ажилтан албан үүргийн хувьд галт зэвсгийг хэрэглэх эрх, үүрэгтэй эсэх, тийнхүү хэрэглэсэн ажиллагаа нь холбогдох тусгай дүрэм, тушаал, заавар, журмын тодорхой заалтыг биелүүлсэн буюу "ягштал" баримталсан эсэх зэргийг нарийвчлан тогтоох шаардлага гарч ирдэг. Энэ нь гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдал нь зөвхөн ерөнхий шинж, үндэслэлтэй байдаг төдийгүй тухайн үйлдэл, тохиолдол бүрт хамаарах нарийвчилсан үндэслэл, шалгууртай байдаг буюу байх ёстой гэдгийг илтгэн харуулж байна.

Дээр дурьдсанаас үндэслэн дүгнэвэл хууль ёсны үүргээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болохын хувьд дараахь үндсэн, бодит шинжүүдтэй гэж үзэж болох талтай байна.

Үүнд:

1. Уг үйл явдал нь "хэм хэмжээт" буюу заавал урьдчилан тогтоож өгсөн журмаар зохицуулагддаг;

2. Уг нөхцөл байдлууд нь эрүүгийн хуулиар хамгаалсан нийгмийн харилцаанд хор хохирол заавал учруулдаг тул түүнийг хийж буй этгээдийн үйлдлийн обьектив ба субьектив шинжийг, нэн ялангуяа эрүүгийн хуулинд урьдчилан тодорхойлон заасан байх;

3. Уг үйл ажиллагаа нь хуулинд урьдчилан заасан үндэслэл, хэр хэмжээний дотор болсон байх;

4. Уг үйл ажиллагаа нь эрүүгийн хуулиар хамгаалсан харилцаанд хор хохирол учруулсан байдаг боловч өөрийн мөн чанарын хувьд нийгэмд ашигтай байдаг;

5. Уг үйл ажиллагааг хийж байгаа этгээд нь хэрэг хариуцах чадвартай, хуулинд заасан насанд хүрсэн байх гэх зэрэг субьектив шинжүүдтэй байх болно. Гэвч энэ нь

[14] Баулин,Ю.В. Обьстоятельства, мсключающие престутность деяния / Ю.В. Баулин. Харьков, 1991, 24-р тал.

бүрэн дүүрэн тогтоож тодорхойлсон шинжүүд биш болох нь ойлгомжтой бөгөөд уг асуудлыг цаашид эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн үүднээс улам нарийвчлан судлах нь дамжиггүй юм.